



Food and Agriculture  
Organization of the  
United Nations



Олон Улсын  
Хөдөлмөрийн  
Байгууллага



# ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ШИНЖИЛГЭЭ

МОНГОЛ УЛСАД ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГОТОЙ  
УЯЛДСАН ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТӨӨР ХӨДӨЛМӨР  
ЭРХЛЭЛТИЙН ШИНЭЧЛЭЛИЙГ ДЭМЖИХ НЬ ТӨСӨЛ








# ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ШИНЖИЛГЭЭ



Европын Холбооны санхүүжилттэй “Монгол Улсад Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төсөл



Энэхүү Төсвийн зарлагын шинжилгээг Европын холбооноос Монгол Улсын Засгийн газарт үзүүлж буй төсвийн дэмжлэгийн бүрэлдэхүүн “Монгол Улсад Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” техник туслалцааны төслийн хүрээнд боловсруулав.

**Ерөнхий зүйл:**

Энэхүү тайлан нь Европын холбоо (ЕХ)-ны санхүүжилтээр хэвлэгдсэн болно. Тайлангийн агуулга зөвхөн зохиогчдын үзэл бодлыг илэрхийлж байгаа бөгөөд ЕХ болон НҮБХХ-ийн албан ёсны бодлого, байр суурийг илэрхийлээгүй. ЕХ, НҮБХХ энэхүү тайланд гарсан тоо баримтын үнэн зөв эсэхийг баталгаажуулахгүй бөгөөд тоо баримтыг ашигласнаар гарах үр дагаварыг хариуцахгүй. НҮБХХ-ийг тодорхой дурдсан тохиолдолд хувийн болон ашгийн бус зорилгоор энэхүү бүтээлээс иш татаж буюу хэсэгчлэн хуулбарлан ашиглаж болно. НҮБХХ-ийн зөвшөөрөлгүйгээр энэхүү хэвлэлийг худалдах, дахин хэвлэх, эсвэл ямар нэгэн ашиг олох хэрэгсэл болгохыг хориглоно.

© 2021 United Nations Development Programme.  
Зохиогчийн бүх эрхийг хамгаалсан.

**Боловсруулсан:** Төсөв, санхүүгийн зөвлөх Б.ГАНБОЛД

## ӨМНӨХ ҮГ

Монгол улсад Европын Холбооноос үзүүлж буй хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлд зориулсан төсвийн дэмжлэгийн хүрээнд Техникийн туслалцааны төсөл хэрэгжүүлж байна.

Энэ төслийн бүрэлдэхүүн хэсэг болох “Монгол улсад ТХЗ-той уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төслөөс Монгол улсад үр дүнд суурилсан төсвийн төлөвлөлт, төсвийн дунд хугацааны зарлагын хүрээг нэвтрүүлэх ажлын хүрээнд Хөдөлмөрийн болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт Тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдсан, нотолгоо, үр дүнд суурилсан төсөв боловсруулах ажлыг 2021 оноос туршилтын журмаар эхлүүлээд байна. Олон улсын туршлагаас харахад төсөв, санхүүгийн удирдлагыг сайжруулах, улсын төсвийн зарлагын үр ашиг, үр нөлөөг дээшлүүлэхэд төсвийн зарцуулалтын судалгаа (Төсвийн зарлагын шинжилгээ) чухал үүрэг гүйцэтгэж байна. Мөн төсвийн зарлагын шинжилгээ нь нотолгоо, үр дүнд суурилсан төсвийн төлөвлөлтийн чухал бүрэлдэхүүн хэсэг болно.

Дээрх төслийн хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын төсвийн зарлагын шинжилгээг анх удаа хийж, хэвлүүлэн гаргаж та бүхэнд хүргүүлж байна. Энэхүү төсвийн зарлагын шинжилгээг төслийн зөвлөх Б.Ганболд салбарын холбогдох тоо мэдээлэл, баримтад тулгуурлан хийсэн бөгөөд цаашид жил бүр тоо мэдээг шинэчлэн, сайжруулж тогтмол гаргаж төсвийн төлөвлөлтөд ашиглахаар төлөвлөж байна. Төсвийн зарлагын шинжилгээ нь салбарын бодлого ба төсвийн уялдаа, хяналт-шинжилгээ үнэлгээ, тайлагнал, ил тод байдлыг хангахад мөн чухал ач холбогдолтой судалгаа болж байна.

ХҮНДЭТГЭСЭН,

Б.ОТГОНЦЭЦЭГ  
ХХААХҮЯ-НЫ САНХҮҮ, ХӨРӨНГӨ  
ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА

## АГУУЛГА

Өмнөх үг .....	3
Товчилсон үгсийн жагсаалт .....	9
Хураангуй .....	10
<b>1. ХХААХҮ-ийн салбарын өнөөгийн байдал, эдийн засагт эзлэх байр суурь.....</b>	<b>12</b>
1.1 Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны эрхлэх асуудлын хүрээ .....	12
1.2 Салбарын эдийн засагт эзлэх байр суурь .....	12
1.3 Хөдөө аж ахуй .....	16
1.3.1 Мал аж ахуй .....	16
1.3.2 Газар тариалан .....	18
1.4 Хүнсний үйлдвэрлэлийн салбар .....	21
1.5 Хөнгөн үйлдвэрийн салбар .....	23
<b>2. Салбарын бодлогын тэргүүлэх чиглэлийн зорилтууд .....</b>	<b>26</b>
2.1 Салбарын бодлогын тэргүүлэх чиглэлүүд.....	26
2.2 Тогтвортой хөгжлийн зорилтууд ба салбарын дунд хугацааны бодлогын зорилтын уялдаа.....	33
<b>3. Салбарын төсвийн зарлагын өнөөгийн байдал, хандлага .....</b>	<b>41</b>
3.1 Салбарын төсвийн нийт зарлагын түвшин, хандлага .....	41
3.2 Салбарын төсвийн зарлагын бүтэц.....	45
3.2.1 Төсвийн зарлагын бүтэц, эдийн засгийн ангиллаар .....	57
3.2.2 Салбарын төсвийн зарлага, хөтөлбөрөөр .....	58
3.2.3 Салбарын төсвийн зарлага, зориулалтаар .....	70
3.2.4 Салбарын төсвийн зарлага, улсын болон орон нутгийн шатлалаар .....	71
3.2.5 Салбарын зээл, тусламжийн төслүүдийн хэрэгжилт.....	80
3.2.6 Зээл тусламжийн эх үүсвэр, төлөвлөсөн санхүүжилт.....	89
3.3 Төсвийн зарлагын гүйцэтгэл .....	90
3.4 ХХААХҮ-ийн сайдын хэрэгжүүлэх хөтөлбөрүүдийн үр дүнгийн үзүүлэлтийн гүйцэтгэл.....	91
3.5 Салбарын төсвийн үр ашгийн шинжилгээ .....	94
<b>4. Санал, дүгнэлт.....</b>	<b>97</b>
<b>5. Хавсралт .....</b>	<b>103</b>
<b>6. Ном зүй .....</b>	<b>107</b>



## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.	Салбарын яамны нэр, эрхлэх асуудлын хүрээнд орсон өөрчлөлт.....	12
Хүснэгт 2.	ХХААХҮ-ийн салбарын үндсэн үзүүлэлтүүд.....	13
Хүснэгт 3.	ХХААХҮ-ийн салбарын бүтэц /Салбарын нийт дүнд эзлэх хувиар/ .....	15
Хүснэгт 4.	Газар тариалангийн бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэл ба нийт нийтлүүлэлтийн харьцаа, хувиар .....	21
Хүснэгт 5.	Нийт тариалсан талбайд усалгаатай талбайн эзлэх хувь.....	21
Хүснэгт 6.	Хөнгөн үйлдвэрийн нийт үйлдвэрлэл, оны үнээр, эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангиллаар, сая төгрөгөөр .....	24
Хүснэгт 7.	ХХААХҮ-ийн салбарын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөний тэргүүлэх чиглэлийн зорилтууд .....	27
Хүснэгт 8.	ХХААХҮ-ийн салбарын стратеги төлөвлөгөө ба ТЕЗ-ийн 2021 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн уялдаа .....	30
Хүснэгт 9.	Төсвийн тухай хуулийн 1-р хавсралт буюу ХХААХҮ-ийн сайдын хэрэгжүүлэх төсвийн хөтөлбөрийн үр дүнгийн үзүүлэлтүүд .....	30
Хүснэгт 10.	Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний төсвийн төлөвлөлт болон бодлогын зорилтын уялдаа /2021 оны төсвийн саналын жишээгээр/ .....	32
Хүснэгт 11.	Тогтвортой хөгжлийн зорилго, зорилтууд .....	33
Хүснэгт 12.	Тогтвортой хөгжлийн зорилт болон манай орны бодлогын баримт бичгийн бүтэц, түүний уялдаа.....	34
Хүснэгт 13.	ХХААХҮЯ-ны бодлогын түвшинд хариуцах ТХЗ-ууд ба шалгуур үзүүлэлтүүд.....	34
Хүснэгт 15.	ХХААХҮ-ийн салбарын төсвийн зарлага, эдийн засгийн ангиллаар, сая төгрөгөөр.....	44
Хүснэгт 16.	Хөнгөн үйлдвэрийг хөгжүүлэх хөтөлбөрийн зардал ба салбарын төсвийн дүнд эзлэх хувь .....	65
Хүснэгт 17.	ЖДҮ-ийг хөгжүүлэх сангаас олгосон зээлийн мэдээлэл.....	67
Хүснэгт 18.	Орон нутгийн харъяа байгууллагуудын урсгал зардал .....	72
Хүснэгт 19.	Аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн газрын урсгал зардал /2019 он/.....	72
Хүснэгт 20.	Аймгуудын Хүнс, хөдөө аж ахуйн газрын урсгал зардлын бүтэц /2019/.....	74
Хүснэгт 21.	Малын генетик нөөцийн тухай хууль заасан зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, зардлын төрлөөр.....	75
Хүснэгт 22.	Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд Мал эмнэлгийн үйлчилгээний санхүүжилтийг заасан эх үүсвэр /улс, орон нутгийн төсөв/ .....	76
Хүснэгт 23.	ЗЗНДНТУТ хууль болон Төсвийн тухай хуулинд заасан орон нутгийн чиг үүргийн талаарх заалтууд.....	77

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН  
ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ШИНЖИЛГЭЭ**

Хүснэгт 24. Улсын болон орон нутгийн төсөв тусгагдсан ХХААХҮ-ийн салбарын төсвийн зардал (зориулалтаар, сая төгрөгөөр) .....	78
Хүснэгт 25. ХХААХҮ-ийн салбарын урсгал зардлын орон нутгийн төсвөөрх санхүүжилт .....	79
Хүснэгт 26. ХХААХҮ-ийн салбарт хэрэгжүүлсэн гадаадын зээл, тусламжийн дүн, тэрбум төгрөгөөр /2016-2020 он/ .....	80
Хүснэгт 27. МАА-н эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төслийн бүрэлдэхүүн хэсгүүд ..	82
Хүснэгт 28. Төслийн бүрэлдэхүүн хэсгүүдийн төлөвлөсөн санхүүжилтийн хуваарь (үр дүнгээр) .....	85
Хүснэгт 29. ХХААХҮ-ийн салбарт 2022 онд хэрэгжүүлэх гадаадын зээл, тусламжийн төсөл, хөтөлбөрүүдийн мэдээлэл /урьдчилсан мэдээлэл/ .....	89
Хүснэгт 30. Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлийн төлөвлөгөө ба гүйцэтгэл ....	91
Хүснэгт 31. ХХААХҮ-ийн сайдын хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийн биелэлт .....	92
Хүснэгт 32. Төсвийн эрх захирагчийн хэрэгжүүлсэн хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтийн биелэлт .....	93
Хүснэгт 33. ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын салбарын хөдөлмөрийн бүтээмж, 1 ажиллагчид ногдох төсвийн зарлага, мян.төгрөгөөр .....	94
Хүснэгт 34 .Ноосны урамшуулал, ноосон бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ .....	96





## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.	Монгол улсын ДНБ-ий бүтэц.....	14
Зураг 2.	ДНБ-д ХХААХҮ-ийн салбарын эзлэх хувь .....	15
Зураг 3	ДНБ-д МАА, газар тариалангийн дэд салбарын эзлэх хувь.....	16
Зураг 4.	МАА-н салбарын бодит өсөлт болон малын тооны өсөлт, бууралт.....	17
Зураг 5.	МАА-н салбарын гол нэр, төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл.....	17
Зураг 6.	Тариалсан талбайн хэмжээ, мян.га-аар .....	19
Зураг 7.	Хураасан ургацын хэмжээ, мянган тонноор.....	19
Зураг 8.	Га-гийн ургац, цн-ээр .....	20
Зураг 9.	Улс орнуудын 1 га-гаас хураан авсан буудайн ургацын хэмжээ /цн-ээр/ .....	20
Зураг 10.	Хүнсний гол нэр, төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, 1989-2019 .....	22
Зураг 11.	Хүнсний гол нэр төрлийн бүтээгдэхүүний импортын хамаарал /2019 оноор/.....	23
Зураг 12.	Хөнгөн үйлдвэрийн гол нэр, төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл /2015-2020/ .....	25
Зураг 13.	Дотоодын үйлдвэрт боловсруулсан малын гаралтай бүтээгдэхүүн. ....	25
Зураг 14.	Улс орнуудын төсвийн нийт зарлагад ХАА-ын салбарын төсвийн зарлагын эзлэх хувь.....	41
Зураг 15.	ХХААХҮ-ийн сайдын багцын төсвийн нийт зарлага /дүнд эзлэх хувиар/ .....	42
Зураг 16.	ХХААХҮ-ийн салбарын төсвийн нийт зарлага, түүний бүтэц /сая төгрөгөөр/.....	43
Зураг 17.	ХХААХҮ-ийн салбарын төсвийн нийт зарлагын бүтэц, сая төгрөгөөр.....	45
Зураг 18.	ХХААХҮ-ийн салбарын төсвийн зарлагын бүтэц, дүнд эзлэх хувиар.....	46
Зураг 19.	ХХААХҮ-ийн салбарын төсвийн урсгал зардал, эдийн засгийн ангиллаар, сая төгрөгөөр .....	47
Зураг 20.	Урсгал зардлын бүтэц, дүнд эзлэх хувиар.....	48
Зураг 21.	Бараа, үйлчилгээний зардлын бүтэц, дүнд эзлэх хувиар.....	48
Зураг 22.	ХАА-н урамшууллын хэмжээ, сая төгрөгөөр .....	49
Зураг 23.	ХХААХҮ-ийн салбарт улсын төсвөөс олгосон урамшуулал, хүүгийн татаасын хэмжээ, сая төгрөгөөр .....	54
Зураг 24.	ХХААХҮ-ийн салбарт олгосон нийт урамшуулал, хүүгийн татаасын салбарын төсөвт эзлэх хувь.....	55
Зураг 25.	ХХААХҮ-ийн салбарын төсвийн хөрөнгийн зардлын дүн ба түүний нийт зардалд эзлэх хувь .....	56
Зураг 26.	ХХААХҮ-ийн салбарын төсвийн хөрөнгийн зардлын бүтэц, дүнд эзлэх хувиар.....	57
Зураг 27.	ХХААХҮ-ийн салбарын төсвийн нийт зарлага, эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлийн хэмжээ болон түүний нийт зарлагад эзлэх хувь.....	58

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН  
ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ШИНЖИЛГЭЭ**

Зураг 28.	ХХААХҮ-ийн салбарын хөтөлбөрүүдийн урсгал зардал, сая төгрөгөөр.....	59
Зураг 29.	Мал аж ахуйг хөгжүүлэх хөтөлбөрийн зардал, түүний нийт салбарын төсвийн зарлагад эзлэх хувь.....	60
Зураг 30.	МАА-г хөгжүүлэх хөтөлбөрийн зардлын төрлүүд, түүний хэмжээ /тэрбум төгрөгөөр/ .....	61
Зураг 31.	Газар тариаланг хөгжүүлэх хөтөлбөрийн зардлын хэмжээ ба нийт салбарын төсөвт эзлэх хувь .....	62
Зураг 32.	Газар тариаланг хөгжүүлэх хөтөлбөрийн зардлын бүтэц.....	62
Зураг 33.	Хүнсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх хөтөлбөрийн зардлын хэмжээ болон салбарын төсөвт эзлэх хувь.....	64
Зураг 34.	Хүнсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх хөтөлбөрийн зардлын бүтэц.....	64
Зураг 35.	ЖДҮ, үйлчилгээ, хоршоог дэмжих хөтөлбөрийн зардал, түүний салбарын төсвийн нийт зарлагад эзлэх хувь.....	66
Зураг 36.	ХАА, газар тариалан, аж үйлдвэрийн бодлого, удирдлагын зардал, түүний салбарын төсвийн нийт зардалд эзлэх хувь.....	68
Зураг 37.	ХХААХҮЯ, түүний харъяа байгууллагуудын урсгал зардлын дүн, сая төгрөгөөр.....	69
Зураг 38.	ХХААХҮ-ийн салбарын 2021 оны батлагдсан төсөв, зориулалтаар /сая төгрөгөөр/ .....	70
Зураг 39.	Мал эмнэлгийн үйлчилгээ, оношлогоо, судалгааны зардлын бүтэц /2021 оны батлагдсан төсөв, сая төгрөгөөр.....	70
Зураг 40.	ХХААХҮ-ийн салбарын орон нутгийн байгууллагуудын зардал, түүний салбарын нийт төсвийн зардалд эзлэх хувь.....	71
Зураг 41.	Аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн газрын урсгал зардлын хэмжээ /2019 он/ .....	72
Зураг 42.	Аймгуудын Хүнс, хөдөө аж ахуйн газрын урсгал зардлын дүн /2019/ .....	74
Зураг 43.	ХХААХҮ-ийн салбарын төсвийн нийт зарлагын гүйцэтгэл, хувиар.....	90
Зураг 44.	Салбарын 1 ажиллагчид ногдох төсвийн зарлага ба хөдөлмөрийн бүтээмжийн хамаарал .....	94
Зураг 45.	Улаан буудайн урамшууллын хэмжээ ба урамшуулал олгосон ургац, нийт хураасан ургац, урамшуулалд хамрагдсан иргэдийн тооны хамаарал .....	95
Зураг 46.	Ноосны урамшуулал болон урамшуулалд хамрагдсан малчдын тоо, бэлтгэсэн нийлүүлсэн ноос, ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээний хамаарал .....	96
Зураг 47.	Арьс, ширний урамшууллын хэмжээ болон урамшууллаар бэлтгэсэн арьс, шир, урамшуулалд хамрагдсан малчдын тоо, үйлдвэрлэлийн хамаарал .....	97



## ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

ААН	Аж ахуйн нэгж
АНУ	Америкийн нэгдсэн улс
АХБ	Азийн хөгжлийн банк
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
ЖДҮ	Жижиг, дунд үйлдвэр
ЗБДС	Зээлийн батлан даалтын сан
ЖАЙКА	Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага
ЖДҮХБОХ	Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах
ЗГ	Засгийн газар
ЗГҮАХ	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр
ЗГҮАХХАХТ	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө
ЗЗНДНТУТ	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай
МАА	Мал аж ахуй
МУ	Монгол улс
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НӨС	Нэмүү өртгийн сүлжээ
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
НҮБХХ	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр
ОЕСД	Organization for Economic Cooperation and Development
СЯ	Сангийн яам
ТББ	Төрийн бус байгууллага
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨҮААТҮГ	Төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилт
УИХ	Улсын Их Хурал
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХХААБ	Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага
ХХААГ	Хүнс, хөдөө аж ахуйн газар
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ЭМЯ	Эрүүл Мэндийн Яам
ЯБЯС	Ядуурлыг бууруулах Японы сан
ЯОУХАБ	Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Банк

## ХУРААНГУЙ

ХХААХҮ-ийн салбар нь 2020 оны байдлаар Монгол улсын ДНБ-ний 32.5 хувийг, нийт экспортын 5.6 хувийг, нийт ажиллагсадын 50 гаруй хувийг тус тус бүрдүүлж байна. Сүүлийн 10 жилийн хандлагаас харахад ХХААХҮ-ийн салбарын нийт эдийн засагт болон экспортод эзлэх хувь төдийлөн өөрчлөгдөөгүй байна.

ХХААХҮ-ийн салбар нь 1995 онд нийт ДНБ-ий 59.6 хувь, 2000 онд 44.5 хувийг бүрдүүлж байсан бол 2000 оноос аажмаар буурч сүүлийн 15 жилд ДНБ-ий 31-33 хувь буюу нийт эдийн засгийн гуравны нэгийг бүрдүүлж байна. Уул уурхай, олборлох үйлдвэрлэлийн салбарт 2000 оноос хойш гадаад, дотоодын хөрөнгө оруулалт мэдэгдэхүйц нэмэгдэж, Монгол улсын эдийн засагт чухал хувь нэмэр оруулах болсон болон үйлчилгээний салбар тэлсэнээр ДНБ-ий бүтэц өөрчлөгдөж ХХААХҮ-ийн салбарын эзлэх хувь буурсан байна.

Мөн сүүлийн 10 жилд ХХААХҮ-ийн сайдын багцын төсвийн нийт зарлага нь 2011 оныг эс тооцвол ДНБ-ий 0.2-1.6 хувь, нэгдсэн төсвийн 0.8-4.2 хувь, улсын төсвийн 1.1-5.5 хувийг тус тус эзэлж байна. ХХААХҮ-ийн сайдын төсвийн нийт зарлага 2011 онд бусад жилүүдтэй харьцуулахад огцом өндөр байсан нь тухайн жилд жижиг, дунд үйлдвэрт зориулсан хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрт 176.8 тэрбум төгрөг, ноолуурын үйлдвэрлэл эрхэлж буй ААН-үүдэд 130.0 тэрбум төгрөгийн зээлийн санхүүжилтийн зардал гарсантай холбоотой.

Салбарын төсвийн нийт хэмжээ болон бүтэц нь сүүлийн 10 жилд татаас, урсгал шилжүүлэг, эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлээс голчлон хамаарч өөрчлөгдөж ирсэн байна.

ХХААХҮ-ийн салбарт улсын төсвөөс санхүүжүүлсэн нийт урамшуулал, хөнгөлөлттэй зээлийн хүүгийн татаасын хэмжээ нь 2010-2020 оны дунджаар тус салбарын төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүнгийн 34.1 хувь, урсгал зардлын 46.9 хувийг тус тус эзэлж, салбарын төсөвт томоохон хувийн жинг эзэлж байна.

Сүүлийн 5 жилийн дунджаар авч үзэхэд ХХААХҮ-ийн салбарын төсвийн урсгал зардлын 19.5 хувийг Мал аж ахуйг хөгжүүлэх, 10.6 хувийг Газар тариалан хөгжүүлэх, 2.8 хувийг Хүнсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, 15.7 хувийг Хөнгөн үйлдвэрийг хөгжүүлэх, 11.1 хувийг Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний дэд хөтөлбөрт, 24.0 хувийг ЖДҮ, үйлчилгээ хоршоог дэмжих, 16.1 хувийг Хөдөө аж ахуй, газар тариалан, аж үйлдвэрийн бодлого удирдлага, 0.1 хувийг Хөдөө аж ахуй, газар тариалан, аж үйлдвэрийн судалгаа шинжилгээний хөтөлбөрт тус тус зарцуулсан байна.

Салбарын төсвийн зардлыг зориулалтын ангиллаар авч үзвэл 2021 оны батлагдсан нийт төсвийн 41.4 хувийг ХАА-н салбарын бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийг дэмжих татаас, урамшуулал, 32.7 хувийг мал эмнэлгийн бүх төрлийн үйлчилгээ, оношлогоо, судалгаа эзэлж байна.

ХХААХҮ-ийн салбарын төсвийн зарлагад томоохон хувийг эзэлдэг хөдөө аж ахуйн түүхий эдийн урамшуулал, татаасын эдийн засгийн үр нөлөөг хэмжих үүднээс урамшуулалд олгосон төсвийн зарлагын хэмжээ нь тухайн бүтээгдэхүүн болон түүгээр хийсэн боловсруулах салбарын бүтээгдэхүүний гарцад ямар нөлөө үзүүлж байгааг корреляци болон детерминацийн коэффициентээр тооцож үзэхэд тухайн урамшуулал олгосон иргэн, аж ахуйн нэгж болон урамшуулал олгогдсон бүтээгдэхүүний хэмжээтэй эерэг хамааралтай байгаа боловч тухайн түүхий эдээр боловсруулсан нийт бүтээгдэхүүний хэмжээтэй хамаарал сул, нөлөө үзүүлээгүй харагдаж байна.

ХАА-н урамшууллыг олгож буй зорилго, зорилт нь олон талтай байх бөгөөд энэ нь үр дүнг тооцох, аль нэгэн зорилго, зорилтыг салгаж тооцоход хүндрэлтэй байна. Иймд урамшууллын

тогтолцоонд иж бүрэн үнэлгээ хийж, түүний зорилго, зорилтыг илүү тодорхой чиглэсэн үр дүнд хүргэх, хөдөө аж ахуйн салбарын бодлого, зохицуулалтанд зах зээлийн механизмийг үр дүнтэй ашиглах нь зүйтэй.

Төсвийн хуулийн 1-р хавсралтад тусгасан хөтөлбөрүүдийн үр дүнгийн үзүүлэлтүүдийг дунд хугацааны стратеги төлөвлөгөөний шалгуур үзүүлэлтүүд, ТХЗ-уудтай илүү уялдуулах шаардлагатай. Мөн шалгуур үзүүлэлтүүдийг сонгохдоо гарцын биш илүү үр дүнгийн үзүүлэлтийг сонгох, аль болох хэмжиж болохуйц тооны болон чанарын шалгуур үзүүлэлтийг эрэмбэлж авч үзэх нь зүйтэй.

Мал эмнэлгийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, түүнд зарцуулж буй төсвийн зарлагын үр дүнг дээшлүүлэхийн тулд уг зардлын норматив, үнэ тарифыг судалгаанд үндэслэн бодитой тогтоох нь чухал ач холбогдолтой. Мал эмнэлгийн үйлчилгээ сайжирсанаар ХХААХҮ-ийн салбарт дэвшүүлсэн хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийн боловсруулалтын түвшинг ахиулах, дотоодын үйлдвэрлэл, экспортыг дэмжих, хүнсний аюулгүй байдал, хангамжийн түвшинг дээшлүүлэх зэрэг олон зорилтуудыг хангахад чухал ач холбогдолтой арга хэмжээ болно.

Өнгөрсөн хугацаанд ЖДҮ-ийг хөгжүүлэх сангийн эх үүсвэрт зориулан гаргасан Засгийн газрын бондын эргэн төлөлтийг ААН, иргэдэд олгосон зээлийн эргэн төлөлтөөс бүрдүүлэн хийж ирсэн бөгөөд зээлийн эргэн төлөлт тасалдсан үед салбарын төсвийн өөрийн орлого бүрдэлт тасарч, энэ хэмжээгээр зарлага, санхүүжилтийн гүйцэтгэл доголдох тохиолдлууд гарч байна. ЖДҮ-ийг хөгжүүлэх, эдийн засгийг төрөлжүүлэх нь Засгийн газрын болон салбарын тэргүүлэх зорилт хэвээр байна. Хэдийгээр улсын хөгжилд чухал хувь нэмэртэй ч аль ч улс оронд ЖДҮ нь зах зээлийн үнэ ханш, эдийн засгийн мөчлөг, бүс нутгийн эдийн засаг, нийгмийн өөрчлөлтөнд өртөмтгий, эрсдэл өндөртэй, барьцаа хөрөнгө дутмаг, үйл ажиллагааны цар хүрээ бага тул санхүүгийн зах зээлээс хэрэгцээт санхүүжилтээ авахад бэрхшээлтэй байдаг. Иймд ЖДҮ-ийн санхүүжилтийн тогтолцоог урт хугацаанд тогтвортой үргэлжлүүлэх, зах зээлийн зарчимд нийцүүлэх, улс төрийн нөлөөнөөс ангид байлгах, хямд өртөгтэй санхүүгийн эх үүсвэр, ялангуяа урт хугацааны төслийн санхүүжилтийн эх үүсвэр, хүртээмжийг нэмэгдүүлэх шаардлага тулгарч байна.

## 1. ХХААХҮ-ИЙН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЭДИЙН ЗАСАГТ ЭЗЛЭХ БАЙР СУУРЬ

### 1.1 Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны эрхлэх асуудлын хүрээ

Монгол улсын Засгийн газрын тухай хуулиар ерөнхий чиг үүргийн болон чиглэлийн яамдын эрхлэх асуудлын хүрээг тогтоодог бөгөөд 2000 оноос хойш хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын яамны нэр, эрхлэх асуудлын хүрээнд нийт 5 удаа өөрчлөлт орсоныг Хүснэгт 1-д үзүүлээ.

*Хүснэгт 1. Салбарын яамны нэр, эрхлэх асуудлын хүрээнд орсон өөрчлөлт*

Яамны нэр, эрхлэх асуудлын хүрээнд орсон өөрчлөлт	Засгийн газрын тухай хуульд орсон өөрчлөлтийн огноо
Хүнс, хөдөө аж ахуйн яам	2000 оны 8 дугаар сарын 3-ны өдөр
Хүнс, хөдөө аж ахуйн яам	2004 оны 9 дүгээр сарын 22-ны өдөр
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	2008 оны 9 дүгээр сарын 17-ны өдөр
Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам	2012 оны 8 дугаар сарын 16-ны өдөр
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	2016 оны 7 дугаар сарын 21-ний өдөр

Монгол улсын Засгийн газрын тухай хуулиар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр /ХХААХҮ/-ийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд дараах 14 асуудал хамаарч байна. Үүнд:

- хүн амын хүнсний хангамжийн бодлого;
- хүнсний аюулгүй байдлын асуудал;
- мал аж ахуйг эрчимжүүлэн хөгжүүлэх бодлого;
- газар тариаланг эрчимжүүлэн хөгжүүлэх бодлого;
- мал эмнэлэг, малын үржлийн талаар төрөөс явуулах бодлого;
- мал, амьтан, ургамлын хорио, цээрийн асуудал;
- бэлчээрийн болон таримал ургамлыг хамгаалах асуудал;
- мал, таримал ургамлын гаралтай хүнсний зүйл, түүхий эд болон хөнгөн үйлдвэрийн бүтээгдэхүүний экспорт, импортын асуудал;
- хөдөө аж ахуйн эдэлбэр газрын болон бэлчээр ашиглалтын бодлого;
- малыг цаг агаарын гэнэтийн аюулаас хамгаалах бодлого;
- хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх асуудал;
- жижиг, дунд үйлдвэрийн хөгжлийн асуудал;
- дотоод худалдаа, үйлчилгээний бодлого, зохицуулалт;
- агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх асуудал.

### 1.2 Салбарын эдийн засагт эзлэх байр суурь

ХХААХҮ-ийн салбар нь 2020 оны байдлаар Монгол улсын ДНБ-ий 32.5 хувийг, нийт экспортын 5.6 хувийг, нийт ажиллагсадын 50 гаруй хувийг тус тус бүрдүүлж байна. Сүүлийн 10 жилийн хандлагаас харахад ХХААХҮ-ийн салбарын нийт эдийн засагт болон экспортод эзлэх хувь төдийлөн өөрчлөгдөөгүй байна.

Мөн сүүлийн 10 жилд ХХААХҮ-ийн сайдын багцын төсвийн нийт зарлага нь 2011 оныг эс тооцвол ДНБ-ий 0.2-1.6 хувь, нэгдсэн төсвийн 0.8-4.2 хувь, улсын төсвийн 1.1-5.5 хувийг тус тус эзэлж байна. ХХААХҮ-ийн сайдын төсвийн нийт зарлага 2011 онд бусад жилүүдтэй харьцуулахад огцом өндөр байсан бөгөөд энэ нь тухайн жилд Жижиг, дунд үйлдвэрт зориулсан хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрт 176.8 тэрбум төгрөг, ноолуурын үйлдвэрлэл эрхэлж буй ААН-үүдэд 130.0 тэрбум төгрөгийн зээл олгосонтой холбоотой. /Хүснэгт 2/




Хүснэгт 2. ХХААХҮ-ийн салбарын үндсэн үзүүлэлтүүд

	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020*
ХХААХҮ-ийн салбарын ДНБ / оны үнээр, тэрбум төг/	3,061.2	4,356.8	5,544.8	6,717.1	7,657.6	7,746.3	7,440.8	8,523.9	9,905.9	11,481.6	11,999.2
Нийт ДНБ-д эзлэх хувь	31.4%	33.1%	33.2%	35.0%	34.5%	33.5%	31.1%	30.6%	30.6%	30.8%	32.5%
ХХААХҮ-ийн салбарын экспорт /сая ам.доллар/	327.7	349.9	305.2	371.2	429.2	420.8	437.5	524.0	647.2	625.8	424.8
Нийт экспортод эзлэх хувь	11.3%	7.3%	7.0%	8.7%	7.4%	9.0%	8.9%	8.5%	9.2%	8.2%	5.6%
ХХААХҮ-ийн салбарт ажиллагсад	85,243	587,407	596,432	597,745	603,003	624,884	639,402	690,408	683,577	577,223	
Нийт ажиллагсдад эзлэх хувь	56.6%	56.6%	56.5%	54.2%	54.3%	54.3%	55.7%	55.8%	54.6%	50.4%	
ХХААХҮ-ийн сайдын нийт төсвийн зарлага / сая төг/	130,626.2	514,162.3	180,731.6	140,801.0	153,336.6	98,625.4	142,178.4	272,481.7	172,524.4	167,233.9	362,942.2
ДНБ-д эзлэх хувь	1.6%	4.7%	1.3%	1.0%	0.6%	0.2%	0.6%	1.0%	0.5%	0.5%	0.9%
Нэгдсэн төсвийн нийт зарлагад эзлэх хувь	4.2%	10.3%	3.0%	2.9%	1.9%	0.8%	1.5%	3.0%	1.9%	1.4%	2.4%
Улсын төсвийн нийт зарлагад эзлэх хувь	5.5%	14.2%	4.1%	3.8%	2.6%	1.1%	1.9%	3.8%	2.4%	1.8%	3.0%

Монгол улсын эдийн засгийн бүтэц 1990 оноос хойш тодорхой хэмжээнд өөрчлөгдөж ирсэн байна. Тухайлбал, 2000 хойш оноос нийт эдийн засагт уул, уурхай, олборлох үйлдвэрлэлийн салбарын эзлэх хувийн жин нэмэгдэж, хөдөө аж ахуй, боловсруулах салбарын хувийн жин буурч ирснийг доорх зургаас харж болно.

## ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ШИНЖИЛГЭЭ

Зураг 1. Монгол улсын ДНБ-ий бүтэц



Монгол улсын Үндэсний тооцооны системийн Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилалаар дараах 4 салбар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд багтаж байна. Үүнд:


- Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур
- Боловсруулах үйлдвэрлэл
- Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ
- Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ

Эдгээр 4 салбар нь 2020 оны байдлаар Монгол улсын Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ий 32.5 хувийг эзэлж байна (Зураг 1).





Зураг 2. ДНБ-д ХХААХҮ-ийн салбарын эзлэх хувь



Зураг 2-ээс харахад ХХААХҮ-ийн салбар нь 1995 онд нийт ДНБ-ий 59.6 хувь, 2000 онд 44.5 хувийг бүрдүүлж байсан бол 2000 оноос аажмаар буурч сүүлийн 15 жилд ДНБ-ий 31-33 хувь буюу нийт эдийн засгийн гуравны нэгийг бүрдүүлж байна. Уул уурхай, олборлох үйлдвэрлэлийн салбарт 2000 оноос хойш гадаад, дотоодын хөрөнгө оруулалт мэдэгдэхүйц нэмэгдэж, Монгол улсын эдийн засагт чухал хувь нэмэр оруулах болсноор ДНБ-ий бүтэц өөрчлөгдөж ХХААХҮ-ийн салбарын эзлэх хувь буурсан байна.

ХХААХҮ-ийн салбарын бүтцийг Хүснэгт 3-т үзүүлээ.

Хүснэгт 3. ХХААХҮ-ийн салбарын бүтэц /Салбарын нийт дүнд эзлэх хувиар/

	1990	1995	2000	2005	2010	2015	2016	2017	2018	2019	2020
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	25.1%	54.6%	61.7%	58.8%	37.4%	39.9%	37.6%	33.6%	35.3%	35.1%	37.2%
Боловсруулах үйлдвэрлэл	41.0%	29.0%	15.1%	17.1%	21.7%	22.8%	23.6%	29.5%	30.9%	30.6%	32.9%
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ	32.9%	15.4%	21.3%	22.2%	39.2%	34.5%	35.6%	33.7%	30.5%	30.9%	27.5%
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	1.0%	1.0%	2.0%	1.9%	1.7%	2.8%	3.2%	3.1%	3.2%	3.5%	2.4%
ХХААХҮ-ийн салбар нийт	100%	100%	100%	100%	100%	100%	100%	100%	100%	100%	100%

Эх үүсвэр. 1212.mn

ХХААХҮ-ийн салбарын ДНБ-ий нийт дүнд Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын салбар хамгийн их хувьтай байгаа бөгөөд 2020 оны байдлаар 37.2 хувийг бүрдүүлж байна. Салбарын ДНБ-ий нийт дүнд боловсруулах салбарын эзлэх хувь 2000 оноос хойш аажмаар нэмэгдэх хандлагатай байгаа бөгөөд 2020 онд 32.7 хувийг эзэлж байна. Салбарын ДНБ-ий 30 орчим хувийг үйлчилгээний салбар болох бөөний болон жижиглэн худалдаа,


## ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ШИНЖИЛГЭЭ

машин, мотоциклийн засвар, үйлчилгээ болон зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ эзэлж байна.

### 1.3 Хөдөө аж ахуй

Хөдөө аж ахуй (ХАА)-н салбар нь мал аж ахуй (МАА), газар тариалангийн дэд салбараас бүрдэж байгаа бөгөөд 1995 онд Монгол улсын ДНБ-ий 32.5 хувийг эзэлж байсан бол аажмаар буурч сүүлийн 5 жилийн хандлагаас харахад ДНБ-ий 8.7-11.4 хувийг МАА, 1.5-2.0 хувийг газар тариалангийн дэд салбар бүрдүүлж байна /Зураг 3/

**Зураг 3. ДНБ-д МАА, газар тариалангийн дэд салбарын эзлэх хувь**



Эх үүсвэр: ҮСХ Тайлбар: \*-Урьдчилсан гүйцэтгэл

#### 1.3.1 Мал аж ахуй

Мал аж ахуйн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл 2019 оны гүйцэтгэлээр 3.7 их наяд төгрөгт хүрч, ДНБ-ний 9.2 хувь, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн 85.0 хувийг бүрдүүлж байна.

Монгол улсын мал аж ахуй (МАА)-н салбар нь уламжлалт бэлчээрийн мал аж ахуй голлосон шинжтэй хэвээр байна. Мал тооллогыг жилийн эцэст явуулдаг болсон 1961 оноос эхлэн 1990 он хүртэл 30 жилийн хугацаанд буюу төлөвлөгөөт эдийн засгийн жилүүдэд Монгол улсын мал сүргийн тоо дунджаар 23.1 сая толгой, хонин толгойд шилжүүлснээр 49.5<sup>1</sup> сая толгой малтай байсан байна.


Зах зээлийн эдийн засагт шилжиж, малыг хувьчилснаас хойш малын тоо тогтвортой өсөж, 2019 оны байдлаар 71.4 сая, хонин толгойд шилжүүлснээр 120 сая толгойд хүрчээ. Малын тоо 1961 онтой харьцуулахад 3.5 дахин буюу 51 сая толгойгоор нэмэгдсэн нь үндсэндээ бог

<sup>1</sup> ҮСХ, "Хөдөө аж ахуйн салбарын танилцуулга 2019" Бог малд буюу хонин толгойд шилжүүлэх коэффициент: 1 тэмээ 5 хонь, 1 адуу 7 хонь, 1 үхэр 6 хонь, 1 ямаа 0.9 хонь. [https://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=huduu\\_aj\\_ahui\\_2019.pdf&ln=Mn](https://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=huduu_aj_ahui_2019.pdf&ln=Mn)

малын өсөлтөөр хангагдсан байна.

Сүүлийн 5 жилийн байдлаар харахад МAA-н салбарын нийт үйлдвэрлэлийн бодит өсөлт дунджаар 5.4 хувьтай байна. Харин сүүлийн жилүүдэд тогтмол өсч байсан малын тоо толгой 2020 онд 5.5 хувиар буурсан дүнтэй байна.

**Зураг 4. МAA-н салбарын бодит өсөлт болон малын тооны өсөлт, бууралт**




Эх үүсвэр: YCX Тайлбар: \*-Урьдчилсан гүйцэтгэл


МAA-н салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүнд мах, сүү, ноос, ноолуур, арьс шир, өндөг, зөгийн бал зэрэг бүтээгдэхүүн ордог. Сүүлийн 5 жилийн хандлагаас харахад бүх төрлийн мах (адуу, үхэр, хонь, ямаа, тэмээний мах), сүү, ноос, ноолуур, арьс ширний үйлдвэрлэл харьцангуй тогтвортой, бага зэрэг өсөх хандлагатай байна (Зураг 5. МAA-н салбарын үйлдвэрлэл, бүтээгдэхүүний нэр төрлөөр).

Монгол улсын хэмжээнд 2015 онд 100.6 сая ширхэг өндөг үйлдвэрлэж байсан бол 2019 оны эцсийн байдлаар 178.7 сая ширхэг өндөг үйлдвэрлэж 77.6 хувиар өссөн байна. Зөгийн балны хувьд 2015 онд 155.3 тонныг үйлдвэрлэж байсан бол 2019 онд 221.5 тонн буюу 2015 онтой харьцуулахад 46.6 хувиар нэмэгдсэн байна.

**Зураг 5. МAA-н салбарын гол нэр, төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл**



## ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ШИНЖИЛГЭЭ



Эх үүсвэр: ҮСХ

Монгол улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, салбарын үндэсний хөтөлбөрүүдэд МАА-н салбарыг хөгжүүлэх, төрөөс дэмжих бодлогыг багцалж авч үзвэл дараах 4 зорилтод чиглэж байна. Үүнд:

1. Бэлчээрийн мал аж ахуйг зонхилон эрхэлж, хүн ам олноор суурьшсан хот, суурин газрын орчмын болон тариалангийн бүс нутагт ашиг шимийн чиглэлээр төрөлжсөн эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэх

2. Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангах

3. МАА-н гаралтай бүтээгдэхүүний боловсруулалтын түвшин, экспортыг нэмэгдүүлэх, гол нэр төрлийн бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээг хангах

4. Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлт, тээвэр, ложистик, чанарын хяналт, баталгаажуулалтын тогтолцоог сайжруулах, боловсруулалтын түвшинг дээшлүүлэх.


Дээрх зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд төрөөс бүтээгдэхүүний нийлүүлэлтэнд урамшуулал олгох, бэлтгэн нийлүүлэлтэнд хөнгөлөлттэй зээл, хүүгийн татаас олгох, хадлан тэжээл бэлтгэх техник, тоног төхөөрөмж нийлүүлэхэд татвар, үнийн хөнгөлөлт үзүүлэх зэрэг дэмжлэг үзүүлж иржээ. Мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэхэд олон улсын байгууллага, гадаад улсын хөнгөлөлттэй зээл, тусламжийг авч зохих дэмжлэг үзүүлж ирсэн байна.

### 1.3.2 Газар тариалан

Газар тариалангийн салбар нь 2020 оны урьдчилсан гүйцэтгэлээр Монгол улсын ДНБ-ий 1.8 хувь, ХАА-н бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 15 хувийг бүрдүүлж байна. Газар тариалангийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл /2010 оны зэрэгцүүлэх үнээр/ сүүлийн 5 жилд дунджаар 5.4 хувиар өссөн байна.

Газар тариалангийн гол нэр төрлийн бүтээгдэхүүнд үр тариа, төмс, хүнсний ногоо, таримал тэжээл, техникийн ургамал, эмийн болон бусад ургамал, жимс, жимсгэнэ ордог бөгөөд 2020 оны байдлаар үр тарианы тариалалт нийт тариалсан талбайн 72.5 хувийг эзэлж байна. /Зураг 6/


**Зураг 6.** Тариалсан талбайн хэмжээ, мян.га-аар



Эх үүсвэр: ҮСХ

Сүүлийн 5 жилийн хандлагаас харахад хураасан ургацын хэмжээ бүтээгдэхүүний нэр төрлөөс хамааран харилцан адилгүй байна. Тухайлбал, улаан буудайн хувьд 2015 онтой харьцуулахад 80.0 мянган тонноор буурсан бол төмс, хүнсний ногоо, таримал тэжээлийн хэмжээ нэмэгдсэн байна /Зураг 7/

**Зураг 7.** Хураасан ургацын хэмжээ, мянган тонноор.




Хураан авсан га-гийн ургацын хэмжээ сүүлийн 5 жилд байгаль, цаг уурын нөхцлөөс хамааран хэлбэлзэлтэй байна. Тухайлбал 2016, 2018 онд үр тариа, төмс, хүнсний ногооны га-гийн ургац мэдэгдэхүйц буурсан байна /Зураг 8/. Мөн га-гийн ургацын хэмжээ буурснаас нийт хураасан ургацын хэмжээ ихээхэн буурсныг Зураг 7-оос харж болно.




## ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ШИНЖИЛГЭЭ

**Зураг 8. Га-гийн ургац, цн-ээр**



Буудайн га-гийн ургацын хэмжээг бусад улс орнуудтай харьцуулж Зураг 9-д үзүүлээ. Зураг 9-өөс харахад манай улсын хувьд 1 га-гаас хураан авсан улаан буудайн ургац дэлхийн дунджаас ойролцоогоор 3 дахин, OECD-ийн орнуудаас 4 дахин доогуур байна. Байгаль цаг уурын нөхцөл ихээхэн таатай, ХАА-ын хөгжил өндөр түвшинд хүрсэн Шинэ Зеланд, Англи зэрэг улсад 1-гаас 80-90 цн буудай хураан авч байна. Манай улсын хувьд 2015-2020 онд 1-гаас дунджаар 10.4 цн улаан буудай хураан авчээ.

**Зураг 9. Улс орнуудын 1 га-гаас хураан авсан буудайн ургацын хэмжээ /цн-ээр/**



Эх үүсвэр: OECD, ХХААХҮЯ

Газар тариалангийн бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэлээс нийт дотоодын зах зээлд нийлүүлсэн хувийн жинг Хүснэгт 4-д харууллаа. Хүснэгт 4-аас харахад сүүлийн 6 жилийн дунджаар улаан буудайн 82.7 хувь, төмсний 98.0 хувь, хүнсний ногооны 55.9 хувийг дотоодын үйлдвэрлэлээс нийлүүлсэн байна.



**Хүснэгт 4.** Газар тариалангийн бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэл ба нийт нийтлүүлэлтийн харьцаа, хувиар

Үзүүлэлт	Дотоодын үйлдвэрлэл/Нийт дотоодын зах зээлд нийлүүлэлт					
	2015	2016	2017	2018	2019	2020*
	Хувь					
Улаан буудай	90.7	74.3	94.3	64.9	96.4	75.9
Төмс	90.6	99.4	100.0	98.2	99.5	100.0
Хүнсний ногоо	57.4	57.4	52.0	54.2	54.3	60.3

Эх үүсвэр: ХХААХҮЯ

Газар тариалангийн эрчимжилтийг харуулах нэг үзүүлэлт нь усалгаатай талбайн хэмжээ бөгөөд нийт тариалсан талбайд эзлэх хувь бага боловч нэмэгдэх хандлагатай байна. Тухайлбал 2015 онд нийт тариалсан талбайд усалгаатай талбайн эзлэх хувь 8.6 байсан бол 2020 онд энэ үзүүлэлт 11.2 хувьтай байна. /Хүснэгт 5/

**Хүснэгт 5.** Нийт тариалсан талбайд усалгаатай талбайн эзлэх хувь

Үзүүлэлт	2015	2016	2017	2018	2019	2020*
	мянган га					
Нийт тариалсан талбай	527.7	508.3	527	511.8	526.0	536.9
Үүнээс усалгаатай талбай	45.2	35.7	36	36.5	47.3	60.2
Нийт дүнд эзлэх хувь	8.6	7	6.8	7.1	9.0	11.2

Эх үүсвэр: ХХААХҮЯ

## 1.4 Хүнсний үйлдвэрлэлийн салбар

Монгол улсын Засгийн газрын тухай хуулиар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах чиг үүрэгт хүн амын хүнсний хангамжийн бодлого, хүнсний аюулгүй байдлын асуудал ордог.

УИХ-ын 2015 оны 104 дүгээр тогтоолоор батлагдсан Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого-д “1.4.3. мал аж ахуй, газар тариалангийн гаралтай түүхий эд, байгалийн баялгийг уламжлалт болон дэвшилтэт технологиор боловсруулж, хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангасан шим тэжээллэг, баталгаатай хүнсээр хүн амыг тогтвортой хангах” чиглэлийг баримтлахаар заасан. Мөн хүнсний аюулгүй байдал, боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх хүрээнд дараах зорилтыг хэрэгжүүлэхээр тусгасан. Үүнд:

-Эрүүл, аюулгүй, тэжээллэг хүнсээр хүн амыг жигд хүртээмжтэй хангах, хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлтийн улирлын хамаарлыг бууруулах, импорт орлох хүнсний үйлдвэрлэлийг дэмжих;

- Стратегийн хүнсний улирлын нөөцийг эрэлт, нийлүүлэлт, хэрэглээний онцлогтой уялдуулан хувийн хэвшлийн оролцоотойгоор бүрдүүлэх;
- Үйлдвэрлэлийн аргаар боловсруулсан мах, сүүн бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх;
- Мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг хүлээн авах, анхан шатны болон хагас боловсруулалт хийх нөхцөлийг бүрдүүлэх, хадгалалт, тээвэрлэлт, боловсруулалт, борлуулалтын сүлжээг хөгжүүлэх;
- Хүнсний сүлжээний бүх үе шатанд бүртгэл, чанарын удирдлага, хяналт, баталгаажуулалтын тогтолцоог төлөвшүүлж хүнсний бүтээгдэхүүний аюулгүй




## ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ШИНЖИЛГЭЭ

байдлыг хангах ажлыг эрчимжүүлэх зэрэг болно.

Монгол улсын хүнсний хэрэглээний гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээ, сүүлийн 30 жилийн динамикийг Зураг 10-д харуулав.

**Зураг 10.** Хүнсний гол нэр, төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, 1989-2019




Эх үүсвэр: УСХ

Хүнсний гол нэр, төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл 1990 оны эхэн үеийн хямралаас хойш сүүлийн 10-аад жилд сэргэх хандлагатай байгаа бөгөөд 2019 оны эцсийн байдлаар сүү, сүүн бүтээгдэхүүн, гурил, махан нөөш, гоймон, шар айрагны үйлдвэрлэл зах зээлийн эдийн засагт шилжихийн өмнөх үе буюу 1989 оны түвшинд, зарим нэр төрөл дээр энэ түвшнээс давсан үзүүлэлттэй байна. /Зураг 10/



Зураг 11. Хүнсний гол нэр төрлийн бүтээгдэхүүний импортын хамаарал /2019 оноор/



Эх үүсвэр: ҮСХ

Дээрх Зураг 11-ээс харахад хүнсний хангамжид загас 100 хувь, шувууны мах 96.6 хувь, сүүн бүтээгдэхүүн 30.7 хувь, гурилан бүтээгдэхүүн 34.1 хувь, төрөл бүрийн будаа 100 хувь, хүнсний ногоо 44 хувь, жимс жимсгэнэ 96.7 хувь, өндөг 47.4 хувь, ургамлын тос 98 хувь, цөцгийн тос 53 хувь, сахар чихрийн зүйл 36.3 хувийн импортын хамааралтай байна. Хүнсний хангамжид мах, гурил, төмсний хэрэгцээг 97-100 хувь, сүүн бүтээгдэхүүний 69.3 хувь, гурилан бүтээгдэхүүний 65.9 хувь, хүнсний ногооны 56 хувь, жимс жимсгэний 3.3 хувь, өндөгний 52.6 хувь, ургамлын тосны 2 хувийг дотоодын үйлдвэрлэлээр хангажээ.

## 1.5 Хөнгөн үйлдвэрийн салбар

ҮСХ-оос гаргасан эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилалаар хөнгөн үйлдвэрийн салбарт дараах дэд салбар орж байна. Үүнд:

- Нэхмэлийн үйлдвэрлэл
- Хувцас үйлдвэрлэл
- Арьс, арьсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл
- Тавилгаас бусад мод болон модон бүтээгдэхүүний үйлдвэрлэл
- Цаас болон цаасан бүтээгдэхүүний үйлдвэрлэл
- Хэвлэх, дуу бичлэгийн хувилах, дахин үйлдвэрлэх үйл ажиллагаа
- Резинэн болон хуванцар бүтээгдэхүүний үйлдвэрлэл
- Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл
- Цахилгаан тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл
- Тавилга үйлдвэрлэл

## ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ШИНЖИЛГЭЭ

Хөнгөн үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэл 2019 оны эцсийн байдлаар 2 их наяд 299.5 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд үүний 18.8 хувийг нэхмэлийн үйлдвэрлэл, 22.5 хувийг хувцас үйлдвэрлэл, 3.5 хувийг арьс, арьсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл, 3.9 хувийг тавилгаас бусад мод болон модон бүтээгдэхүүний үйлдвэрлэл, 4.9 хувийг цаас болон цаасан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, 5.0 хувийг хэвлэх, дуу бичлэгийн хувилах, дахин үйлдвэрлэх үйл ажиллагаа, 3.7 хувийг резинэн болон хуванцар бүтээгдэхүүний үйлдвэрлэл, 27.7 хувийг төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл, 1.5 хувийг цахилгаан тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл, 8.7 хувийг тавилга үйлдвэрлэл тус тус эзэлж байна. /Хүснэгт 6/


**Хүснэгт 6.** Хөнгөн үйлдвэрийн нийт үйлдвэрлэл, оны үнээр, эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангиллаар, сая төгрөгөөр

Салбар	2015	2016	2017	2018	2019
Нэхмэлийн үйлдвэрлэл	316 859.2	338 964.1	340 346.0	383 926.4	431 441.3
Хувцас үйлдвэрлэл	288 720.7	333 961.5	426 485.5	519 194.4	516 410.2
Арьс, арьсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	67 027.3	67 249.3	73 787.3	79 630.0	79 978.5
Тавилгаас бусад мод болон модон бүтээгдэхүүний үйлдвэрлэл	109 316.7	112 069.5	142 478.7	149 351.6	89 352.5
Цаас болон цаасан бүтээгдэхүүний үйлдвэрлэл	47 726.1	38 318.7	53 547.0	65 238.9	111 574.1
Хэвлэх, дуу бичлэгийн хувилах, дахин үйлдвэрлэх үйл ажиллагаа	72 620.8	88 658.5	91 277.8	96 740.1	114 061.1
Резинэн болон хуванцар бүтээгдэхүүний үйлдвэрлэл	38 916.1	35 782.2	48 746.1	73 670.8	85 786.3
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл	315 711.4	237 482.2	347 760.5	548 097.5	636 427.4
Цахилгаан тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл	56 551.1	8 278.8	15 442.3	32 046.3	35 463.4
Тавилга үйлдвэрлэл	45 657.2	81 235.9	91 805.5	104 264.5	199 006.9
<b>Бүгд</b>	<b>1 359 106.6</b>	<b>1 342 000.8</b>	<b>1 631 676.8</b>	<b>2 052 160.5</b>	<b>2 299 501.7</b>

Эх үүсвэр: ХХААХҮЯ

Хөнгөн үйлдвэрийн гол нэр төрлийн бүтээгдэхүүнд самнасан ноолуур, угаасан ноос, хивс, ноосон хөнжил, эсгий, савхин хувцас, нэхий дээл, хувцас орж байна. Гол нэрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээг сүүлийн 5 жилээр Зураг 12-д үзүүлэв.


**Зураг 12.** Хөнгөн үйлдвэрийн гол нэр, төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл /2015-2020/



Эх үүсвэр: ҮСХ, ХХААХҮЯ

Дотоодын үйлдвэрт боловсруулсан малын гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн байдлыг сүүлийн 5 жилээр Зураг 13-д үзүүллээ. Зураг 13-аас харахад угаасан ноосны хэмжээ 2015 онд 1777.8 тонн байсан бол 2017 онд 8721.5 тонн хүрч өссөн бөгөөд 2018-2019 онд буурч 3340-3370 тонн болсон байна. Самнасан ноолуурын хэмжээ өнгөрсөн 5 жилд төдийлөн өөрчлөгдөөгүй бөгөөд 754.5-1160.3 тонныг үйлдвэрлэсэн байна. Боловсруулсан үхрийн шир, хонины арьсны тоо хэмжээ сүүлийн 3 жилд буурсан үзүүлэлттэй байна. /Зураг 13/

**Зураг 13.** Дотоодын үйлдвэрт боловсруулсан малын гаралтай бүтээгдэхүүн.



Эх үүсвэр: ҮСХ, ХХААХҮЯ





## 2. САЛБАРЫН БОДЛОГЫН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛИЙН ЗОРИЛТУУД

### 2.1 Салбарын бодлогын тэргүүлэх чиглэлүүд

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн зорилтуудыг агуулсан “Алсын хараа-2050” хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулж УИХ-ын 2020 оны 52-р тогтоолоор батласан билээ. “Алсын хараа-2050” хөгжлийн бодлогын баримт бичигт нийт 9 зорилго, 47 зорилт дэвшүүлж, түүнийг хэрэгжүүлэх 965 арга хэмжээг тусгасан бөгөөд үр дүнгийн нийт 73 шалгуур үзүүлэлт гаргажээ.

Түүнчлэн Монгол улсад дунд хугацааны хөгжлийн бодлогын 2 баримт бичиг боловсруулж, батлан мөрдөж байна. Эдгээр нь “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл”, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болно.

Эдгээр урт болон дунд хугацааны улсын хөгжлийн бодлогын баримт бичигт үндэслэн ХХААХҮЯ-наас ХХААХҮ-ийн салбарын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөг боловсруулж ХХААХҮ-ийн сайдын 2021 оны А-28 тоот тушаалаар батлан хэрэгжүүлж байна.

ХХААХҮ-ийн салбарын 2021-2024 оны стратеги төлөвлөгөө нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтууд, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээг салбарын түвшинд нарийвчилж тусган хэрэгжүүлэхэд чиглэгдсэн байна.

Стратеги, төлөвлөгөө нь дараах 9 бүлэг бүхий бүтэц, агуулгатай боловсруулагдсан байна. Үүнд:

Нэг. Нийтлэг үндэслэл

Хоёр. Мандатын шинжилгээ /чиг үүргийн шинжилгээ/

Гурав. Алсын хараа

Дөрөв. Эрхэм зорилго

Тав. Орчны шинжилгээ

Зургаа. Стратегийн зорилго

Долоо. Стратегийн зорилгыг хэмжих шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшин, стратеги

Найм. Стратегийн зорилго ба салбар, нутаг дэвсгэрийн нэгж, байгууллагын бүтцийн уялдаа, стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх нэгжийн матриц

Ес. Стратеги төлөвлөгөөний төсөв, эх үүсвэр

Тус стратеги төлөвлөгөөнд салбарын эрхэм зорилгыг “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны үйл ажиллагааны эрхэм зорилго нь салбарын бодлогыг оновчтой тодорхойлж хэрэгжүүлэх замаар **түүхий эдийн нөөцийг зохистой ашиглах, импортыг орлох, экспортын баримжаатай бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үнэ цэнийн сүлжээг хөгжүүлэх, үйлдвэрлэлийн орлого, бүтээмжийг өсгөн өрсөлдөх чадварыг дээшлүүлэн салбарын эдийн засгийн өсөлтийг тогтвортой нэмэгдүүлэх, хүн амыг эрүүл, баталгаат, шим тэжээллэг хүнс, эрүүл ахуй, хэрэглээний шаардлага хангасан хувцас, хэрэгслээр хангах** нөхцөлийг бүрдүүлэхэд оршино” гэж тодорхойлсон байна.



**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН  
ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ШИНЖИЛГЭЭ**

Салбарын стратеги төлөвлөгөөнд тус яамны хариуцах нийт 7 чиг үүргийн хүрээнд 23 зорилт дэвшүүлж, түүнийг хэрэгжүүлэх 73 арга хэмжээг заасан байх бөгөөд үр дүнгийн 95 шалгуур үзүүлэлтийг тусгажээ.

Салбарын дунд хугацаанд хэрэгжүүлэх тэргүүлэх чиглэлийн дээр дурдсан 23 зорилтыг бүхэлдээ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан тус салбарт хамаарах зорилтууд байна /Хүснэгт 7/. Өөрөөр хэлбэл Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг салбарын түвшинд хэрэгжүүлэхээр бүрэн уялдуулж боловсруулсан стратеги төлөвлөгөө гэж хэлж болно.

**Хүснэгт 7. ХХААХҮ-ийн салбарын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөний тэргүүлэх чиглэлийн зорилтууд**

Чиг үүрэг	Зорилт	Арга хэмжээний тоо
<b>1. Салбарын хөгжлийн бодлого, төлөвлөлт</b>		
	Зорилт-1. Салбарын хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох;	13
<b>2. Газар тариалангийн хөгжлийн бодлого, зохицуулалт</b>		
	Зорилт-1. Атрын IV аяныг хэрэгжүүлж, тариалангийн тогтвортой үйлдвэрлэлийн хөгжлийг хангах, таримлын сэлгээ, тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх замаар салбарын бүтээмж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ. /ЗГҮАХХАХТ-ийн 3.3.1/	10
	Зорилт-2. Газар тариалан, хөдөө аж ахуйн төв, Дархан, Сэлэнгэ бүс нутгийн агротехникийн засвар үйлчилгээний төв байгуулах ажлыг хэрэгжүүлнэ. /ЗГҮАХХАХТ-ийн 3.3.2/	1
	Зорилт-3. Хөдөө аж ахуйн тээвэр, борлуулалтын ложистикийн сүлжээг байгуулж, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн чанарын хяналт, баталгаажуулалтын оновчтой тогтолцоог бүрдүүлнэ. /ЗГҮАХХАХТ-ийн 3.3.12/	1
	Зорилт-4. Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр бүрэн хангаж, махны экспортын хэмжээг нэмэгдүүлнэ. /ЗГҮАХХАХТ-ийн 3.3.3/	1
<b>3. Мал аж ахуйн хөгжлийн бодлого</b>		
	Зорилт-1. Бэлчээрийг усжуулах, худагжуулах ажлыг үргэлжлүүлэн малын бэлчээрийн нөөцийг нэмэгдүүлэх, тогтвортой байдлыг хангах, малын чанар, ашиг шимийг сайжруулж, малын тоог чанарт шилжүүлж малын генийн санг хамгаалах, биотехнологийн ололтыг нэвтрүүлэх, эрчимжсэн мал аж ахуйн салбарын хөгжлийг дэмжиж, “Монгол мал-II” хөтөлбөр хэрэгжүүлнэ. /ЗГҮАХХАХТ-ийн 3.3.4/	12
	Зорилт-2. Бэлчээрийн ашиглалт, хамгаалалт, сайжруулалтын хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, бэлчээрийн доройтол, цөлжилтийг бууруулна. /ЗГҮАХХАХТ-ийн 3.3.5/	1
	Зорилт-3. Малчдыг дэмжих анхдугаар аян зохион байгуулж, мал сүргийг гэмт халдлагаас хамгаалж, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрийг бүсчилсэн байдлаар байгуулан нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн экспортлож, малчид, иргэдийн орлогыг нэмэгдүүлнэ. /ЗГҮАХХАХТ-ийн 3.3.6/	2
	Зорилт-4. Мал аж ахуйг байгаль цаг уурын эрсдлээс хамгаалах, бэлэн байдлыг хангах, сумдад өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх, малчдыг өвс тэжээл нөөцлөх сүлжээг бий болгоно. /ЗГҮАХХАХТ-ийн 3.3.7/	1
	Зорилт-5. Мал эмнэлгийн тогтолцооны шинэчлэлийг төгөлдөржүүлж, халдварт, гоц халдварт өвчинтэй тэмцэх, гоц халдварт өвчингүй, тайван бүсийг баталгаажуулж, мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний экспортын боломжийг нээнэ. /ЗГҮАХХАХТ-ийн 3.3.8/	8

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН  
ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ШИНЖИЛГЭЭ**

	Зорилт-6. Хөдөө аж ахуйн тээвэр, борлуулалтын логистикийн сүлжээг байгуулж, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн чанарын хяналт, баталгаажуулалтын оновчтой тогтолцоог бүрдүүлнэ. /ЗГҮАХХАХТ-ийн 3.3.12/	1
<b>4. Хүнсний үйлдвэрийн хөгжлийн бодлого зохицуулалт</b>		
	Зорилт-1. Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр бүрэн хангаж, махны экспортын хэмжээг нэмэгдүүлнэ. /ЗГҮАХХАХТ-ийн 3.3.5/	6
<b>5. Хөнгөн үйлдвэрийн хөгжлийн бодлого, зохицуулалт</b>		
	Зорилт-1 Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих замаар мах, ноос, ноолуур, арьс шир боловсруулах үйлдвэрийн бүтээмжийг нэмэгдүүлнэ. /ЗГҮАХХАХТ-ийн 3.3.9/	2
	Зорилт-2. Мал, малын гаралтай түүхий эдийг боловсруулах байгальд ээлтэй цогцолбор байгуулж, хөдөө аж ахуйн гаралтай бараа, бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлнэ. /ЗГҮАХХАХТ-ийн 3.3.10/	3
	Зорилт-3. Малчдыг дэмжих анхдугаар аян зохион байгуулж, мал сүргийг гэмт халдлагаас хамгаалж, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрийг бүсчилсэн байдлаар байгуулан нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн экспортолж, малчид, иргэдийн орлогыг нэмэгдүүлнэ. /ЗГҮАХХАХТ-ийн 3.3.6/	1
	Зорилт-4. Бүтээгдэхүүнээ экспортод гаргасан аж ахуйн нэгжийг тусгайлан дэмжих “Экспортын баталгааны сан” байгуулж ажиллуулна. /ЗГҮАХХАХТ-ийн 3.1.20/	1
	Зорилт-5. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний хүчин чадлыг үе шаттайгаар нэмэгдүүлж, ашиглалтын дэвшилтэт техник, технологи нэвтрүүлнэ. /ЗГҮАХХАХТ-ийн 3.7.11/	1
<b>6. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршооны хөгжлийн бодлого, зохицуулалт</b>		
	Зорилт-1. Хөдөө аж ахуйн тээвэр, борлуулалтын логистикийн сүлжээг байгуулж, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн чанарын хяналт, баталгаажуулалтын оновчтой тогтолцоог бүрдүүлнэ. /ЗГҮАХХАХТ-ийн 3.3.12/	1
	Зорилт-2. Жижиг, дунд үйлдвэр, бизнес эрхлэгчдэд орчин үеийн санхүүжилтийн хэлбэрүүдийг нэвтрүүлж, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг төрөөс бизнес инкубацын үйлчилгээгээр бойжуулж, томруулах бодлого хэрэгжүүлнэ. /ЗГҮАХХАХТ-ийн 3.3.13/	3
	Зорилт-3. Оюутолгой, Эрдэнэт зэрэг томоохон үйлдвэрийн захиалгат ажлыг үндэсний жижиг, дунд бизнес эрхлэгчид гүйцэтгэх боломжийг нэмэгдүүлнэ. /ЗГҮАХХАХТ-ийн 3.3.14/	1
	Зорилт-4. Төр хувийн хэвшлийн түншлэлд тулгуурласан, байгаль орчинд ээлтэй, хүлэмжийн хий багатай ногоон төслүүдийн санхүүжилтийг нэмэгдүүлнэ. /ЗГҮАХХАХТ-ийн 3.3.15/	1
	Зорилт-5. Засгийн газраас эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон зээл, санхүүжилтийн эх үүсвэрийг хугацаанаас нь өмнө төлүүлэх, хямдруулан худалдах, дампуурсан банкнуудын эрх хүлээн авагчдаас авах төрийн байгууллагуудын авлагыг Монголбанканд шилжүүлэх зэргээр Засгийн газрын санхүүгийн нөөцийг нэмэгдүүлнэ. /ЗГҮАХХАХТ-ийн 3.3.15/	1
<b>7. Санхүү, хөрөнгө оруулалтын бодлого, зохицуулалт</b>		
	Зорилт-1. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, үндэсний үйлдвэрт бүтээгдэхүүнээ нийлүүлсэн малчид, тариаланчдад төрөөс урамшуулал олгоно. /ЗГҮАХХАХТ-ийн 3.3.11/	1

Дээрх 7 чиг үүргийн 23 зорилтуудаас харахад салбарын тэргүүлэх чиглэлд дараах үндсэн зорилтуудыг хэрэгжүүлэхээр тусгасан гэж үзэхээр байна. Үүнд:



### Газар тариалангийн салбарт:

- Тариалангийн тогтвортой үйлдвэрлэлийн хөгжлийг хангах, таримлын сэлгээ, тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх замаар салбарын бүтээмж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх
- ХАА-н тээвэр, борлуулалтын ложистикийн сүлжээг байгуулж, ХАА-ын бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн чанарын хяналт, баталгаажуулалтын оновчтой тогтолцоог бүрдүүлэх.
- Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр бүрэн хангах / улаан буудай, төмс, хүнсний ногоо/

### Мал аж ахуйн салбарт:

- Малын бэлчээрийн нөөцийг нэмэгдүүлэх, тогтвортой байдлыг хангах, бэлчээрийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах, бэлчээрийн доройтол, цөлжилтийг бууруулах
- Мал аж ахуйг байгаль цаг уурын эрсдлээс хамгаалах, бэлэн байдлыг хангах, сумдад өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх, малчдыг өвс тэжээл нөөцлөх сүлжээг бий болгох
- Мал эмнэлгийн тогтолцоог сайжруулах, халдварт, гоц халдварт өвчинтэй тэмцэх, гоц халдварт өвчингүй, тайван бүсийг баталгаажуулж, мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний экспортын боломжийг нээх.
- Малын чанар, ашиг шимийг сайжруулж, малын тоог чанарт шилжүүлж малын генийн санг хамгаалах, биотехнологийн ололтыг нэвтрүүлэх
- Эрчимжсэн мал аж ахуйн салбарын хөгжлийг дэмжих
- Хөдөө аж ахуйн тээвэр, борлуулалтын логистикийн сүлжээг байгуулж, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн чанарын хяналт, баталгаажуулалтын оновчтой тогтолцоог бүрдүүлэх

### Хүнсний салбарт:

- Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр бүрэн хангаж, махны экспортын хэмжээг нэмэгдүүлэх.

### Хөнгөн үйлдвэрийн салбарт:

- Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих замаар мах, ноос, ноолуур, арьс шир боловсруулах үйлдвэрийн бүтээмжийг нэмэгдүүлэх
- Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрийг бүсчилсэн байдлаар байгуулан нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн экспортлох.

### Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ, хоршооны салбарт:

- Жижиг, дунд үйлдвэр, бизнес эрхлэгчдэд орчин үеийн санхүүжилтийн хэлбэрүүдийг нэвтрүүлж, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг төрөөс бизнес инкубацын үйлчилгээгээр бойжуулж, томруулах бодлого хэрэгжүүлэх
- Төр хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлсан, байгаль орчинд ээлтэй, хүлэмжийн хий багатай ногоон төслүүдийн санхүүжилтийг нэмэгдүүлэх
- Засгийн газраас эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон зээл, санхүүжилтийн эх үүсвэрийг хугацаанд нь төлүүлэх, өр авлагыг цэгцэлж, салбарын санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх

**Салбарын санхүү, хөрөнгө оруулалтын бодлого зохицуулалтын хүрээнд:**

- Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, үндэсний үйлдвэрт бүтээгдэхүүнээ нийлүүлсэн малчид, тариаланчдад төрөөс урамшуулал олгох, ХАА-н татаас, дэмжлэгийн үр нөлөөтэй тогтолцоог бий болгох зэрэг болно.

Салбарын стратеги төлөвлөгөөнд тусгагдсан бодлогын тэргүүлэх чиглэлийн зорилтууд, түүний шалгуур үзүүлэлтүүд нь төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн үр дүнгийн үзүүлэлтүүдтэй хэрхэн уялдаж буйг доорх хүснэгтээр харуулав.

**Хүснэгт 8.** ХХААХҮ-ийн салбарын стратеги төлөвлөгөө ба ТЕЗ-ийн 2021 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн уялдаа

		Үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн тоо		Уялдаатай буюу ижил шалгуур үзүүлэлтийн тоо
		Салбарын 2021-2024 оны стратеги төлөвлөгөө	ТЕЗ-ийн 2021 оны хөтөлбөр	
1	Хөдөө аж ахуй, газар тариалан, аж үйлдвэрийн бодлого, удирдлага	1	1	1
2	Мал аж ахуйг хөгжүүлэх	25	4	1
3	Газар тариаланг хөгжүүлэх	41	2	
4	Хүнсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх	6	2	
5	Хөнгөн үйлдвэрийг хөгжүүлэх	4		
6	ЖДҮ, үйлчилгээ, хоршооны салбар	6	2	
7	Хөдөө аж ахуй, газар тариалан, аж үйлдвэрийн судалгаа шинжилгээ		1	
	<b>Нийт</b>	<b>83</b>	<b>12</b>	<b>2</b>

Дээрх хүснэгтээс харахад стратеги төлөвлөгөөнд үр дүнгийн нийт 83 шалгуур үзүүлэлт байгаа бол ТЕЗ-ийн 2021 онд хэрэгжүүлэх хөтөлбөрт 12 шалгуур үзүүлэлт байгаа бөгөөд эдгээрийн зөвхөн 2 нь ижил буюу харилцан уялдаатай гэж үзэж болохоор байна.

ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн үр дүнгийн үзүүлэлтүүд сүүлийн 4 жилд төдийлөн өөрчлөгдөөгүй бөгөөд 15 байсан үзүүлэлтийн тоог сүүлийн 2 жилд бууруулж 12 болгон төсвийн хуулийн 1-р хавсралтаар батласан байна.

**Хүснэгт 9.** Төсвийн тухай хуулийн 1-р хавсралт буюу ХХААХҮ-ийн сайдын хэрэгжүүлэх төсвийн хөтөлбөрийн үр дүнгийн үзүүлэлтүүд

Төсвийн эрх захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт	Зорилтот түвшин /төл./			
	2018	2019	2020	2021
Мал аж ахуй				
1. Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээ /сая толгой, давхардсан тоогоор/	56	65.2	82.6	58.7
2. Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх /өссөн хувиар/	-	20	20	3
3. Бэлчээрийн ургамал хамгаалал /мянган га/	750	720	1390	1066
4. Үндэсний үйлдвэрлэлд нийлүүлэх ноос /мянган тонн/	-	22	-	-
5. Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх /мян.толгой мал/	25	-	2318*	-



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН  
ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ШИНЖИЛГЭЭ

Газар тариалан				
1. Буудайн үйлдвэрлэлийг дэмжих /мянган тонн/	460	460	440	480
2. Төмс, хүнсний ногоо /мянган тонн/	269.5	280	270	290
3. Уриншилсан талбайн хэмжээ /мянган га/	390	-	-	-
4. Стандартын шаардлага хангасан жимс, жимсгэнэ тариалсан талбай /га/	7000	-	-	-
Хүнсний үйлдвэрлэл				
1. Хүн амын сүүний хэрэглээг үйлдвэрлэлийн аргаар боловсруулсан сүүний хангамжаар хангах /сая литр/	55	90	150	170
2. Үйлдвэрлэлийн аргаар боловсруулсан махны хэрэглээг нэмэгдүүлэх /мянган тонн/	15	14	20	50
Хөдөө аж ахуй, газар тариалангийн бодлого, удирдлага				
1. Улсын Их Хурал, Засгийн газраас баталсан шийдвэр, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх /тоогоор/	5	3	5	4
Хөдөө аж ахуй, газар тариалан, аж үйлдвэрийн судалгаа шинжилгээ				
1. Салбарын хэмжээнд хэрэгжүүлж дууссан нийгэм, эдийн засгийн чухал ач холбогдолтой, импортыг орлох, экспортыг дэмжих төслийн үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх	-	2	2	-
Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих, хөгжүүлэх, ажлын байр олгох				
1. Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төслийн тоо	100	150-200	200-250	450
2. Зээлийн батлан даалтын сангийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх /зээлдэгчийн тоо/	100-150	100-150	100-150	100-150

Эх үүсвэр: ХХААХҮЯ Тайлбар: \*-Сүүний үхрийн тоо

ХХААХҮЯ-ны 2021 оны төсвийн саналын төлөвлөлт болон урт болон дунд хугацааны хөтөлбөр, бодлогын баримт бичгийн зорилтуудтай хэрхэн уялдуулсан байдлыг Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөсөн жишээгээр доорх хүснэгтээр үзүүлэв.



**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН  
ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ШИНЖИЛГЭЭ**

**Хүснэгт 10. Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний төсвийн төлөвлөлт болон бодлогын зорилтын уялдаа /2021 оны төсвийн саналын жишээгээр/**

№	Урт болон дунд хугацааны хөтөлбөр, бодлогын баримт бичиг	Зорилт, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	2021 онд хүрэх түвшин, үр дүн	ХХААХҮЯ-ны 2021 оны төсвийн санал /сая төг/	Өргөн баригдсан	Тайлбар, Тооцоо
0	1	2	3	4	5	6	7
	Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээ				...	3,200.1	Хавсралт 3
	Халдварт өвчнөөс сэргийлэх арга хэмжээ, өвчнөөс эрүүлжсэнийг баталгаажуулах, нийтийн эрүүл мэндийг хамгаалах үйл ажиллагаа				7,065.3	3,200.1	
1	Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 33.1.2, 33.1.2.1, заалт, Монгол мал хөтөлбөрийн 3.3.1.1, 3.3.1.3, 3.3.2.4 зорилт, ЗГҮАХ-ийн 3.3.8.5	Малын халдварт өвчинтэй тэмцэх урьдчилан сэргийлэх вакцин худалдан авах	вакцин нэр төрлийн тоо	7	885.4	649.8	Мал сүргийг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтад шаардагдах вакцины зардал. Биокомбинат ТӨААТҮГ-аас 7 нэр төрлийн халдварт өвчнөөс сэргийлэх вакцин, 7 нэр төрлийн өвчнийг оношлох оношлуур авч орон нутагт нийлүүлж, 23.4 сая толгой малыг урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулснаар дээр халдварт өвчний оношилгоо хийгдэж, гаралтын тоо буурсан байна.
2		Малын халдварт өвчинтэй тэмцэх урьдчилан сэргийлэх үйлчилгээний хөлс /225 дугаар тогтоолын 1-р хавсралтын дагуу/	дархлаа тогтох хувь	80-аас доошгүй	5,930.0	2,550.4	7 нэр төрлийн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын арга хэмжээг санартай гүйцэтгэгдсэн байна. МУ-ын ЗГ-ын 225 тоот тогтоолын 1-р хавсралтанд заагдсан халдварт өвчнүүдээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг төсөвлөв.
3		Вакцин биобэлдмэлд мал эмнэлгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын лабораториор хянан баталгаажуулалт хийх	Дотоодын үйлдвэрийн вакцин, биобэлдмэлд баталгаажуулалтын шинжилгээ хийх нэр төрлийн тоо	7	250.0		Биокомбинат ТӨААТҮГ-аас 7 нэр төрлийн халдварт өвчнөөс сэргийлэх вакцин, 7 нэр төрлийн өвчнийг оношлох оношлуурт чанарын баталгаажуулалтын шинжилгээ хийж, шаардлага хангасан бүтээгдэхүүнийг нийлүүлэхэд шаардагдах зардал.

Дээрх хүснэгтээс харахад салбарын төсвийн төлөвлөлт хийхдээ урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгийн зорилго, зорилт, хууль заасан арга хэмжээ, эдгээрийн шалгуур үзүүлэлтүүдийг гарган, тооцоо судалгааны тайлбарыг хийсэн байна. Гэхдээ эдгээр шалгуур үзүүлэлтүүдийг дээр дурдсанчлан Төсвийн хуулийн 1-р хавсралтад тусгасан болон дунд хугацааны стратеги төлөвлөгөөний шалгуур үзүүлэлтүүд, ТХЗ-уудтай илүү уялдуулах шаардлагатай. Мөн шалгуур үзүүлэлтүүдийг сонгохдоо илүү үр дүнд чиглэсэн, аль болох хэмжиж болохуйц тооны болон чанарын шалгуур үзүүлэлтийг эрэмбэлж авч үзэх нь зүйтэй.

## 2.2 Тогтвортой хөгжлийн зорилтууд ба салбарын дунд хугацааны бодлогын зорилтын уялдаа

Мянганы хөгжлийн зорилгын үргэлжлэл болгож улс орнуудын төрийн тэргүүнүүд оролцсон НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 70 дугаар чуулганаар 2015 онд Тогтвортой хөгжлийн 17 зорилго (ТХЗ), 169 зорилтыг баталсан.

“Тогтвортой хөгжлийн зорилго-2030” нь нийгэм, эдийн засаг, байгаль орчин гэсэн гурван тулгуурт суурилан тогтвортой хөгжилд хүрэх дэлхийн нийтийн урт хугацааны бодлогын баримт бичиг юм. 2017 оны 3 сард НҮБ-ын Статистикийн комиссын 48-р чуулганаар ТХЗ-ын хэрэгжилтийг дүгнэх 244 шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон байна.

**Хүснэгт 11. Тогтвортой хөгжлийн зорилго, зорилтууд**

Зорилго	Зорилгын нэр	Зорилт	Үзүүлэлт
1	Ядуурлыг устгах	7	14
2	Өлсгөлөнг зогсоох	8	13
3	Эрүүл мэндийг дэмжих	13	27
4	Чанартай боловсролыг дэмжих	10	11
5	Жендэрийн эрх, тэгш байдлыг хангах	9	14
6	Баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах	8	11
7	Сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх	5	6
8	Эдийн засгийн өсөлт, баталгаат ажлын байрыг бий болгох	12	17
9	Инноваци болон дэд бүтцийг хөгжүүлэх	8	12
10	Тэгш бус байдлыг бууруулах	10	11
11	Ээлтэй хот, иргэдийн оролцоог дэмжих	10	15
12	Хариуцлагатай хэрэглээг дэмжих	11	13
13	Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах	5	8
14	Далай, тэнгисийн нөөцийг хамгаалах	10	10
15	Хуурай газрын эко системийг хамгаалах	12	14
16	Энх тайван, шударга ёсыг цогцлоох	12	23
17	Хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлэх	19	25
Бүгд		169	244

Монгол Улс НҮБ-ын Ерөнхий Ассамблейн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх үүднээс Тогтвортой хөгжлийн зорилгыг улс орныхоо хөгжлийн онцлогт нийцүүлэн үндэсний урт, дунд хугацааны бодлогын баримт, бичгүүдэд тусган хэрэгжүүлэх ажлыг үе шаттайгаар гүйцэтгэж байна.

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН  
ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ШИНЖИЛГЭЭ**

**Хүснэгт 12.** *Тогтвортой хөгжлийн зорилт болон манай орны бодлогын баримт бичгийн бүтэц, түүний уялдаа*

Бүтэц	Алсын хараа-2050	Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	ХХААХҮ-ийн салбарын 2021-2024 оны стратеги төлөвлөгөө	Тогтвортой хөгжлийн зорилт
Бүлэг			6		
Зорилго	9	9	23	7	17
Зорилт	47	47	259	23	169
Үйл ажиллагаа	965	243			
Арга хэмжээ			1058	73	
Шалгуур үзүүлэлт	73	95	203	95	244

Манай улсын хувьд ТХЗ-уудыг хангах үүднээс түүнд нийцүүлж “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулж 2020 онд УИХ-аас батлан хэрэгжүүлж байна.

ТХЗ-ууд, түүний шалгуур үзүүлэлтүүдээс ХХААХҮЯ-ны бодлогын түвшинд хариуцах нийт 10 зорилт, 17 шалгуур үзүүлэлт байна. Үүнийг доор хүснэгтээр үзүүлэв.

**Хүснэгт 13.** *ХХААХҮЯ-ны бодлогын түвшинд хариуцах ТХЗ-ууд ба шалгуур үзүүлэлтүүд*

	Зорилт	Үзүүлэлт	Хариуцах байгууллага	
			Үзүүлэлтийг хариуцан гаргах	Үзүүлэлтийг бодлогын түвшинд хариуцах
1	Зорилт 2.1 2030 он гэхэд ядуурлыг эцэс болгож, хүн бүрийг, ялангуяа ядуу болон эмзэг бүлгийн хүмүүс, түүний дотор нялхсыг эрүүл, шим тэжээллэг, хүрэлцэхүйц хоол хүнсийг жилийн турш авах боломжоор хангах	2.1.1 Хоол тэжээлийн дутагдлын тархалт (POU)	ҮСХ, ХХААХҮЯ	ХХААХҮЯ, ЭМЯ
		2.1.2 Хүнсний баталгаат байдлын алдагдлыг тооцох хэмжүүрт тулгуурласан хоол хүнсний дунд болон хүнд хэлбэрийн баталгаагүй хүн амын тархалт (FIES)	ҮСХ, ХХААХҮЯ	ХХААХҮЯ, ЭМЯ
2	Зорилт 2.3 Нэмүү өртөг шингээх, хөдөө аж ахуйн бус ажил эрхлэлтийг бий болгох үүднээс газар, үр ашигтай бусад баялаг, мэдээлэл мэдлэг, санхүүгийн үйлчилгээ, зах зээл, нөөц боломжийг ашиглах эрх тэгш, баталгаатай боломжийг бүрдүүлэх замаар жижиг хэмжээний хүнсний үйлдвэрлэгчид, ялангуяа нутгийн иргэд, гэр бүлийн фермерийн аж ахуй эрхлэгчид, малчид, загасны аж ахуй эрхлэгчдийн хөдөө аж ахуйн бүтээмж, орлогыг 2030 он гэхэд 2 дахин нэмэгдүүлэх	2.3.1.1 ажилтанд ногдох бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээ фермийн аж ахуй/бэлчээрийн мал аж ахуйн/ ойн аж ахуйн нэгжийн ангиллаар (тогтмол ам.доллараар хэмжигдэх)	ҮСХ, ХХААХҮЯ	ХХААХҮЯ
		2.3.2. Хоол хүнсний төрлийн жижиг үйлдвэрлэгчдийн дундаж орлого, хүйс, үндсэн засаг захиргаагаар	ҮСХ, ХХААХҮЯ	ХХААХҮЯ
3	Зорилт 2.5 2030 он гэхэд олон улс, бүс нутаг, үндэсний түвшний зохистой удирдлага, зохион байгуулалттай, олон төрлийн үр, ургамлын сантай банкаар дамжуулан үр, тариалах ургамал, фермерийн болон гэрийн тэжээвэр амьтан, тэдгээртэй холбоотой зэрлэг ан амьтдын генетикийн олон янз байдлыг хадгалж, олон улсын хэмжээнд тохиролцсоны дагуу генетикийн нөөц баялаг, уламжлалт холбогдох мэдлэгийг ашигласнаар гарах үр шимийг хүртэх, эрх тэгш, шударга зарчмаар солилцох нөхцөлийг бүрдүүлэх	2.5.1. Хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр ашиглахаар дунд болон урт хугацаанд зориулалтын хадгалалтын байгууламжид байсан ургамал, амьтны генетикийн нөөцийн хэмжээ	ХХААХҮЯ	ХХААХҮЯ
		2.5.2. Устах эрсдэлтэй, устах эрсдэлгүй, устах эрсдэлийн үл мэдэгдэх түвшинд байгаа дотоодын малын эзлэх хувь	ҮСХ, ХХААХҮЯ	ХХААХҮЯ

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН  
ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ШИНЖИЛГЭЭ

4	Зорилт 2.а Хөгжиж буй орнуудад, ялангуяа нэн буурай хөгжилтэй орнуудын хөдөө аж ахуйн бүтээмжийн чадамжийг сайжруулах үүднээс хөдөөгийн дэд бүтэц, хөдөө аж ахуйн судалгаа, хөдөө аж ахуйг өргөжүүлэх үйлчилгээ, технологийн хөгжил, ургамал болон малын гений банкны салбарт олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх	2.а.1. Засгийн газрын хөдөө аж ахуйд чиглэсэн Зардлын Индекс	ҮСХ, Сангийн яам	ХХААХҮЯ
		2.а.2. ХАА-н салбарт чиглэсэн албан ёсны гүйлгээ (хөгжлийн албан ёсны тусламж болон бусад албан ёсны гүйлгээ)	Сангийн яам	ХХААХҮЯ
5	Зорилт 2.б Дохагийн хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд бий болсон эрх үүргийн дагуу хөдөө аж ахуйн экспортын татаас, түүнтэй адил экспортын арга хэмжээний бүх хэлбэрийг нэгэн зэрэг халах замаар дэлхийн хөдөө аж ахуйн зах зээлд байгаа худалдааны хязгаарлалт, гажуудлаас урьдчилан сэргийлэх, тэдгээрийг засах	2.б.1 Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний экспортын татаас	Сангийн яам, Гаалийн ерөнхий газар	ХХААХҮЯ
6	Зорилт 5.а Үндэсний хууль тогтоомжид нийцүүлэн эмэгтэйчүүдэд эдийн засгийн тэгш эрх, түүнчлэн газар болон бусад хэлбэрийн эд хөрөнгө өмчлөх, захиран зарцуулах, санхүүгийн үйлчилгээ, өв залгамжлах, байгалийн баялгаас хүртэх боломжийг олгох шинэчлэлийг хэрэгжүүлэх	5.а.1 а) Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалттай газрын эзэд, газар эзэмших, ашиглах эрх бүхий хүн амын (ХАА-д ажилладаг нийт хүмүүсийн дотор) эзлэх хувь, хүйсээр, б)газар эзэмшигч, эрх бүхий эмэгтэйчүүдийн эзлэх хувь, эзэмшлийн хэлбэр болон эзэмшсэн хугацаагаар	ҮСХ, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар	ХХААХҮЯ
		5.а.2 Эмэгтэйчүүдийн эдлэн газар эзэмших, ашиглах эрхийг баталгаажуулсан, хамгаалсан тусгай арга хэмжээ бүхий хуультай орнуудын эзлэх хувь	ХЗДХЯ	ХХААХҮЯ
7	Зорилт 9.2 Хүртээмжтэй, тогтвортой аж үйлдвэржилтийг хөхүүлэн дэмжиж, 2030 он гэхэд үндэсний нөхцөл байдалтай уялдуулан ДНБ-нд аж үйлдвэрийн салбарын ажлын байрны эзлэх хувийг үлэмж хэмжээгээр нэмэгдүүлж, нэн буурай хөгжилтэй орнуудад энэ хувийг хоёр дахин өсгөх	9.2.1 ДНБ болон нэг хүнд ногдох ДНБ-нд аж үйлдвэрийн салбарын нэмүү өртгийн эзлэх хувь	ҮСХ	ХХААХҮЯ
		9.2.2 Нийт ажил эрхлэлтэд үйлдвэрлэлийн салбарын ажлын байрны эзлэх хувь	ҮСХ	ХХААХҮЯ, ХНХЯ
8	Зорилт 9.3 Жижиг хэмжээний аж үйлдвэрийн болон бусад салбарын аж ахуй нэгжүүд, ялангуяа хөгжиж буй орнуудын эдгээр аж ахуй нэгжүүдийн санхүүгийн үйлчилгээ авах, түүний дотор хямд зээл авах, үйлдвэрлэл, зах зээл нэвтрэх боломжийг нэмэгдүүлэх	9.3.1 Нийт үйлдвэрлэлийн нэмүү өртөгт жижиг дунд үйлдвэрлэлийн эзлэх хувь	ҮСХ, ХХААХҮЯ, Оюуны өмч, Улсын бүртгэлийн ерөнхий газар	ХХААХҮЯ
		9.3.2 Зээлтэй ЖДҮ-ийн эзлэх хувь	Монгол банк	ХХААХҮЯ
9	Зорилт 9.4 2030 он гэхэд нөөц баялгийн хэрэглээний үр ашгийг нэмэгдүүлж, цэвэр, байгальд ээлтэй технологи, үйлдвэрлэлийн ажиллагааг нэвтрүүлж, бүх улс орнууд өөрсдийн нөөц чадавхдаа уялдуулан арга хэмжээ авч хэрэгжүүлж, аж үйлдвэрийн тогтвортой ажиллагааг хангах зорилгоор дэд бүтцийг хөгжүүлж, аж үйлдвэрийг боловсронгуй болгох	9.4.1 Нэмүү өртгийн үйлдвэрлэлийн нэгжид ноогдох нүүрстөрөгчийн ялгарал	ҮСХ, Сангийн яам	ХХААХҮЯ
10	Зорилт 12.3 2030 он гэхэд жижиглэн худалдааны болон хэрэглээний түвшинд нэг хүнд ногдох дэлхийн хүнсний хаягдлыг хоёр дахин багасгаж, үйлдвэрлэлийн болон нийлүүлэлтийн тогтолцоотой холбоотойгоор гарах хүнсний алдагдал, түүний дотор ургац хураалтын дараах алдагдлыг бууруулах	12.3.1 Дэлхийн хүнсний алдагдлын индекс	ХХААХҮЯ, ЭМЯ	ХХААХҮЯ, ЭМЯ

Эдгээр ТХЗ-ууд болон салбарын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөний зорилтуудын уялдааг доорх Хүснэгт 29-д харууллаа. Хүснэгт 29-аас харахад Тогтвортой хөгжлийн нийт 10 зорилтоос 7 нь салбарын стратеги төлөвлөгөөнд бүрэн уялдаж туссан, 3 нь бүрэн бус боловч

## ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ШИНЖИЛГЭЭ

тодорхой хэмжээнд туссан гэж үзэж болохоор байна. Огт тусгаагүй зорилт байхгүй болно.

Харин тус яамны бодлогын түвшинд хариуцах ТХЗ-ын нийт 17 шалгуур байгаа ба эдгээрээс салбарын стратеги төлөвлөгөө болон ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтүүдтэй ижил буюу уялдаатай шалгуур үзүүлэлт байхгүй байна.

Иймд цаашид салбарын дунд хугацааны стратеги төлөвлөгөөг тодотгож ТХЗ-ууд болон Монгол улсын “Алсын хараа -2050”-ын зорилтуудын шалгуур үзүүлэлтүүдтэй аль болох уялдуулж, улмаар Төсвийн хуулийн 1-р хавсралтанд тусгагддаг шалгуур үзүүлэлтүүдтэй нийцүүлэх нь зүйтэй.



Хүснэгт 14. ТХЗ-ууд ба салбарын стратеги төлөвлөгөөний уялдаа

Тогтвортой хөгжлийн зорилго, зорилтууд	Салбарын бодлогын баримт бичиг: ХХААХҮ-ийн салбарын 2021-2024 оны стратеги төлөвлөгөө	ТХЗ-ууд ба салбарын стратеги төлөвлөгөөнд туссан зорилтуудын харьцуулалт			Тайлбар
		бүрэн туссан	бүрэн бус туссан	огт тусгаагүй	
Зорилго 2. Өлсгөлөнг эцэс болгож, хүнсний аюулгүй байдлыг хангаж, хоол тэжээл байдлыг сайжруулж, тогтвортой хөдөө аж ахуйг хөгүүлэн дэмжих	ТХЗ-уудтай уялдах зорилго, зорилтууд				
1	Зорилт 2.2 2025 он гэхэд 5 хүртэлх насны өсөлтийн хоцролттой, туранхай хүүхдийн талаар олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрсөн зорилтуудад хүрэх замаар хоол тэжээлийн дутлын бүх хэлбэрийг арилгаж, өсвөр насны охид, жирэмсэн болон хүүхдээ хөхөөрөө хооллож буй эмэгтэйдүүд, өндөр настайчуудын хоол тэжээлийн хэрэгцээг 2030 он гэхэд хангах		ТИЙМ		Зорилгот бүлгийг илүү тодорхой тусгаагүй, ерөнхий байдлаар тусгасан
2	Зорилт 2.3 Нэмүү өртөг шингээх, хөдөө аж ахуйн бус ажил эрхлэлийг бий болгох үүднээс газар, үр ашигтай бусад баялаг, мэдээлэл мэдлэг, санхүүгийн үйлчилгээ, зах зээл, нөөц боломжийг ашиглах эрх тэгш, баталгаатай боломжийг бүрдүүлэх замаар жижиг хэмжээний хүнсний үйлдвэрлэгчид, ялангуяа нутгийн иргэд, гэр бүлийн фермерийн аж ахуй эрхлэгчид, малчид, загасны аж ахуй эрхлэгчдийн хөдөө аж ахуйн бүтээмж, орлогыг 2030 он гэхэд 2 дахин нэмэгдүүлэх	Зорилт-1. Гол нөрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр бүрэн хангаж, махны экспортын хэмжээг нэмэгдүүлнэ.			
		Зорилт-2. Атрын IV аяныг хэрэгжүүлж, тариалангийн тогтвортой үйлдвэрлэлийн хөгжлийг хангах, таримлын сэлгээ, тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх замаар салбарын бүтээмж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.			
		Зорилт-1. Балчээрийг усжуулах, худагжуулах ажлыг үргэлжлүүлэн малын балчээрийн нөөцийг нэмэгдүүлэх, тогтвортой байдлыг хангах, малын чанар, ашиг шимийг сайжруулж, малын тоог чанарт шилжүүлж малын генийн санг хамгаалах, биотехнологийн ололтыг нэвтрүүлэх, эрчимжсэн мал аж ахуйн салбарын хөгжлийг дэмжиж, "Монгол мал-II" хөтөлбөр хэрэгжүүлнэ.			
		Зорилт-3. Малчдыг дэмжих анхдугаар аян зохион байгуулж, мал сүргийг гэмт халдлагаас хамгаалж, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрийг бусчилсэн байдлаар байгуулан нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн экспортолж, малчид, иргэдийн орлогыг нэмэгдүүлнэ.	ТИЙМ		
		Зорилт-1. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, үндэсний үйлдвэрт бүтээгдэхүүнээ нийлүүлсэн малчид, тариаланчдад төрөөс урамшуулал олгоно			
		Зорилт-6. Хөдөө аж ахуйн тзвэр, борлуулалтын логистикийн сүлжээг байгуулж, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн чанарын хяналт, баталгаажуулалтын оновчтой тогтолцоог бүрдүүлнэ.			



**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ШИНЖИЛГЭЭ**

<p>Зорилт 2.5.2030 он гэхэд олон улс, бүс нутаг, үндэсний түвшний зоохистой удирдлага, зохион байгуулалттай, олон төрлийн үр, ургамлын сантай банкаар дамжуулан үр, тариалах ургамал, фермерийн болон гэрийн тэжээвэр амьтан, тэдгээртэй холбоотой зэрлэг ан амьтдын генетикийн олон янз байдлыг хадгалж, олон улсын хэмжээнд тохиролцсоны дагуу генетикийн нөөц баялаг, уламжлалт холбогдох мэдлэгийг ашигласнаар гарах үр шимийг хүртэх, эрх тэгш, шударга зарчмаар солилцох нөхцөлийг бүрдүүлэх</p>	<p>Зорилт-2. Атрын IV аяныг хэрэгжүүлж, тариалангийн тогтвортой үйлдвэрлэлийн хөгжлийг хангах, таримлын сэлгээ, тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх замаар салбарын бүтээмж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.</p> <p>Зорилт-1. Бэлчээрийг усжуулах, худагжуулах ажлыг үргэлжлүүлэн малын бэлчээрийн нөөцийг нэмэгдүүлэх, тогтвортой байдлыг хангах, малын чанар, ашиг шимийг сайжруулж, малын тоог чанарт шилжүүлж малын генийн санг хамгаалах, биотехнологийн ололтыг нэвтрүүлэх, эрчимжсэн мал аж ахуйн салбарын хөгжлийг дэмжиж, "Монгол мал-I" хөтөлбөр хэрэгжүүлнэ.</p> <p>Зорилт-1. Арга хэмжээ-3: Үржлийн хээлтүүлэгч, цөм сүргийн хээлтэгч, төвийн бүсийн үхэр сүргийг ялган тэмдэглэж, бүртгэл мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх.</p> <p>Арга хэмжээ-4: Баталгаажсан үүлдэр, омгийн малын үрийг авах, генийн санг хамгаалах, биотехнологийн ололтыг нэвтрүүлэх.</p>	<p>Зорилт-2. Атрын IV аяныг хэрэгжүүлж, тариалангийн тогтвортой үйлдвэрлэлийн хөгжлийг хангах, таримлын сэлгээ, тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх замаар салбарын бүтээмж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.</p> <p>Зорилт-3. Газар тариалан, хөдөө аж ахуйн төв, Дархан, Сэлэнгэ бүс нутгийн агротехникийн засвар үйлчилгээний төв байгуулах ажлыг хэрэгжүүлнэ.</p> <p>Зорилт-1. Бэлчээрийг усжуулах, худагжуулах ажлыг үргэлжлүүлэн малын бэлчээрийн нөөцийг нэмэгдүүлэх, тогтвортой байдлыг хангах, малын чанар, ашиг шимийг сайжруулж, малын тоог чанарт шилжүүлж малын генийн санг хамгаалах, биотехнологийн ололтыг нэвтрүүлэх, эрчимжсэн мал аж ахуйн салбарын хөгжлийг дэмжиж, "Монгол мал-I" хөтөлбөр хэрэгжүүлнэ.</p> <p>Зорилт-3. Малчдыг дэмжих анхдугаар аян зохион байгуулж, мал сүргийг гэмт халдлагаас хамгаалж, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрийг бүсчилсэн байдлаар байгуулан нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн экспортлож, малчид, иргэдийн орлогыг нэмэгдүүлнэ.</p>	<p>Тийм</p>	<p>гэрийн тэжээвэр амьтан, зэрлэг ан амьтан зэргийг тусгаагүй</p>
<p>Зорилт 2.а Хөгжиж буй орнуудад, ялангуяа нэн буурай хөгжилтэй орнуудын хөдөө аж ахуйн бүтээмжийн чадамжийг сайжруулах үүднээс хөдөөгийн дэд бүтэц, хөдөө аж ахуйн судалгаа, хөдөө аж ахуйг өргөжүүлэх үйлчилгээ, технологийн хөгжил, ургамал болон малын гений банкны салбарт олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх</p>	<p>Зорилт-2. Атрын IV аяныг хэрэгжүүлж, тариалангийн тогтвортой үйлдвэрлэлийн хөгжлийг хангах, таримлын сэлгээ, тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх замаар салбарын бүтээмж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.</p> <p>Зорилт-3. Газар тариалан, хөдөө аж ахуйн төв, Дархан, Сэлэнгэ бүс нутгийн агротехникийн засвар үйлчилгээний төв байгуулах ажлыг хэрэгжүүлнэ.</p> <p>Зорилт-1. Бэлчээрийг усжуулах, худагжуулах ажлыг үргэлжлүүлэн малын бэлчээрийн нөөцийг нэмэгдүүлэх, тогтвортой байдлыг хангах, малын чанар, ашиг шимийг сайжруулж, малын тоог чанарт шилжүүлж малын генийн санг хамгаалах, биотехнологийн ололтыг нэвтрүүлэх, эрчимжсэн мал аж ахуйн салбарын хөгжлийг дэмжиж, "Монгол мал-I" хөтөлбөр хэрэгжүүлнэ.</p>	<p>Зорилт-2. Атрын IV аяныг хэрэгжүүлж, тариалангийн тогтвортой үйлдвэрлэлийн хөгжлийг хангах, таримлын сэлгээ, тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх замаар салбарын бүтээмж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.</p> <p>Зорилт-3. Газар тариалан, хөдөө аж ахуйн төв, Дархан, Сэлэнгэ бүс нутгийн агротехникийн засвар үйлчилгээний төв байгуулах ажлыг хэрэгжүүлнэ.</p> <p>Зорилт-1. Бэлчээрийг усжуулах, худагжуулах ажлыг үргэлжлүүлэн малын бэлчээрийн нөөцийг нэмэгдүүлэх, тогтвортой байдлыг хангах, малын чанар, ашиг шимийг сайжруулж, малын тоог чанарт шилжүүлж малын генийн санг хамгаалах, биотехнологийн ололтыг нэвтрүүлэх, эрчимжсэн мал аж ахуйн салбарын хөгжлийг дэмжиж, "Монгол мал-I" хөтөлбөр хэрэгжүүлнэ.</p>	<p>Тийм</p>	<p>гэрийн тэжээвэр амьтан, зэрлэг ан амьтан зэргийг тусгаагүй</p>





ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН  
ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ШИНЖИЛГЭЭ

			<p>Зорилт-5. Мал эмнэлгийн тогтолцооны шинэчлэлийг төгөлдөржүүлж, халдварт, гоц халдварт өвчинтэй тэмцэх, гоц халдварт өвчингүй, тайван бүсийг баталгаажуулж, мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний экспортын боломжийг нээнэ.</p>				
			<p>Зорилт-6. Хөдөө аж ахуйн тээвэр, борлуулалтын логистикийн сүлжээг байгуулж, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн чанарын хяналт, баталгаажуулалтын оновчтой тогтолцоог бүрдүүлнэ.</p>				
			<p>Зорилт-6. Хөдөө аж ахуйн тээвэр, борлуулалтын логистикийн сүлжээг байгуулж, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн чанарын хяналт, баталгаажуулалтын оновчтой тогтолцоог бүрдүүлнэ.</p>				
			<p>Зорилт-1. Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр бүрэн хангаж, махны экспортын хэмжээг нэмэгдүүлнэ.</p>				
5							

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН  
ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ШИНЖИЛГЭЭ

<p>Зорилт-2. Жижиг, дунд үйлдвэр, бизнес эрхлэгчдэд орчин үеийн санхүүжилтийн хэлбэрүүдийг нэвтрүүлж, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг төрөөс бизнес инкубацийн үйлчилгээгээр бойжуулж, томруулах бодлого хэрэгжүүлнэ. СХБТ: Зорилт-1. Салбарын хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох;</p>	<p>Тийм</p>				<p>тодорхой зааж тусгаагүй</p>
<p>Зорилт-2. Жижиг, дунд үйлдвэр, бизнес эрхлэгчдэд орчин үеийн санхүүжилтийн хэлбэрүүдийг нэвтрүүлж, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг төрөөс бизнес инкубацийн үйлчилгээгээр бойжуулж, томруулах бодлого хэрэгжүүлнэ. СХБТ: Зорилт-1. Салбарын хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох;</p>	<p>Тийм</p>				<p>Тийм</p>
<p>Зорилт-2. Жижиг, дунд үйлдвэрүүдийг дэмжих, ажлын байр бий болгох, үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих зээл, санхүүжилтийн бодлого хэрэгжүүлэх;</p>	<p>Тийм</p>				<p>Тийм</p>
<p>Зорилт-4. Бүтээгдэхүүнээ экспортод гаргасан аж ахуйн нэгжийг тусгайлан дэмжих “Экспортын баталгааны сан” байгуулж ажиллуулна.</p>	<p>Тийм</p>				<p>Тийм</p>
<p>Зорилт-2. Мал, малын гаралтай түүхий эдийг боловсруулах байгальд ээлтэй цогцолбор байгуулж, хөдөө аж ахуйн гаралтай бараа, бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлнэ.</p>	<p>Тийм</p>				<p>Тийм</p>
<p>Зорилт-6. Хөдөө аж ахуйн тзвээр, борлуулалтын логистикийн сүлжээг байгуулж, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн чанарын хяналт, баталгаажуулалтын оновчтой тогтолцоог бүрдүүлнэ.</p>	<p>Тийм</p>				<p>Тийм</p>
<p>Арга хэмжээ-4: Мал амьтан, ургамлын гаралтай органик хүнсний баталгаажуулан, худалдааны түнш орнуудад хүлээн зөвшөөрүүлэх;</p>	<p>Тийм</p>				<p>Тийм</p>
<p>Зорилт-2. Атрын IV аяныг хэрэгжүүлж, тариалангийн тогтвортой үйлдвэрлэлийн хөгжлийг хангах, таримлын сэлгээ, тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх замаар салбарын бүтээмж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.</p>	<p>Тийм</p>				<p>Тийм</p>
<p>Зорилт-4. Бүтээгдэхүүнээ экспортод гаргасан аж ахуйн нэгжийг тусгайлан дэмжих “Экспортын баталгааны сан” байгуулж ажиллуулна. Арга хэмжээ: Экспортод чиглэсэн нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд дэмжлэг үзүүлэх / хөнгөлөлттэй зээл, зээлийн батлан даалт/.</p>	<p>Тийм</p>				<p>Тийм</p>
<p>Зорилт-2. Мал, малын гаралтай түүхий эдийг боловсруулах байгальд ээлтэй цогцолбор байгуулж, хөдөө аж ахуйн гаралтай бараа, бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлнэ.</p>	<p>Тийм</p>				<p>Тийм</p>




### 3. САЛБАРЫН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ХАНДЛАГА

#### 3.1 Салбарын төсвийн нийт зарлагын түвшин, хандлага

ХХААХҮ-ийн салбар нь 2020 оны байдлаар Монгол улсын ДНБ-ий 32.5 хувийг, нийт экспортын 5.6 хувийг, нийт ажиллагсадын 50 гаруй хувийг тус тус бүрдүүлж байна. ХХААХҮ-ийн сайдын төсвийн нийт зарлагыг сүүлийн 10 жилийн дунджаар /2011 оны үл оролцуулсан/ авч үзвэл ДНБ-ий 0.8 хувь, Монгол улсын нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн 2.2 хувь, улсын төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн 2.9 хувийг тус тус эзэлж байна.

Бусад улс орнуудтай харьцуулж үзвэл Монгол улсын хувьд төсвийн нийт зарлагад хөдөө аж ахуйн салбарын төсвийн зарлагын эзлэх хувь дэлхийн дундаж орчимд байгаа бөгөөд Ази, Африк далайд гарцгүй хөгжиж буй орнуудын дунджаас болон бүс нутгийн хөгжиж буй орнуудын дунджаас доогуур түвшинд байна<sup>2</sup> (Зураг 14).

**Зураг 14.** Улс орнуудын төсвийн нийт зарлагад ХАА-ын салбарын төсвийн зарлагын эзлэх хувь




Эх үүсвэр: НҮБ-ын ХХААБ, <http://www.fao.org/faostat/en/#data/IG/metadata>

2011 оны хувьд жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрт 176.8 тэрбум төгрөг, ноолуурын үйлдвэрлэл эрхэлж буй ААН-үүдэд 130.0 тэрбум төгрөгийн зээлийн эх үүсвэр хуваарилсан нь салбарын төсвийг харьцангуй өндөр дүнтэй харагдуулж байна. /Зураг 15/

<sup>2</sup> -Food and Agriculture Organization of the United Nations (FAO), <http://www.fao.org/faostat/en/#data/IG/metadata>

**Зураг 15. ХХААХҮ-ийн сайдын багцын төсвийн нийт зарлага /дүнд эзлэх хувиар/**



Эх үүсвэр: СЯ, ХХААХҮЯ

Зураг 15-аас харахад ХХААХҮ-ийн салбарын төсвийн нийт зарлагын түвшин 2012 оноос хойш төдийлөн өөрчлөгдөөгүй байна.

Салбарын төсвийн нийт зарлагын бүтцийг сүүлийн 10 жилээр авч үзвэл салбарыг дэмжих чиглэлээр тухайн үеийн төр, засгийн бодлого, шийдвэрээс хамааран жилээс жилд ихээхэн өөрчлөгдөж ирсэн байна. Тухайлбал, 2011 онд ЖДҮ-ийг дэмжих хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрт ихээхэн хөрөнгө хуваарилснаар тухайн жилийн салбарын төсвийн нийт хэмжээ болон бүтэц ихээхэн өөр байгаа бөгөөд хөнгөлөлттэй зээл буюу эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл нийт багцын 63.8 хувийг бүрдүүлсэн байна.


Мөн 2020 онд Засгийн газраас малчдын орлогыг нэмэгдүүлэх болон үндэсний үйлдвэрүүдийг дэмжих зорилгоор ноолуурын нэг кг тутамд 20 000 төгрөгийн урамшууллыг олгох арга хэмжээ авсан бөгөөд үүнд ХХААХҮ-ийн сайдын багцад нийт 174.9 тэрбум төгрөг хуваарилсан. Үүний дүнд салбарын төсвийн урсгал шилжүүлгийн хэмжээ энэ хэмжээгээр нэмэгдэж салбарын төсвийн бүтцэд ихээхэн өөрчлөлт орсон харагдаж байна /Зураг 16/.

Энэ нь 2020 оны ХХААХҮ-ийн салбарын төсвийн нийт зарлагын тэн хагас буюу 50.8 хувийг эзэлсэн байна. Зураг 16-с харахад салбарын төсвийн нийт хэмжээ болон бүтэц нь сүүлийн 10 жилд татаас, урсгал шилжүүлэг, эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлээс голчлон хамаарч өсч, буурсан дүр зураг харагдаж байна.

Урсгал шилжүүлэгт малчдад олгосон ноос, ноолуурын урамшуулал, улаан буудайн урамшуулал гол дүнтэй байсан бол эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл бүхэлдээ ЖДҮ-т олгох хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэр, түүний эргэн төлөлтөөс бүрдэж байна.



Зураг 16. ХХААХҮ-ийн салбарын төсвийн нийт зарлага, түүний бүтэц /сая төгрөгөөр/



Эх үүсвэр: ХХААХҮЯ

ХХААХҮ-ийн салбарын төсвийн зарлагын бүтцийг эдийн засгийн ангилалаар авч үзвэл 2020 оны байдлаар нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 345.9 тэрбум төгрөг байгаа бөгөөд үүний 325.5 тэрбум төгрөг буюу 94.1 хувийг урсгал зардал, 20.5 тэрбум төгрөг буюу 5.9 хувийг хөрөнгийн зардал эзэлж байна.

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ШИНЖИЛГЭЭ

Хүснэгт 15. ХХААХҮ-ийн салбарын төсвийн зарлага, эдийн засгийн ангиллаар, сая төгрөгөөр.

	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	130,626.2	514,162.3	180,731.6	177,977.9	134,838.8	57,417.0	142,178.4	272,486.4	172,524.4	167,233.9	347,881.1
Урсгал зардал	81,699.9	92,117.7	78,753.4	93,451.8	101,518.4	89,933.4	113,519.1	99,505.5	102,616.9	121,728.0	307,824.4
Бараа, үйлчилгээний зардал	37,322.1	65,465.1	34,039.3	41,195.9	50,544.8	36,043.3	63,696.2	44,858.6	51,016.7	71,503.4	67,765.1
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	3,519.4	4,134.0	6,481.8	8,508.3	9,445.6	9,055.2	9,621.3	10,511.0	9,687.7	11,129.3	13,302.9
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	390.6	469.8	721.6	962.3	1,066.7	1,004.7	1,038.5	1,190.4	1,177.4	1,403.3	1,756.4
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	648.0	688.5	741.8	897.3	968.1	946.6	1,217.6	1,184.3	1,331.7	1,455.6	1,587.3
Хангамж, бараа материалын зардал	453.3	673.4	694.1	1,316.4	755.6	451.3	494.4	596.2	695.6	1,478.1	1,289.1
Нормативт зардал	4,848.5	10,974.7	7,165.1	6,440.9	9,769.8	8,460.2	22,377.9	11,441.4	16,094.7	13,139.8	12,193.6
Эд хогшил, урсгал засварын зардал	247.0	5,576.9	4,121.2	1,829.8	573.0	306.1	297.2	389.6	489.1	2,555.5	1,671.4
Томилголт, зочны зардал	271.6	327.8	602.4	629.2	559.3	360.6	259.7	514.9	488.6	523.8	433.6
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, Хураамж	12,460.0	13,656.5	12,744.5	14,282.7	9,066.9	10,092.6	26,215.7	17,494.4	17,260.2	38,131.8	34,934.1
Бараа үйлчилгээний бусад зардал	14,483.7	28,963.5	766.7	6,329.1	18,339.9	5,365.9	2,173.9	1,536.4	3,791.7	1,686.1	596.7
Татаас	12,643.7	26,361.5	44,255.2	51,274.5	49,998.6	53,040.4	48,715.5	53,313.4	50,471.0	48,524.1	62,560.2
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	-	-	-	-	-	65.1	-	-	-	-	1,183.0
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	12,643.7	26,361.5	44,255.2	51,274.5	49,998.6	52,975.3	48,715.5	53,313.4	50,471.0	48,524.1	61,377.1
Урсгал шилжүүлэг	31,734.0	291.1	458.9	981.3	975.0	849.7	1,107.4	1,333.6	1,129.3	1,700.5	177,499.1
Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-	-	126.3	186.5	186.5	205.4	277.4	349.2	564.6	707.2
Бусад урсгал шилжүүлэг	31,734.0	291.1	458.9	855.0	788.5	663.2	902.0	1,056.2	780.1	1,135.9	176,791.9
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	30,990.0	-	-	-	-	-	277.0	277.0	264.4	277.0	175,352.6
Хөрөнгийн зардал	35,646.6	62,641.9	76,994.1	54,156.7	50,256.2	4,832.1	22,974.2	48,939.2	27,617.3	40,163.7	20,585.5
Барилга байгууламж	33,490.8	46,400.5	44,622.6	34,430.3	34,843.5	3,547.1	7,198.8	22,868.0	18,890.8	21,877.0	6,118.3
Их засвар	238.7	655.3	881.7	1,288.7	817.7	28.4	-	20.5	185.9	-	1,103.1
Тоног төхөөрөмж	600.0	10,364.8	13,237.1	577.8	7,245.0	638.6	9,534.1	1,853.2	4,066.9	6,403.3	1,036.8
Бусад хөрөнгө	1,317.2	-	-	-	-	-	-	3,427.9	-	-	-
Стратегийн нөөц хөрөнгө	-	5,221.4	18,252.7	17,859.8	7,349.9	618.0	6,241.3	20,769.6	4,473.7	11,883.5	12,327.3
Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	12,531.6	359,402.7	24,984.0	30,369.5	(16,935.8)	(37,348.5)	5,685.1	124,041.7	42,290.2	5,342.3	19,471.3
Эргэж төлөгдөх зээл	12,531.6	359,402.7	24,984.0	30,369.5	(17,855.4)	(39,171.8)	5,384.0	123,254.4	42,290.2	5,342.3	19,471.3
Гадаадын төслийн зээлээс санхүүжих	-	-	-	-	919.6	1,823.3	301.1	787.3	-	-	-
Гадаадын төслийн зээлээс санхүүжих :	-	-	-	-	919.6	1,823.3	301.1	787.3	-	-	-

Эх үүсвэр: СЯ, ХХААХҮЯ

## 3.2 Салбарын төсвийн зарлагын бүтэц

### 3.2.1 Төсвийн зарлагын бүтэц, эдийн засгийн ангиллаар

Төсвийн тухай хуулийн 22-р зүйлд зааснаар Монгол улсын төсвийг шатлалаар, төсвийн захирагчаар, эдийн засгийн ангиллаар, хөтөлбөрөөр, арга хэмжээгээр, санхүүжүүлэх эх үүсвэрээр нь тус тус ангилж, төлөвлөлт, тайлагналт, статистик, судалгаанд ашиглаж байна.

Мөн Сангийн сайдын 2015 оны 7-р тушаалаар Төсвийн ангилалыг батлан мөрдөж байна. Төсвийн зарлагын Эдийн засгийн ангиллыг дотор нь 3 төрөлд хувааж авч үздэг. Эдийн засгийн ангилалаар төсвийн зарлага нь урсгал зардал, хөрөнгийн зардал, эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлээс бүрдэж байна.


Урсгал зардал гэдэг нь төсвийн санхүүжилтийн өдөр тутмын хэрэглээнд дахин ашиглагдахгүйгээр нэг удаа зарцуулах зардлуудыг хэлнэ. Төсвийн урсгал зардал нь төрийн болон орон нутгийн засаг захиргааны байгууллагын үйл ажиллагааг санхүүжүүлэх, төсөвт байгууллагууд, төрийн үйлчилгээг хэвийн үзүүлэх, эдийн засгийн тодорхой салбарт төрөөс санхүүжилт олгох, татаас өгөх, санхүүгийн тусламж үзүүлэхэд гарах зардлын төрөл юм.

Хөрөнгийн зардал гэдэг нь үндсэн капитал ба нөөцийн өсөлтийг бий болгохтой холбогдон гарах төсвийн зардал болно. Хөрөнгийн зардал нь хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг санхүүжүүлэх шинж чанартай байна.

Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл нь улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд чиглэсэн шаардлагатай зардлыг төсвөөс хөнгөлөлттэй нөхцөлөөр санхүүжүүлэх үйл ажиллагаа болно. Нөгөө талаас, төсвөөс олгосон хөрөнгийн ашиглалтын эцсийн үр дүнг сайжруулах үүднээс эргүүлж төлөх нөхцөлтэйгээр санхүүжүүлдэг бөгөөд энэхүү төлбөрийг хассан цэвэр дүнгээр улсын төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийг гаргадаг.

Салбарын төсвийн нийт зарлагын бүтцийг эдийн засгийн ангиллаар буюу урсгал зардал, хөрөнгийн зардал болон эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлийн ерөнхий дүнгээр сүүлийн 10 жилээр Зураг 17-д харууллаа.

**Зураг 17.** ХХААХҮ-ийн салбарын төсвийн нийт зарлагын бүтэц, сая төгрөгөөр






## ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ШИНЖИЛГЭЭ

Салбарын төсвийн нийт зардалд урсгал болон хөрөнгийн зардал, эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлийн дүнгийн эзлэх хувийг Зураг 18-д үзүүлэв. Зураг.18-аас харахад эдгээр зардлын салбарын төсвийн нийт зарлагад эзлэх хувь 2010 оноос хойш ихээхэн өөрчлөгдөж ирсэн байна. Тухайлбал урсгал зардлын эзлэх хувь 2010 онд 62.9 хувийг эзэлж байсан бол 2011 онд 17.9 хувь болж буурсан ба 2020 оны байдлаар 88.5 хувийг эзэлж байна. Энэ нь салбарын төсөвт тухайн жилийн татаас, шилжүүлэг, эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлийн эзлэх хувь хэмжээ ихээхэн өөр байснаас голчлон хамаарч байна. Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл 2014, 2015 онд хасах утгатай байгаа нь тухайн жилүүдэд төсвийн зээлийн эх үүсвэрийн санхүүжилтээс эргэж төлөгдөх төлбөрийн хэмжээ илүү байсантай холбоотой.

**Зураг 18.** ХХААХҮ-ийн салбарын төсвийн зарлагын бүтэц, дүнд эзлэх хувиар




Эх үүсвэр: СЯ, ХХААХҮЯ

### 3.2.1 Урсгал зардал

Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллаар урсгал зардалд бараа, үйлчилгээний зардал, татаас, урсгал шилжүүлэг орж байгаа бөгөөд сүүлийн 10 жилд ХХААХҮ-ийн салбарын нийт төсвийн зарлагын 17.9-94.1 хувийг урсгал зардал эзэлж байна. Тухайлбал 2011 онд урсгал зардал салбарын нийт төсвийн зардлын 17.9 хувийг эзэлж байсан бол 2020 онд 88.5 хувийг эзэлж, ихээхэн хэлбэлзэлтэй явж ирсэн нь харагдаж байна.

Зураг 19-с харахад 2020 онд урсгал шилжүүлгийн хэмжээ ихээхэн нэмэгдсэн нь УИХ, Засгийн газрын тогтоолоор малчдын орлого болон үндэсний үйлдвэрүүдийг дэмжих зорилгоор ноолуурын зах зээлийн суурь үнэ дээр 1 кг тутамд 20 000 /хорин мянган/ төгрөгийг буюу нийт 175.4 тэрбум төгрөгийн урамшууллыг малчин, мал бүхий иргэдэд мөнгөн шилжүүлэг хэлбэрээр олгосонтой холбоотой.

**Зураг 19.** ХХААХҮ-ийн салбарын төсвийн урсгал зардал, эдийн засгийн ангиллаар, сая төгрөгөөр



Эх үүсвэр: ХХААХҮЯ


ХХААХҮ-ийн салбарын бараа, үйлчилгээний зардал сүүлийн 10 жилд дунджаар 49.6 тэрбум төгрөг байгаа бөгөөд 2012 онд хамгийн бага буюу 34.0 тэрбум төгрөг, 2020 онд хамгийн их буюу 73.4 тэрбум төгрөг байв. Татаасын хувьд сүүлийн 10 жилийн дундаж хэмжээ 46.6 тэрбум төгрөг байсан бол 2010 онд хамгийн бага буюу 12.6 тэрбум төгрөг, 2020 онд хамгийн их буюу 62.6 тэрбум төгрөгт хүрчээ. Урсгал шилжүүлгийн хэмжээ 2011-2019 онд дунджаар 980.8 сая төгрөг байсан бол ноолуурын урамшуулалтай холбоотойгоор 2020 онд 177.5 тэрбум төгрөгт хүрч огцом нэмэгдсэн байна.

Урсгал зардлын бүтцийг нийт дүнд эзлэх хувиар авч үзвэл жил бүр мөн харилцан адилгүй харагдаж байна. Урсгал зардлын хувийн жин өнгөрсөн хугацаанд ихээхэн хэлбэлзэлтэй байгаа нь ХАА-н салбарт олгосон урамшуулал, татаас, шилжүүлгийн зардал жил бүр харилцан адилгүй хэмжээтэй хуваарилагдаж ирсэнтэй холбоотой.

Жишээ нь 2019 онд нийт урсгал зардлын 58.7 хувийг бараа, үйлчилгээний зардал, 39.9 хувийг татаас, 1.4 хувийг урсгал шилжүүлэг эзэлж байсан бол 2020 оны байдлаар 22.5 хувийг бараа, үйлчилгээний зардал, 22.6 хувийг татаас, 54.9 хувийг урсгал шилжүүлэг /дийлэнх нь ноолуурын урамшуулал/ эзэлж байна. /Зураг 20/

## ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ШИНЖИЛГЭЭ

**Зураг 20.** Урсгал зардлын бүтэц, дүнд эзлэх хувиар.




Эх үүсвэр: СЯ, ХХААХҮЯ

### Бараа, үйлчилгээний зардал

Бараа, үйлчилгээний зардлын бүтцийг авч үзвэл Зураг 21-с харахад 2020 оны байдлаар энэхүү зардлын 53.3 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, 18.4 хувийг норматив зардлууд, 15.6 хувийг цалин, хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал эзэлж байна. Эдгээр 3 төрлийн зардал нийт бараа, үйлчилгээний зардлын 87.3 хувийг эзэлж байна.

**Зураг 21.** Бараа, үйлчилгээний зардлын бүтэц, дүнд эзлэх хувиар




### Татаас

Төсвийн зарлагын эдийн засгийн ангилалаар татаас нь дотроо төрийн өмчит байгууллагад олгох татаас, хувийн хэвшлийн байгууллагад олгох татаасаас бүрдэнэ. ХХААХҮ-ийн салбарын хувьд хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас дийлэнхийг бүрдүүлж байна. Энэхүү

татаас нь арьс, шир, ноос, улаанбуудай, сүүний урамшуулал, мах бэлтгэлийн, ноолуурын, газар тариалан эрхлэгчдийн зээлийн хүүгийн татаасууд ордог. Жил бүрийн урамшууллын хэмжээг төрлөөр нь Зураг 22-д үзүүлэв.

**Зураг 22. ХАА-н урамшууллын хэмжээ, сая төгрөгөөр**



Урамшууллын хэмжээ нь өнгөрсөн хугацаанд тогтвортой бус, өөрчлөгдөж ирсэн бөгөөд энэ нь байгаль, цаг уур болон бусад хүчин зүйлсээс шалтгаалан тухайн жилийн ХАА-н бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нийлүүлэлтийн хэмжээ хэлбэлзлэлтэй байснаас нэг талаас хамаарсан байна.


Өнгөрсөн хугацаанд улаанбуудай, сүү, арьс шир, ноолуурыг дотоодын үйлдвэрт тушаасан үйлдвэрлэгчдэд Засгийн газраас урамшуулал олгож ирсэн. Мөн дотоодын мах, ноолуур бэлтгэгчид, тариалан эрхлэгчдэд зээлийн хүүгийн татаас олгож иржээ.

**Ноосны урамшуулал.** УИХ-ын 2011 оны 30-р тогтоолоор үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх арга хэмжээний хүрээнд хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдийн бэлтгэж ноос боловсруулах үндэсний үйлдвэрт тушаасан ноосыг малын ашиг шим, үүлдэрлэг байдал, ноосны чанараас хамааруулан 2014 оноос эхлэн хонины ноос, тэмээний ноосны килограмм тутамд 1000-2000 төгрөгийн мөнгөн урамшуулал олгохоор заасан байна.

Засгийн газрын 2019 оны 343-р тогтоолоор урамшуулал олгох харилцааг журамласан бөгөөд үүнд ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэгч үндэсний үйлдвэр, цех-д хонь, тэмээний ноос бэлтгэн тушаасан малчин, мал бүхий этгээд, өмчийн бүх хэлбэрийн цөм сүргийн аж ахуйд мөнгөн урамшуулал олгохоор заажээ.

Энэхүү журамд зааснаар боловсруулах үйлдвэрт ноос бэлтгэж тушаасан малчинд өмнөх жилийн эцсийн мал тооллогын А данс дах малын тоо, үүлдэрлэг байдал, ашиг шим, ноосны чанараас хамааран ноосны кг тутамд 1500-2000 төгрөгийн урамшуулал олгож байна.

Журамд зааснаар урамшуулалд олгох хөрөнгийг дараах байдлаар төлөвлөж байна.



**Сүүний урамшуулал.** Хүнсний тухай хуулийн 8-р зүйлд хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэхэд үзүүлэх, дэмжлэг, урамшууллын харилцааг зохицуулсан байх бөгөөд уг хуулийн 8.3-д “Мал төхөөрөх болон сүү боловсруулах үйлдвэр, цехэд гарал үүсэл нь баталгаажсан эрүүл малыг, техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн түүхий сүүг нийлүүлсэн малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид мөнгөн урамшуулал олгож болно”, 8.5-д “Энэ хуулийн 8.1, 8.3-т заасан үйлдвэрлэлд үзүүлэх дэмжлэг, урамшууллын хэлбэр, тэдгээрийг олгох журмыг Засгийн газар батална” гэж заажээ.

Энэ дагуу Засгийн газрын 2020 оны 130-р тогтоолоор “Сүү боловсруулах үйлдвэр, цехэд техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн малын түүхий сүү нийлүүлсэн малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд мөнгөн урамшуулал олгох журам”-ыг батласан байна.

Журманд тусгаснаар өвлийн улирлын сүүний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх замаар хуурай сүүний импортыг бууруулах, хүн амын ундны сүүний хэрэгцээг тогтвортой, хүртээмжтэй хангахад урамшууллын зорилго чиглэгдэж байна.

Журмын дагуу зохих шаардлагыг хангасан сүү боловсруулах үйлдвэр, цехэд техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн малын түүхий сүү тушаасан малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид мөнгөн урамшууллыг тухайн оны 11 дүгээр сарын 1-нээс дараа оны 3 дугаар сарын 31-нийг дуустал хугацаанд **1 литр тутамд таван зуун төгрөгөөр** тооцож олгохоор заасан байна.

Уг журмын 3.1-д сүүний урамшуулалд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг ХХААХҮЯ холбогдох тооцоо, судалгааг хийж шаардлагатай бусад материалын хамт санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, батлуулахаар ерөнхий байдлаар тусгажээ. Цаашид сүүний урамшууллын чиглэсэн зорилго, ач холбогдлыг дахин судалж, үнэлэн, шаардлагатай бол журамд өөрчлөлт оруулан жил бүрийн төсөвт тодорхой шалгуурт үндэслэн тусгахаар оруулах, нэг удаагийн шинжтэй арга хэмжээ байх эсэхийг шийдэх шаардлагатай.

Өвлийн улиралд нийлүүлсэн сүүний хэмжээг тодорхойлох статистик мэдээлэл олдоогүй тул урамшууллын зорилгыг хэрхэн хангаж байгаа үр нөлөөг тооцох боломжгүй байна.

Сүүний урамшууллыг 2019 оноос эхлэн олгож эхлэхээр улсын төсөвт тусгасан боловч 2019 онд олгогдоогүй бөгөөд 2020 онд 1.0 тэрбум төгрөгийг төсөвлөсөн бөгөөд гүйцэтгэлээр



970.0 сая төгрөгийн урамшуулал олгогдсон байна.

**Арьс, ширний урамшуулал.** Мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнээр нэмэгдсэн өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид болон жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээрх УИХ-ын 2011 оны 30-р тогтоол, малчид, үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих чиглэлээрх 2012 оны 74-р тогтоолоор арьс, ширний урамшуулал олгох асуудлыг Засгийн газарт зөвшөөрсөн байна. Тухайлбал, УИХ-ын 2012 оны 74-р тогтоолд дараах арга хэмжээ авахыг Засгийн газарт даалгажээ. Үүнд:

- малаа гарал үүслийн баталгаажуулалтад хамруулсан малчин, мал бүхий этгээдэд үндэсний боловсруулах үйлдвэрт тушаасан бог малын арьс тутамд 3000 төгрөг, адуу, үхрийн шир тутамд 15000 төгрөгийн урамшуулал олгох
- малчин, мал бүхий этгээдэд олгох урамшуулалд шаардагдах хөрөнгийг 2013 оны төсвийн тодотголд тусгаж, цаашид мөнгөн урамшуулал болон үнэт цаасны хүүгийн зөрүүг жил бүрийн улсын төсөвт тусгаж байх
- хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл олгох болон малчин, мал бүхий этгээдэд урамшуулал олгох, түүнд хяналт тавих журмыг баталж, хэрэгжилтийг хангаж ажиллах.

Энэ дагуу Засгийн газрын 2013 оны 394-р тогтоолоор “Үндэсний боловсруулах үйлдвэрт арьс, шир бэлтгэн тушаасан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох журам”-ыг батлан гаргасан байна.

Энэхүү журамд урамшууллын зорилгыг тодорхойлоогүй байх ба урамшуулах олгох харилцааг зохицуулсан байна. Цаашид журмаар урамшууллын зорилгыг маш тодорхой томъёолж, түүний үр дүнг дүгнэх арга, аргачлалыг тусган хэрэгжүүлэх нь зүйтэй.

Уг журмын 1.1-д “Арьс, ширийг гүн боловсруулах үндэсний үйлдвэр (цех, төв, цэг зэрэг)-т (цаашид “үйлдвэр” гэх) арьс, ширийг стандартын дагуу бэлтгэн тушаасан, малаа гарал үүслийн баталгаажуулалтад хамруулсан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд (цаашид “малчин, мал бүхий этгээд” гэх) мөнгөн урамшуулал олгох ажлыг зохион байгуулах, хяналт тавих, тайлагнахтай холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна” гэсэн байх бөгөөд “Арьс, ширийг гүн боловсруулдаг үйлдвэр” гэдэгт арьс, ширийг хатаах боловсруулалт хийсний дараа элдэж зөөлрүүлэн гүйцэд боловсруулах хүчин чадал бүхий үйлдвэр хамаарахаар зохицуулжээ.

Уг журамд арьс ширний урамшууллын хөрөнгийг төлөвлөлтийг ноосны урамшуулалтай ижил зарчмаар хийхээр тусгасан ба Мал хамгаалах сангаар дамжуулан ХХААХҮ-ийн сайдын төсвийн багцад саналаа оруулахаар зохицуулсан байна.

**Ноолуурын урамшуулал.** Ноолуурын урамшууллыг цар тахлын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд 2020 онд олгосон байна. УИХ-ын 2020 оны “Коронавируст халдвар / КОВИД-19/-ын цар тахлын үед санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн үйлчилгээнд цахим шилжилт хийх арга хэмжээний тухай” 32-р тогтоолд “малчдын орлого болон үндэсний үйлдвэрүүдийг дэмжих зорилгоор ноолуурын зах зээлийн суурь үнэ дээр 1 кг тутамд 20 000 /хорин мянган/ төгрөгийн урамшууллыг Малын генетик нөөцийн тухай хуульд заасан малчин, мал бүхий этгээд бүрд олгох”-оор тусгасан байна.

Мөн “Коронавируст халдвар (covid-19)-ын цар тахлын үед эдийн засгийг идэвхжүүлэх, иргэдийн амьжиргааг дэмжих нийгмийн хамгааллын зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2020 оны 167-р тогтоол гарсан бөгөөд уг тогтоолын 4-д Малчдын орлогыг нэмэгдүүлэх болон үндэсний үйлдвэрүүдийг дэмжих зорилгоор Монгол Улсын 2019 оны жилийн эцсийн



## ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ШИНЖИЛГЭЭ

мал тооллогоор А дансанд бүртгэгдсэн мэдээлэлд үндэслэн, ноолуурын хэмжээг “Монгол ямааны үүлдэр, омог. Ерөнхий шаардлага” (MNS 0550:2011) стандартаар тооцож, нэг кг тутамд 20 000 (хорин мянган) төгрөгийн урамшууллыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу олгох арга хэмжээ авахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдад даалгасан байна.

Эдгээр тогтоолыг хэрэгжүүлэхдээ заасан арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7.1.2-т заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2020 оны төсөвт холбогдох зохицуулалт хийх замаар санхүүжүүлэхийг Засгийн газрын уг тогтоолоор Сангийн сайдад зөвшөөрчээ.

**Улаан буудайн урамшуулал.** Тариалангийн тухай хуулийн 19.1-д “Тариалангийн үйлдвэрлэлд төрөөс мөнгөн болон мөнгөн бус дэмжлэг үзүүлж болно.”, 19.6-д “Тариалангийн үйлдвэрлэл эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнд мөнгөн урамшуулал олгох, мөнгөн бус дэмжлэг үзүүлэх журмыг тариалангийн болон санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална” гэж заасан. Энэ хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Сангийн сайдын 2019 оны 290/А-504 дүгээр хамтарсан тушаалаар “Тариалангийн үйлдвэрлэл эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнд мөнгөн урамшуулал олгох, мөнгөн бус дэмжлэг үзүүлэх журам”-аар улаан буудайн урамшууллыг олгож байна.

Хууль, журамд зохих техникийн шаардлагуудыг хангасан, байгаль орчинд ээлтэй, түүний нөөц баялгийг хамгаалан зохистой дэвшилтэт техник, технологи ашиглан нэгжээс авах ургацыг нэмэгдүүлж, тогтвортой үйлдвэрлэл эрхэлж, бүтээгдэхүүнээ зах зээлд хөнгөлөлттэй нийлүүлж, хангамжийг нэмэгдүүлсэн тариалан эрхлэгчийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнд мөнгөн урамшуулал олгохоор заажээ.

Мөнгөн урамшууллыг гурил үйлдвэрлэх зорилгоор нийлүүлсэн улаан буудайн нэгж хэмжээнд тооцон олгож байгаа бөгөөд урамшууллын хэмжээг Засгийн газраас тогтоон батлаж байна. Засгийн газрын 2020 оны “Мөнгөн урамшууллын хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 15-р тогтоолоор Буудайн үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор иргэн, хуулийн этгээдийн дотоодын гурилын үйлдвэр болон Хөдөө аж ахуйг дэмжих сан, Улсын нөөцийн салбарт нийлүүлсэн стандартын I ангиллын шаардлага хангасан хүнсний улаанбуудайн тонн тутамд олгох мөнгөн урамшууллыг 100,000.0 (нэг зуун мянган), II ангиллын шаардлага хангасан хүнсний улаанбуудайн тонн тутамд олгох мөнгөн урамшууллыг 80,000.0 (наян мянган), III ангиллын шаардлага хангасан хүнсний улаанбуудайн тонн тутамд олгох мөнгөн урамшууллыг 60,000.0 (жаран мянган), IV ангиллын шаардлага хангасан хүнсний улаанбуудайн тонн тутамд олгох мөнгөн урамшууллыг 55,000.0 (тавин таван мянган) төгрөгөөр тогтоосон байна. Мөн баруун болон зүүн бүсэд улаанбуудайн үйлдвэрлэл эрхэлж буй иргэн, хуулийн этгээдийн дотоодын гурилын үйлдвэр болон Хөдөө аж ахуйг дэмжих сан, Улсын нөөцийн салбарт нийлүүлсэн стандартын I-IV ангиллын шаардлага хангасан хүнсний улаанбуудайн нэг тонн тутамд олгох мөнгөн урамшууллын хэмжээг энэ тогтоолын 1 дэх заалтад тогтоосон мөнгөн урамшууллын хэмжээнээс 50 хувиар нэмэгдүүлэн тооцож тухайн жилд батлагдсан төсөвтөө багтаан санхүүжүүлэхээр тогтоожээ.

Мөнгөн урамшууллын хэмжээг төлөвлөх талаар нарийвчилсан зохицуулалт журамд тусгаагүй байх ба журмын 2.1-д “Тариалангийн үйлдвэрлэл эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнд олгох мөнгөн урамшуулалд зарцуулах хөрөнгийн эх үүсвэрийг санхүүжүүлэх асуудлыг Төсвийн тухай хуульд заасан төсвийн цаглабарын дагуу санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, Сайдын



төсвийн багцад хуваарилан батлуулна” гэсэн заалт байна. Цаашид мөнгөн урамшууллын хэмжээг тооцохдоо урамшууллын зорилгыг маш тодорхой болгож, дунд хугацааны бодлого, зорилтын хүрээнд төсвийн төлөвлөгөөг хийх, тооцоолох аргачлал боловсруулж гаргах нь зүйтэй.

**Мах бэлтгэлийн урамшуулал.** Хүнсний тухай хуулийн 8-р зүйлд заасан буюу сүүний урамшуулалтай ижил үндэслэлээр нөөцийн мах бэлтгэлд урамшуулал, хүүгийн хөнгөлөлтийн татаас олгож ирсэн байна.

Нөөцийн мах бэлтгэлд зориулан 2013 онд 11.4 тэрбум төгрөг, 2014 онд 9.5 тэрбум төгрөг, 2016 онд 14.5 тэрбум төгрөгийн урамшууллыг аж ахуйн нэгжүүдэд олгосон ба 2015 онд урамшуулалд зардал төсөвлөөгүй байна. Түүнчлэн 2017 оноос урамшууллыг зогсоож оронд нь мах бэлтгэлд зориулсан зээлийн хүүгийн хөнгөлөлт буюу татаас олгож иржээ. Мах бэлтгэлд олгосон зээлийн хүүгийн хөнгөлөлтөд 2017-2020 онуудад жилд дунджаар 3.9 тэрбум төгрөг зарцуулсан байна.

Мах бэлтгэлийн урамшууллын зорилго нь нөөцийн махны нийлүүлэлт, хангамжийг нэмэгдүүлэхэд чиглэгдэж байгаа ба махны нийлүүлэлтийн үнэ, ханшийн хэлбэлзэлтэй хэрхэн холбогдох нь тодорхойгүй байна. Төсвийн тухай хуулийн 1-р хавсралтад тусгагдсан хөтөлбөрийн үр дүнгийн үзүүлэлтэд “Үйлдвэрлэлийн аргаар боловсруулсан махны хэрэглээг нэмэгдүүлэх /мянган тонн/” гэж тусгасан байдаг. Энэ нь мах бэлтгэлийн урамшууллын үр дүнг тооцох шалгуур үзүүлэлт байж болох боловч нэг талаас бэлтгэсэн мах нь “үйлдвэрлэлийн аргаар” боловсруулсан эсэх, мөн урамшуулалд хамрагдаж бэлтгэсэн эсэхийг тодорхойлоход түвэгтэй болно.

Тиймээс мах бэлтгэлийн урамшууллын зорилго, үр дүн, түүний шалгуур үзүүлэлтийг илүү тодорхой, хэмжигдэхүйц болгож журманд тусгах нь зүйтэй.




## Шилжүүлэг

Төсвийн шилжүүлэг нь Засгийн газрын гадаад шилжүүлэг болон бусад урсгал шилжүүлгээс бүрддэг. Бусад урсгал шилжүүлэгт нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал, төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал, тэтгэвэрт гарахад нэг удаа олгох мөнгөн тэтгэмж, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал, бүтцийн өөрчлөлтөөр чөлөөлөгдсөн албан хаагчид олгох тэтгэмж орно.

ХХАХХҮ-ийн салбарын төсвийн хувьд 2011-2019 онд шилжүүлгийн хэмжээ нь дунджаар урсгал зардлын 1.0 хувийг эзэлж байсан бол 2020 онд ноолуурын урамшууллыг төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшууллын хэлбэрээр нийт 174.9 тэрбум төгрөгийг олгосонтой холбоотойгоор шилжүүлгийн хэмжээ нь нийт урсгал зардлын 54.9 хувийг эзэлсэн байна.

ХХААХҮ-ийн салбарт улсын төсвөөс татаас, шилжүүлгийн хэлбэрээр олгосон нийт урамшуулал, зээлийн хүүгийн татаасын хэмжээг 2010-2020 оноор нийт болон урсгал төсвийн зарлагатай харьцуулж Зураг 23-д үзүүллээ.

**Зураг 23.** ХХААХҮ-ийн салбарт улсын төсвөөс олгосон урамшуулал, хүүгийн татаасын хэмжээ, сая төгрөгөөр



Эх үүсвэр: ХХААХҮЯ

Зураг 23-оос харахад 2011 онд салбарын төсвийн зарлага бусад жилүүдээс өндөр байгаа нь тухайн онд ЖДҮ болон ХАА-н үйлдвэрлэлийг дэмжих татаас, хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрт ихээхэн хөрөнгө хуваарилсантай холбоотой.

Тус салбарт улсын төсвөөс олгосон нийт урамшуулал, хүүгийн татаасын хэмжээг салбарын төсвийн нийт болон урсгал зардалд харьцуулж доорх Зураг 24-т үзүүллээ



**Зураг 24.** ХХААХҮ-ийн салбарт олгосон нийт урамшуулал, хүүгийн татаасын салбарын төсөвт эзлэх хувь



Эх үүсвэр: Сангийн яам, ХХААХҮЯ

Дээрх Зураг 24-т үзүүлснээр ХХААХҮ-ийн салбарт улсын төсвөөс санхүүжүүлсэн нийт урамшуулал, хөнгөлөлттэй зээлийн хүүгийн татаасын хэмжээ нь 2010-2020 оны дунджаар тус салбарын төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүнгийн 34.1 хувь, урсгал зардлын 46.9 хувийг тус тус эзэлж, салбарын төсөвт чухал нөлөөтэй болохыг харуулж байна.


Зураг 24-т нийт зарлага ба цэвэр зээлийн дүнд эзлэх хувь 2015 онд огцом өндөр байгаа нь тухайн жилд эргэж төлөгдөх төлбөр өндөр байснаас нийт зарлага ба цэвэр зээлийн дүн ихээхэн буурсантай холбоотой.



### 3.2.1. Хөрөнгийн зардал

ХХААХҮ-ийн салбарын төсвийн зардалд хөрөнгийн зардлын эзлэх хувь өнгөрсөн 10 жилд 5.9-42.6 хүртэл хувийг эзэлж байв. Тухайлбал 2012 онд хөрөнгийн зардал салбарын нийт төсвийн зардлын 42.6 хувь буюу 77.0 тэрбум төгрөг байсан бол 2020 онд салбарын нийт төсвийн зардлын 5.9 хувь буюу 20.5 тэрбум төгрөгийн дүнтэй байна /Зураг 25/.

**Зураг 25.** ХХААХҮ-ийн салбарын төсвийн хөрөнгийн зардлын дүн ба түүний нийт зардалд эзлэх хувь




Дээрх зургаас харахад сүүлийн 10 жилд хөрөнгийн зардлын хэмжээ болон нийт салбарын төсвийн зардалд эзлэх хувь жилээс жилд харилцан адилгүй хуваарилагдаж ирсэн байна.

ХХААХҮ-ийн салбарын төсвийн хөрөнгийн зардлын дийлэнх хэсгийг барилга байгууламж болон стратегийн нөөц хөрөнгө эзэлж байна.

Барилга байгууламжид малын уст цэг худаг гаргах зардал, газар тариалангийн бүтээгдэхүүний агуулах, харъяа байгууллагуудын барилга барих зэрэг нь гол хувийн жин эзэлж байна.



Зураг 26. ХХААХҮ-ийн салбарын төсвийн хөрөнгийн зардлын бүтэц, дүнд эзлэх хувиар



Сүүлийн 10 жилийн байдлаар тус салбарын хөрөнгө оруулалтанд тоног төхөөрөмж авах зардал 1.1-41.5 хүртэл хувийг эзэлж байна. Энэ төрлийн хөрөнгийн зардалд газар тариалангийн техник, тоног төхөөрөмж болон харъяа байгууллагуудын тоног төхөөрөмжийн шинэчлэл гол дүнтэй байна.

ХХААХҮ-ийн салбарын хувьд стратегийн нөөц хөрөнгө нь хүнс бараа, өвс тэжээл, үр, таваарын буудайн нөөцөөс бүрддэг. Стратегийн нөөц хөрөнгийн зардал салбарын нийт хөрөнгө оруулалтын зардалд жил бүр харилцан адилгүй хувийн эзэлж ирсэнийг дээрх Зураг 26-аас харж болно.

Дүгнэж хэлэхэд тухайн жилийн хэрэгцээ шаардлага, төсвийн боломжоос шалтгаалан хөрөнгийн зардлын бүтэц жил бүр өөрчлөгдөж ирсэн байна. Сүүлийн 10 жилийн байдлаар хөрөнгийн зардлын 29.9-94 хувийг барилга, байгууламжид, 41.5 хүртэл хувийг тоног төхөөрөмжинд, 60.2 хүртэл хувийг стратегийн нөөц хөрөнгө бүрдүүлэхэд тус тус зарцуулсан байна. Хөрөнгийн зардлын бүтцэд их засвар болон бусад хөрөнгийн зардал 10 хувиас доош, зарим жил тухайлбал 2016, 2019 онд ийм төрлийн хөрөнгийн зардал төсөвлөгдөөгүй байна.

### 3.2.1. Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл


ХХААХҮ-ийн салбарт улсын төсвөөс жил бүр ЖДҮ-ийг дэмжих, газар тариалангийн бүтээгдэхүүн, хүнсний хангамжийг нэмэгдүүлэхэд зориулж хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийг олгож байна.

Төсвийн зардлын эдийн засгийн ангилалаар эргэж төлөгдөх зээлийн эх үүсвэрийн зардлаас өмнө олгосон зээлийн эргэн төлөлтийг хасаж тооцсон зардлыг эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл гэсэн зүйлээр төсөвт тусгадаг.

ХХААХҮ-ийн салбарын төсвийн зарлагад эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл зарим жилд томоохон хувийн жинтэй байна.

## ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ШИНЖИЛГЭЭ

**Зураг 27.** ХХААХҮ-ийн салбарын төсвийн нийт зарлага, эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлийн хэмжээ болон түүний нийт зарлагад эзлэх хувь



Дээрх зургаас харахад өнгөрсөн жилүүдэд энэхүү зардлын зүйлийн хэмжээ болон дүнд эзлэх хувь харилцан адилгүй байна. Энэ нь салбарын төсөвт тухайн жилд эргэж төлөгдөх зээлийн эх үүсвэрт олгосон санхүүжилт болон өмнөх зээлийн эргэн төлөлтийн хэмжээнээс хамаарч байна. Тухайлбал 2011 онд ЖДҮ-ийг дэмжихэд зориулж эргэн төлөх нөхцөлтэй зээлийн эх үүсвэрт төсвөөс 176.8 тэрбум төгрөг, ноолуурын үйлдвэрлэл эрхэлж буй ААН-үүдэд 130.0 тэрбум төгрөгийн зээлийн эх үүсвэр хуваарилсан нь эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлийн хэмжээг өсгөсөн байна.

### 3.2.2 Салбарын төсвийн зарлага, хөтөлбөрөөр


Сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаалаар батлагдсан Төсвийн зарлагын хөтөлбөрийн ангилалаар ХХАХҮ-ийн сайдын төсвийн багц нь дараах 7 хөтөлбөрөөс бүрдэж байна. Үүнд:

1. Мал аж ахуйг хөгжүүлэх
2. Газар тариалан хөгжүүлэх
3. Хүнсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх
4. Хөнгөн үйлдвэрийг хөгжүүлэх
5. Хөдөө аж ахуй, газар тариалан, аж үйлдвэрийн бодлого удирдлага
6. Хөдөө аж ахуй, газар тариалан, аж үйлдвэрийн судалгаа шинжилгээ
7. Хүнд үйлдвэрийг хөгжүүлэх

Яамдын чиг үүрэгт 2016 онд өөрчлөлт орсонтой холбогдуулан ЖДҮ, үйлчилгээ, хоршооны салбар нь ХХААХҮ-ийн сайдын багцад нэмэгдсэн ба Хүнд үйлдвэрийг хөгжүүлэх хөтөлбөр хасагдсан байна. Мөн мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг мал аж ахуйг хөгжүүлэх хөтөлбөрийн дэд хөтөлбөр хэлбэрээр санхүүжүүлж ирсэн байна.

Хөтөлбөрүүдийн төсвийн урсгал зардлын гүйцэтгэлийг Зураг 28-аар үзүүлэв. 2020 оны хувьд ноолуурын урамшуулалд 174.9 тэрбум төгрөг олгосон нь хөнгөн үйлдвэрийг хөгжүүлэх хөтөлбөрийн зарлагын хэмжээг огцом нэмэгдүүлж, салбарын төсвийн урсгал зардлын дийлэнхийг бүрдүүлсэн харагдаж байна.

**Зураг 28. ХХААХҮ-ийн салбарын хөтөлбөрүүдийн урсгал зардал, сая төгрөгөөр**



Сүүлийн 5 жилийн дунджаар авч үзэхэд ХХААХҮ-ийн салбарын төсвийн урсгал зардлын 19.5 хувийг Мал аж ахуйг хөгжүүлэх, 10.6 хувийг Газар тариалан хөгжүүлэх, 2.8 хувийг Хүнсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, 15.7 хувийг Хөнгөн үйлдвэрийг хөгжүүлэх, 11.1 хувийг Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний дэд хөтөлбөрт, 24.0 хувийг ЖДҮ, үйлчилгээ хоршоог дэмжих, 16.1 хувийг Хөдөө аж ахуй, газар тариалан, аж үйлдвэрийн бодлого удирдлага, 0.1 хувийг Хөдөө аж ахуй, газар тариалан, аж үйлдвэрийн судалгаа шинжилгээний хөтөлбөрт тус тус зарцуулсан байна. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль 2018 оноос хэрэгжиж эхэлснээр мал эмнэлгийн урьдчилсан сэргийлэх арга хэмжээний зардал сүүлийн жилүүдэд нэмэгдэх хандлагатай байна.




## 1. Мал аж ахуйг хөгжүүлэх

Мал аж ахуйг хөгжүүлэх хөтөлбөрийн зардалд ноос, арьс ширний урамшуулал, бэлчээрийн ургамал хамгаалал, эрчимжсэн МАА-г дэмжих хөнгөлөлттэй зээл, өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх зардал орж байна.

Сүүлийн 5 жилийн МАА-г хөгжүүлэх хөтөлбөрийн зардлын нийт салбарын төсвийн зардалд эзлэх хувийг доорх зургаар харуулав.


**Зураг 29.** Мал аж ахуйг хөгжүүлэх хөтөлбөрийн зардал, түүний нийт салбарын төсвийн зарлагад эзлэх хувь



Дээрх зургаас харахад сүүлийн 5 жилд МАА-г хөгжүүлэх хөтөлбөрийн (мал эмнэлгийг оруулаагүй дүнгээр) төсвийн зарлагын хэмжээ 2017 оныг эс оролцуулбал жилд ойролцоогоор 30 орчим тэрбум төгрөгт тогтвортой байгаа боловч нийт салбарын төсөвт эзлэх хувь буурах хандлагатай байна. 2017 оны хувьд өвс тэжээлийн нөөц бүрдүүлэхэд улсын төсвөөс 40 тэрбум төгрөг хуваарилсан нь тухайн жилийн хөтөлбөрийн зардлыг огцом нэмэгдүүлсэн байна.

Мал аж ахуйг хөгжүүлэх хөтөлбөрийн зардлын гол бүрэлдэхүүн хэсэгт ноосны урамшуулал, арьс ширний урамшуулал, бэлчээрийн ургамал хамгаалал /үлийн цагаан огтоно, царцаатай тэмцэх арга хэмжээ/, МАА-н салбар бодлого, хөтөлбөр хэрэгжүүлэх бусад зардал, эрчимжсэн МАА-г дэмжих, өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх зэрэгт зориулсан зардлууд орж байна. Эдгээр зардлын жил бүрийн дүнг доорх Зураг 30-д харуулав.

**Зураг 30. МАА-г хөгжүүлэх хөтөлбөрийн зардлын төрлүүд, түүний хэмжээ /тэрбум төгрөгөөр/**



Дээрх зургаас харахад сүүлийн 5 жилийн байдлаар жил бүр ноосны урамшуулалд 18.2-22.6 тэрбум төгрөг, арьс ширний урамшуулалд 8.4-13.0 тэрбум төгрөг, бэлчээрийн ургамал хамгаалалд буюу үлийн цагаан оготно, царцаатай тэмцэхэд 1.6-2.2 тэрбум төгрөгийг зарцуулж байна. Эрчимжсэн МАА эрхлэгчдийг дэмжих хөнгөлөлттэй зээлд 2015-2017 онууд 0.9-1.6 тэрбум төгрөгийг зарцуулсан байх бөгөөд 2018-2020 онд үүнд зардал төсөвлөөгүй байна. МАА-н салбарын бодлого, хөтөлбөр хэрэгжүүлэх бусад зардалд МАА-н салбарт хэрэгжүүлж буй Монгол мал хөтөлбөр зэрэг үндэсний болон салбарын хөтөлбөрүүдийн урсгал зардал орж байна.

## 2. Газар тариалан хөгжүүлэх

Газар тариаланг хөгжүүлэх хөтөлбөрийн төсвийн зардал нь улаанбуудайн урамшуулал, газар тариалан эрхэлж буй ААН-үүд олгосон зээлийн хүүгийн хөнгөлөлт, ХАА-г дэмжих санд үрийн нөөц бүрдүүлэх зардал болон “Хүнсний ногоо” үндэсний хөтөлбөр, “Жимс жимсгэнэ” үндэсний хөтөлбөр зэрэг газар тариалангийн бодлого, хөтөлбөр хэрэгжүүлэх зардлаас бүрдэж байна.

Газар тариаланг хөгжүүлэх хөтөлбөрийн зардал нь сүүлийн 5 жилийн байдлаар салбарын төсвийн нийт зарлагын 4.8-14.1 хувийг эзэлж байна. Үнийн дүнг нь авч үзвэл сүүлийн 5 жилд 6.9-38.5 тэрбум төгрөгийг жил бүр газар тариаланг хөгжүүлэх хөтөлбөрт зарцуулжээ.

## ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ШИНЖИЛГЭЭ

**Зураг 31.** Газар тариаланг хөгжүүлэх хөтөлбөрийн зардлын хэмжээ ба нийт салбарын төсөвт эзлэх хувь



Дээрх зургаас харахад 2017 онд бусад жилүүдтэй харьцуулахад хөтөлбөрийн зардлын хэмжээ огцом нэмэгдсэн харагдаж байгаа бөгөөд энэ нь зөвхөн тухайн жилд ХАА-г дэмжих санд үрийн нөөц бүрдүүлэхэд 23.4 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосонтой холбоотой.

Газар тариаланг хөгжүүлэх хөтөлбөрийн зардлын бүтцийг доорх Зураг 32-д харууллаа. Үүнээс харахад хөтөлбөрийн зардлын дийлэнх буюу 80-90 гаруй хувийг улаан буудайн урамшууллын зардал эзэлж байна. Сүүлийн 5 жилийн байдлаар авч үзэхэд улаан буудайн урамшуулалд жил бүр 5.9-22.4 тэрбум төгрөгийг зарцуулжээ.

**Зураг 32.** Газар тариаланг хөгжүүлэх хөтөлбөрийн зардлын бүтэц



Дээрх зурагт үзүүлснээр 2017 онд ХАА-г дэмжих сангаар дамжуулан үрийн нөөц бүрдүүлэхэд нийт хөтөлбөрийн зардлын 60.8 хувь буюу 23.4 тэрбум төгрөг зарцуулсан байна. Бусад жилүүдэд үүнд зардал төсөвлөөгүй байна.

### 3. Хүнсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх

Хүнсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх хөтөлбөрийн зардалд нөөцийн мах бэлтгэлийн урамшуулал, нөөцийн мах бэлтгэлд зориулсан зээлийн хүүгийн хөнгөлөлт, сүүний урамшуулал болон хүнсний салбарын бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардал орж байна.

Энэхүү хөтөлбөрийн зардал нь сүүлийн 5 жилийн байдлаар ХХААХҮ-ийн салбарын нийт төсвийн зарлагын 1.1-10.6 хувьтай тэнцэх хэмжээний буюу жилд 3.0-14.6 тэрбум төгрөг байна. Нөөцийн мах бэлтгэлийн урамшуулалд 2016 онд 14.5 тэрбум төгрөгийг олгосон ба түүний дараа жилээс хэлбэрийг нь өөрчилж нөөцийн мах бэлтгэлд зориулсан зээлийн хүүгийн хөнгөлөлтөд татаас олгож эхэлсэн байна. Нөөцийн мах бэлтгэлд зориулсан зээлийн хүүгийн хөнгөлөлтөд 2017-2020 онд жилд дунджаар 3.9 тэрбум төгрөг зарцуулсан байна.

Засгийн газрын 2020 оны 130-р тогтоолоор “Сүү боловсруулах үйлдвэр, цехэд техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн малын түүхий сүү нийлүүлсэн малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд мөнгөн урамшуулал олгох журам”-ыг батласан байна.

Журамд тусгаснаар өвлийн улирлын сүүний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх замаар хуурай сүүний импортыг бууруулах, хүн амын ундны сүүний хэрэгцээг тогтвортой, хүртээмжтэй хангахад урамшууллын зорилго чиглэгдэж байна.

Журмын дагуу зохих шаардлагыг хангасан сүү боловсруулах үйлдвэр, цехэд техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн малын түүхий сүү тушаасан малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид мөнгөн урамшууллыг тухайн оны 11 дүгээр сарын 1-нээс дараа оны 3 дугаар сарын 31-нийг дуустал хугацаанд 1 литр тутамд таван зуун төгрөгөөр тооцож олгохоор заасан байна. Энэхүү арга хэмжээнд 2020 онд 970 сая төгрөгийг зарцуулжээ.

Хүнсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээнд 2016-2020 онд жилд дунджаар 214 сая төгрөгийн зардал гаргасан байна.



## ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ШИНЖИЛГЭЭ


**Зураг 33.** Хүнсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх хөтөлбөрийн зардлын хэмжээ болон салбарын төсөвт эзлэх хувь



Дээрх Зураг 33-д харуулснаар Хүнсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх хөтөлбөрт 2016 онд салбарын төсвийн 10.6 хувь буюу 14.6 тэрбум төгрөг зарцуулсан бол 2017-2020 онд жилд дунджаар салбарын төсвийн 2.1 хувь буюу 4.4 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдсэн байна.

Хүнсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх хөтөлбөрийн зардлын бүтцийг доорх Зураг 34-д харууллаа.

**Зураг 34.** Хүнсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх хөтөлбөрийн зардлын бүтэц



Зураг- аас харахад энэхүү хөтөлбөрийн зардлын дийлэнх хувийг нөөцийн мах бэлтгэлийн урамшуулал, нөөцийн мах бэлтгэлд зориулсан зээлийн хүүгийн хөнгөлөлт эзэлж байна.

#### 4. Хөнгөн үйлдвэрийг хөгжүүлэх

Хөнгөн үйлдвэрийн хөгжүүлэх хөтөлбөрийн зардал нь тус салбарын бодлого, хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас бүрддэг ба 2020 онд ноолуурын урамшуулал, ноолуур бэлтгэлд зориулсан зээлийн хүүгийн хөнгөлөлтийн зардал нэмэгдсэн байна.

Тус хөтөлбөрийн зардлын нийт салбарын төсвийн зардалд эзлэх хувь 2017-2019 онд 0.1-0.2 хувь байсан бол 2020 онд ноолуурын урамшуулал, мөн ноолуур бэлтгэлд зориулсан зээлийн хүүгийн хөнгөлөлт олгосонтой холбоотойгоор нийт ХХААХҮ-ийн салбарын төсвийн зардлын 52.1 хувийг эзэлсэн байна /Хүснэгт 16/.

**Хүснэгт 16.** Хөнгөн үйлдвэрийг хөгжүүлэх хөтөлбөрийн зардал ба салбарын төсвийн дүнд эзлэх хувь

	2017	2018	2019	2020
ХХААХҮ-ийн салбарын төсвийн нийт зарлагад эзлэх хувь	0.1%	0.2%	0.2%	52.1%
Хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх хөтөлбөрийн зардал	317.0	359.4	312.2	180,245.9
Үүнээс: -Ноолуурын урамшуулал				175,001.0
-Ноолуур бэлтгэлийн зээлийн хүүгийн хөнгөлөлт				5,062.7
-Хөнгөн үйлдвэрийн салбарын бодлого, хөтөлбөр хэрэгжүүлэх зардал	317.0	359.4	312.2	182.2

Дээрх Хүснэгт 7-д харуулсанаар хөнгөн үйлдвэрийн салбарын бодлого, хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардал нь 2017-2020 онд жилд дунджаар 292.7 сая төгрөг байсан болно.

#### 5. Жижиг дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршоог дэмжих

ЖДҮ, үйлчилгээ, хоршоог дэмжих хөтөлбөрийн зардалд ЖДҮ эрхлэгчдэд олгох хөнгөлөлттэй зээлийн санхүүжилт, ЖДҮ-ийн бодлого, хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардал ордог.

Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх төсөв нь жилээс жилд харилцан адилгүй байна. Тухайлбал 2018 онд ЖДҮ, үйлчилгээ, хоршоог дэмжих зардалд тус салбарын төсвийн зарлагын 56.1 хувь буюу 96.8 тэрбум төгрөгийг зарцуулсан бол 2020 онд салбарын төсвийн зарлагын 6.7 хувь буюу 23.0 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

## ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ШИНЖИЛГЭЭ

**Зураг 35.** ЖДҮ, үйлчилгээ, хоршоог дэмжих хөтөлбөрийн зардал, түүний салбарын төсвийн нийт зарлагад эзлэх хувь



Тус хөтөлбөрийн зардлын бүтцийг авч үзвэл хөтөлбөрийн зардлын 99.2-99.9 хувийг ЖДҮ эрхлэгчдэд олгох хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийн зардал эзэлж байна. Үлдэх багахан хувийг ЖДҮ, үйлчилгээ, хоршоог дэмжих бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний урсгал зардал эзэлж байна.

ЖДҮ эрхлэгчдэд олгох хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийг ЖДҮ-ийг хөгжүүлэх сангаар дамжуулан ААН, бизнес эрхлэгчдэд олгож ирсэн байна.

ЖДҮ-ийг дэмжих сан нь 1992 онд тухайн үеийн Үйлдвэр, Худалдааны Яамнаас АНУ-ын Засгийн газар болон Монгол улсын Засгийн газраас хамтран хэрэгжүүлсэн “Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг дэмжих” төслийн хүрээнд “ЖДҮ-ийн сан” нэртэйгээр анх байгуулагдсан байна. Түүний хойш 2000 онд яамдын чиг үүрэг өөрчлөгдөж ЖДҮ-ийн асуудал ХХААХҮЯ-нд шилжсэнтэй холбогдуулан тус яамны дэргэд “ЖДҮ-ийг дэмжих сан” нэртэй болсон байна. Түүнчлэн 2009 онд бүтэц зохион байгуулалтыг өөрчилж “ЖДҮ-ийг хөгжүүлэх сан” хэмээх болжээ. Мөн яамдын чиг үүргийн өөрчлөлттэй холбоотойгоор тус сан нь 2012 онд Хөдөлмөрийн яам, 2014 онд Аж үйлдвэрийн яам, 2016 онд буцаад ХХААХҮЯ-ны харъяанд шилжсэн байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн 49 дүгээр тогтоолоор “ЖДҮ-ийг хөгжүүлэх сан”-гийн ажлын албыг ХХААХҮЯ-ны Жижиг, дунд үйлдвэр, хоршооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газартай нэгтгэн Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-“Жижиг, дунд үйлдвэрийн газар” байгуулсан байна.

ЖДҮ-ийг хөгжүүлэх сангийн үндсэн зорилго нь анх байгуулагдсан цагаас хойш хот, хөдөөд ажлын байрыг хадгалах, шинээр бий болгож нэмэгдүүлэх, жижиг дунд бизнест санхүүгийн дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэж байсан бол ЖДҮ-ийн газар байгуулагдсанаар ЖДҮ, үйлчилгээ, хоршооны салбарыг хөгжүүлэх, өрсөлдөх чадварыг дээшлүүлж, үндэсний үйлдвэрлэлийн өсөлтийг хангах, импортыг орлох, экспортыг нэмэгдүүлэх бодлогын хэрэгжилтийг хангах, хөнгөлөлттэй зээл, татаас олгох, улмаар нийгэм, эдийн засагт жижиг, дунд үйлдвэр, хоршооны



салбарын эзлэх байр суурийг бэхжүүлэх, тэдгээрийн хөгжлийн цаашдын чиг хандлагыг тодорхойлж, төрийн дэмжлэг үзүүлэх, тэдний эрх ашигт нийцсэн бизнесийн таатай орчныг бүрдүүлэх өргөн хүрээний зорилготой болжээ.

ЖДҮ-ийг хөгжүүлэх сангаас олгосон зээл. ЖДҮ-ийн хөгжүүлэх сангаас 2009-2020 оны хооронд хот, орон нутагт нийт 8178 төсөлд 860.6 тэрбум төгрөгийн зээл олгосон байна. Энэ хугацаанд 1 төсөлд дунджаар 105.2 сая төгрөгийн зээл олгожээ.

**Хүснэгт 17. ЖДҮ-ийг хөгжүүлэх сангаас олгосон зээлийн мэдээлэл**

Он	Зээлд хамрагдсан төслийн тоо			Олгосон зээлийн хэмжээ /тэрбум төг-өөр/		
	Орон нутаг	Хот	Бүгд	Орон нутаг	Хот	Бүгд
2009	1,604	34	1,638	25.7	12.8	38.5
2010	1,523	84	1,607	22.3	17.7	40.0
2011	1,526	181	1,707	57.2	118.6	175.8
2012	68	38	106	4.1	24.9	29.0
2013	360	181	541	22.7	54.3	77.0
2014	530	398	928	36.2	107.6	143.8
2015	290	108	398	17.5	42.8	60.3
2016	87	101	188	20.3	59.7	80.0
2017	117	37	154	35.5	14.2	49.7
2018			211			96.2
2019	306	145	451	17.7	29.4	47.4
2020			249			22.9
Бүгд	6,105	1,162	8,178	242	453	860.6

ЖДҮ-ийг дэмжих урт хугацаатай хөнгөлөлттэй зээлд хамрагдахаар 2020 онд нийт 1579 төсөл, 238.4 тэрбум төгрөгийн зээлийн хүсэлт ирүүлснээс 249 төсөлд нийт 22.9 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байна.

ЖДҮ-ийг дэмжих зээлийн нөхцлийн хувьд 2009 оноос жилийн 7 хувийн хүүтэй, 5 хүртэл жилийн хугацаатай, эхний 1 жил үндсэн төлбөрөөс чөлөөлөх нөхцөлтэй байсан бол 2018 оноос жилийн 3 хувийн хүүтэй болсон байна.

Өнгөрсөн хугацаанд ЖДҮ-ийг хөгжүүлэх сангийн эх үүсвэрт зориулан гаргасан Засгийн газрын бондын эргэн төлөлтийг ААН, иргэдэд олгосон зээлийн эргэн төлөлтөөс бүрдүүлэн хийж ирсэн бөгөөд зээлийн эргэн төлөлт тасалдсан үед салбарын төсвийн өөрийн орлого бүрдэлт тасарч, энэ хэмжээгээр зарлага, санхүүжилтийн гүйцэтгэл доголдох тохиолдлууд гарч байв.

ЖДҮ-ийг хөгжүүлэх, эдийн засгийг төрөлжүүлэх нь Засгийн газрын болон салбарын тэргүүлэх зорилт хэвээр байна. Хэдийгээр улсын хөгжилд чухал хувь нэмэртэй ч аль ч улс оронд ЖДҮ нь зах зээлийн үнэ ханш, эдийн засгийн мөчлөг, бүс нутгийн эдийн засаг, нийгмийн өөрчлөлтөнд өртөмтгий, эрсдэл өндөртэй, барьцаа хөрөнгө дутмаг, үйл ажиллагааны цар хүрээ бага тул санхүүгийн зах зээлээс хэрэгцээт санхүүжилтээ авахад бэрхшээлтэй байдаг.

Иймд ЖДҮ-ийн санхүүжилтийн тогтолцоог урт хугацаанд тогтвортой үргэлжлүүлэх, зах зээлийн зарчимд нийцүүлэх, хямд өртөгтэй санхүүгийн эх үүсвэр, ялангуяа урт хугацааны төслийн санхүүжилтийн эх үүсвэр, хүртээмжийг нэмэгдүүлэх шаардлага тулгарч байна.

## 6. Хөдөө аж ахуй, газар тариалан, аж үйлдвэрийн судалгаа шинжилгээ

Хөдөө аж ахуй, газар тариалан, аж үйлдвэрийн судалгаа, шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төсвийн зардлын гүйцэтгэл нь 2016 онд 141.7 сая, 2017, 2018 онд зардал төсөвлөөгүй байна. Түүнчлэн 2019 онд 109.8, 2020 онд 35.0 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Энэхүү зардал нь яамны урсгал зардалд орох бөгөөд салбарт хамаарах судалгаа, шинжилгээний ажлыг гэрээний үндсэн дээр бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээнд хамаарна.

## 7. Хөдөө аж ахуй, газар тариалан, аж үйлдвэрийн бодлого, удирдлага

Хөдөө аж ахуй, газар тариалан, аж үйлдвэрийн бодлого, удирдлагын зардалд ХХААХҮЯ, түүний харъяа дараах байгууллагуудын үйл ажиллагааны урсгал зардал хамрагдаж байна. Үүнд:

1. Мал эмнэлгийн ерөнхий газар
2. Аймаг, нийслэлийн мал эмнэлгийн газар, сумдын тасаг
3. Жижиг, дунд үйлдвэрийн газар
4. Малын удмын сангийн үндэсний төв
5. Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргаа
6. Хөдөө аж ахуйг дэмжих сан
7. ХАА-н “Халх гол” үндэсний бүтээн байгуулалтын захиргаа
8. Улсын мал эмнэлгийн ариун цэврийн төв лаборатори
9. Малын эм, эмнэлгийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори

Энэхүү хөтөлбөрийн зардал нь сүүлийн 5 жилийн байдлаар ХХААХҮ-ийн салбарын төсвийн нийт зардлын 5.5-18.1 хувь буюу жилд 13.3-33.8 тэрбум төгрөг байв /Зураг 36/.


**Зураг 36.** ХАА, газар тариалан, аж үйлдвэрийн бодлого, удирдлагын зардал, түүний салбарын төсвийн нийт зардалд эзлэх хувь



Эх үүсвэр: СЯ, ХХААХҮЯ

ХХААХҮЯ болон түүний харъяа байгууллагуудын урсгал зардлын дүнг байгууллага тус бүрээр сүүлийн 5 жилээр доорх Зураг 37-д харуулав.

**Зураг 37. ХХААХҮЯ, түүний харъяа байгууллагуудын урсгал зардлын дүн, сая төгрөгөөр**



Эх үүсвэр: СЯ, ХХААХҮЯ

### 3.2.3 Салбарын төсвийн зарлага, зориулалтаар

ХХААХҮ-ийн салбарын 2021 оны батлагдсан төсвийн зарлагыг зориулалтаар нь доорх Зураг 38-д үзүүлээ. Төсвийн зориулалтаас харахад ХАА-н салбарын бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийг дэмжих урамшуулал болон мал эмнэлгийн үйлчилгээний зардал салбарын төсвийн 70 гаруй хувийг эзэлж байна.

Тухайлбал 2021 оны батлагдсан төсвийг зориулалтын ангиллаар харахад нийт төсвийн 41.4 хувийг ХАА-н салбарын бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийг дэмжих урамшуулал, 32.7 хувийг мал эмнэлгийн бүх төрлийн үйлчилгээ, оношлогоо, судалгаа эзэлж байна. Бусад зориулалтын зардал тус бүр нийт зарлагын дүнд 5-аас бага хувийг эзэлж байна. /Зураг 38/

**Зураг 38. ХХААХҮ-ийн салбарын 2021 оны батлагдсан төсөв, зориулалтаар /сая төгрөгөөр/**



Үүнээс Мал эмнэлгийн бүх төрлийн үйлчилгээ, оношлогоо, судалгааны зардлыг задалж дараах Зураг 39-аар харуулав.

**Зураг 39. Мал эмнэлгийн үйлчилгээ, оношлогоо, судалгааны зардлын бүтэц /2021 оны батлагдсан төсөв, сая төгрөгөөр/**




Мал эмнэлгийн салбарын зардалд мал эмнэлгийн үйлчилгээ, малын гоц болон бусад халдварт өвчнаас урьдчилан сэргийлэх, мал, амьтан архаг халдварт өвчин болон бусад өвчнөөс эрүүлжүүлэх, ариутгал халдваргүйжүүлэлт, лабораторийн оношлогоо, шинжилгээ болон сургалт, сурталчилгаа, судалгаа шинжилгээний зардал орж байна.

### 3.2.4 Салбарын төсвийн зарлага, улсын болон орон нутгийн шатлалаар

ХХААХҮ-ийн салбарын төсвөөс 21 аймаг, нийслэлийн хүнс, хөдөө аж ахуйн газар болон аймаг, нийслэлийн мал эмнэлгийн газар, түүний суман дах тасгийн үйл ажиллагааны урсгал зардлыг санхүүжүүлж байна.

Эдгээр зардлын ХХААХҮ-ийн салбарын төсвийн нийт зардалд эзлэх дүн 2019 онд 12.5 хувь буюу 20.8 тэрбум төгрөг байсан бол 2020 онд 6.5 хувь буюу 22.6 тэрбум төгрөгт хүрсэн байна. Одоогийн байдлаар аймгуудын төсвийн гүйцэтгэлийн задаргаа 2020 оны байдлаар гараагүй байгаа тул 2019 оны гүйцэтгэлийг энд авав.

**Зураг 40.** ХХААХҮ-ийн салбарын орон нутгийн байгууллагуудын зардал, түүний салбарын нийт төсвийн зардалд эзлэх хувь



Дээрх зардлыг байгууллагаар нь ангилж үзвэл 2020 оны байдлаар 60.1 хувь буюу 13.6 тэрбум төгрөгийг 21 аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн газрын урсгал зардалд, 39.9 хувь буюу 9.0 тэрбум төгрөгийг 21 аймаг, нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын урсгал зардалыг санхүүжүүлэхэд зориулсан байна /Хүснэгт 18/.


**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ШИНЖИЛГЭЭ**

**Хүснэгт 18.** Орон нутгийн харъяа байгууллагуудын урсгал зардал

	2019		2020	
	тэрбум төг.	дүнд эзлэх хувь	тэрбум төг.	дүнд эзлэх хувь
ХХААХҮ-ийн салбарын орон нутгийн төсвийн зардал	20,826.4	100.0%	22,629.3	100.0%
Үүнээс: Аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн газар	14,524.3	69.7%	13,589.4	60.1%
Аймаг, нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар	6,302.1	30.3%	9,039.9	39.9%

Аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн газрын урсгал зардлыг аймгуудаар харьцуулж үзвэл тухайн аймгийн малын тоо зэргээс хамааран харилцан адилгүй байгааг Зураг 41-с харж болно.

**Зураг 41.** Аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн газрын урсгал зардлын хэмжээ /2019 он/



Аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн газрын урсгал зардлын хэмжээ, түүний бүтцийг 2019 оны гүйцэтгэлээр доорх Хүснэгт 19-д үзүүлэв.

**Хүснэгт 19.** Аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн газрын урсгал зардал /2019 он/

	УРСГАЛ ЗАРДАЛ	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		Цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал, ажил олгогчийн НДШ		Нормативт зардал		Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	
	Дүн /сая төгрөгөөр/	сая төгрөг	дүнд эзлэх хувь	сая төгрөг	дүнд эзлэх хувь	сая төгрөг	дүнд эзлэх хувь	сая төгрөг	дүнд эзлэх хувь	сая төгрөг	дүнд эзлэх хувь
Архангай	915,997.6	901,997.6	98.5%	205,795.2	22.5%	193,190.2	21.1%	364,638.3	39.8%	14,000.0	1.5%
Баян-Өлгий	540,261.0	538,761.0	99.7%	87,861.6	16.3%	13,701.1	2.5%	352,740.5	65.3%	1,500.0	0.3%
Баянхонгор	665,144.9	649,301.3	97.6%	89,274.2	13.4%	22,440.4	3.4%	422,535.6	63.5%	15,843.6	2.4%
Булган	667,283.2	657,054.4	98.5%	193,781.5	29.0%	6,135.8	0.9%	333,539.6	50.0%	10,228.8	1.5%
Говь-алтай	680,251.9	650,268.1	95.6%	105,886.7	15.6%	4,942.4	0.7%	401,367.5	59.0%	29,983.8	4.4%
Дорноговь	534,262.2	529,014.5	99.0%	100,336.9	18.8%	57,257.0	10.7%	278,967.0	52.2%	5,247.7	1.0%

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН  
ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ШИНЖИЛГЭЭ**

Дорнод	565,552.0	562,052.0	99.4%	77,202.3	13.7%	8,836.1	1.6%	363,287.8	64.2%	3,500.0	0.6%
Дундговь	499,472.4	497,205.0	99.5%	76,106.1	15.2%	14,288.0	2.9%	307,274.4	61.5%	2,267.4	0.5%
Завхан	714,737.6	713,247.6	99.8%	100,595.1	14.1%	29,186.5	4.1%	399,121.5	55.8%	1,490.0	0.2%
Өвөрхангай	898,631.2	889,043.4	98.9%	226,973.6	25.3%	193,905.9	21.6%	342,393.8	38.1%	9,587.8	1.1%
Өмнөговь	497,118.4	493,751.7	99.3%	71,100.7	14.3%	6,889.8	1.4%	346,194.2	69.6%	3,366.7	0.7%
Сүхбаатар	625,940.6	619,440.6	99.0%	116,343.7	18.6%	11,353.2	1.8%	357,054.9	57.0%	6,500.0	1.0%
Сэлэнгэ	558,929.3	550,088.7	98.4%	99,680.6	17.8%	19,907.1	3.6%	341,274.1	61.1%	8,840.6	1.6%
Төв	915,987.5	889,877.2	97.1%	214,140.8	23.4%	15,336.1	1.7%	531,131.2	58.0%	26,110.3	2.9%
Увс	673,294.5	659,794.5	98.0%	94,370.5	14.0%	63,164.7	9.4%	350,476.4	52.1%	13,500.0	2.0%
Ховд	872,290.6	870,915.6	99.8%	100,971.4	11.6%	64,659.5	7.4%	534,879.1	61.3%	1,375.0	0.2%
Хөвсгөл	791,572.4	772,930.9	97.6%	103,837.5	13.1%	12,861.9	1.6%	554,740.9	70.1%	18,641.5	2.4%
Хэнтий	683,573.5	670,143.5	98.0%	123,106.0	18.0%	17,189.4	2.5%	390,414.6	57.1%	13,430.0	2.0%
Дархан-Уул	305,162.7	304,162.7	99.7%	55,591.6	18.2%	6,494.4	2.1%	132,022.4	43.3%	1,000.0	0.3%
Орхон	292,058.5	291,058.5	99.7%	46,912.7	16.1%	7,762.6	2.7%	154,197.4	52.8%	1,000.0	0.3%
Говьсүмбэр	245,546.3	243,636.7	99.2%	23,164.5	9.4%	3,052.7	1.2%	166,235.7	67.7%	1,909.6	0.8%
Улаанбаатар	1,381,185.6	1,364,986.5	98.8%	390,723.4	28.3%	83,612.5	6.1%	790,394.6	57.2%	16,199.1	1.2%
<b>Нийт</b>	<b>14,524,253.9</b>	<b>14,318,732.0</b>	<b>98.6%</b>	<b>2,703,756.6</b>	<b>18.6%</b>	<b>856,167.3</b>	<b>5.9%</b>	<b>8,214,881.5</b>	<b>56.6%</b>	<b>205,521.9</b>	<b>1.4%</b>

Дээрх хүснэгтээс харахад 2019 оны гүйцэтгэлээр аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн газрын төсвийн зардлын дунджаар 98.6 хувийг бараа, үйлчилгээний зардал, үүний дотор 18.6 хувийг цалин, хөлс болон нэмэгдэл, урамшуулал, НДШ эзэлж байна.

Норматив зардалд эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл ордог бөгөөд энэхүү зардал нь 2019 оны байдлаар аймаг, нийслэлийн дунджаар нийт урсгал зардлын 5.9 хувийг эзэлж байна. Гэхдээ энэхүү зардлын хувийн жин аймаг бүрт харилцан адилгүй байна. Тухайлбал энэ зардлын урсгалд зардалд эзлэх хувь Өвөрхангай аймагт 21.6 хувийг эзэлж байгаа бол Говь-Алтай аймагт 0.7 хувийг эзэлж байна.

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн дийлэнх хэсгийг бусдаар гүйцэтгүүлсэн мал эмнэлгийн үйлчилгээ эзлэх бөгөөд энэхүү зардал нь аймаг, нийслэлийн дунджаар 2019 онд нийт урсгал зардлын 56.6 хувийг эзэлж байна.


Урсгал шилжүүлэг нь ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, шагнал, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж зэргээс бүрдэнэ. Аймаг, нийслэлийн дунджаар урсгал шилжүүлэг нь нийт мал эмнэлгийн газрын урсгал зардлын 1.4 хувийг эзэлж байна.

Аймгуудын Хүнс, хөдөө аж ахуйн газрын төсвийн урсгал зардал мөн тухайн аймгийн малын тоо, газар тариалангийн хөгжлөөс хамаарах боловч төдийлэн их зөрүүтэй биш байгаа бөгөөд 2019 оны байдлаар нэг аймагт 229.6-355.4 сая төгрөгийн зардлын гүйцэтгэлтэй байна. Энэхүү зардлын дүнг аймаг тус бүрээр 2019 оны байдлаар харьцуулан доорх Зураг 42-д үзүүлэв.



**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ШИНЖИЛГЭЭ**

**Зураг 42. Аймгуудын Хүнс, хөдөө аж ахуйн газрын урсгал зардлын дүн /2019/**



Орон нутгийн Хүнс, хөдөө аж ахуйн газруудын урсгал зардлын бүтцийг авч үзвэл 2019 оны байдлаар 95.2 хувийг бараа, үйлчилгээний зардал, түүний дотор 62.2 хувийг цалин хөлс, нэмэгдэл, урамшуулал, НДШ эзэлж байна. Бараа, үйлчилгээний бусад зардалд байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, хангамж, бараа материалын зардал, норматив зардал, эд хогшил, урсгал засвар, томилолт, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр болон бусад үйлчилгээний зардал орох бөгөөд эдгээр нь дунджаар нийт урсгал зардлын 32.9 хувийг эзэлж байна. Харин урсгал шилжүүлэг нь нийт урсгалын зардлын 4.8 хувь буюу багахан хэсгийг эзэлж байна. Урсгалд шилжүүлэгт ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, нэг удаагийн тэтгэмж, шагнал, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж ордог. Бүх аймгуудын Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2019 оны урсгал зардлын бүтцийг Хүснэгт 20-ээр харууллаа.

**Хүснэгт 20. Аймгуудын Хүнс, хөдөө аж ахуйн газрын урсгал зардлын бүтэц /2019/**

	УРСГАЛ ЗАРДАЛ Дүн /сая төгрөг/	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		Цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал, НДШ		Бараа үйлчилгээний бусад зардал		УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	
		сая төгрөг	ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ	сая төгрөг	ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ	сая төгрөг	ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ	сая төгрөг	ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ
Архангай	313,569.7	312,069.7	99.5%	197,775.3	63.1%	114,294.4	36.4%	1,500.0	0.5%
Баян-Өлгий	273,999.1	272,374.1	99.4%	161,980.2	59.1%	110,393.9	40.3%	1,625.0	0.6%
Баянхонгор	325,648.6	295,579.6	90.8%	180,290.4	55.4%	115,289.2	35.4%	30,069.0	9.2%
Булган	334,495.7	329,014.7	98.4%	242,593.9	72.5%	86,420.8	25.8%	5,481.0	1.6%
Говь-алтай	305,659.1	290,737.4	95.1%	187,426.7	61.3%	103,310.7	33.8%	14,921.7	4.9%
Дорноговь	252,463.4	231,469.1	91.7%	161,497.3	64.0%	69,971.8	27.7%	20,994.3	8.3%
Дорнод	249,463.7	247,963.7	99.4%	173,578.0	69.6%	74,385.7	29.8%	1,500.0	0.6%
Дундговь	290,602.4	262,183.3	90.2%	177,500.3	61.1%	84,683.0	29.1%	28,419.1	9.8%
Завхан	338,744.6	301,351.1	89.0%	222,814.9	65.8%	78,536.2	23.2%	37,393.5	11.0%
Өвөрхангай	257,854.6	256,354.6	99.4%	169,641.0	65.8%	86,713.6	33.6%	1,500.0	0.6%

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН  
ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ШИНЖИЛГЭЭ**

Өмнөговь	285,269.7	275,451.4	96.6%	199,915.7	70.1%	75,535.7	26.5%	9,818.3	3.4%
Сүхбаатар	337,299.1	326,968.8	96.9%	168,410.3	49.9%	158,558.5	47.0%	10,330.3	3.1%
Сэлэнгэ	324,926.2	323,525.1	99.6%	210,779.1	64.9%	112,746.0	34.7%	1,401.1	0.4%
Төв	355,446.2	328,736.0	92.5%	238,080.1	67.0%	90,655.9	25.5%	26,710.2	7.5%
Увс	296,688.6	275,573.8	92.9%	198,181.5	66.8%	77,392.3	26.1%	21,114.8	7.1%
Ховд	311,420.7	278,461.2	89.4%	179,139.7	57.5%	99,321.5	31.9%	32,959.5	10.6%
Хөвсгөл	335,575.5	313,301.0	93.4%	245,198.3	73.1%	68,102.7	20.3%	22,274.5	6.6%
Хэнтий	296,108.3	294,608.3	99.5%	192,133.9	64.9%	102,474.4	34.6%	1,500.0	0.5%
Дархан-Уул	290,020.0	287,316.3	99.1%	139,055.7	47.9%	148,260.6	51.1%	2,703.7	0.9%
Орхон	297,239.3	285,226.8	96.0%	144,172.3	48.5%	141,054.5	47.5%	12,012.5	4.0%
Говьсүмбэр	229,612.4	208,298.1	90.7%	132,166.1	57.6%	76,132.0	33.2%	21,314.3	9.3%
Нийт	6,302,106.9	5,996,564.1	95.2%	3,922,330.7	62.2%	2,074,233.4	32.9%	305,542.8	4.8%

Орон нутгийн ХХААГ-ын урсгал зардлыг улсын төсвөөс санхүүжүүлж байгаа бол Мал эмнэлгийн газрын үйл ажиллагааны урсгал зардлыг улс болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж байна. Улсын төсөв болон орон нутгийн төсвөөс аль төрлийн зардлыг санхүүжүүлэхийг 2017 онд батлагдсан Малын генетик нөөцийн тухай хууль болон Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд тодорхойлон заасан байна.

Тухайлбал Малын генетик нөөцийн тухай хуульд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улс, орон нутгийн төсвөөр ялган тодорхой заасныг дараах хүснэгтээр үзүүлнэ.

**Хүснэгт 21.** Малын генетик нөөцийн тухай хууль заасан зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, зардлын төрлөөр

Улсын төсвөөс	Орон нутгийн төсвөөс
18.2.1.малын генетик нөөцийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан, үндэсний генийн санг бүрдүүлэх, ажиллуулах;	8.3.1.батлагдсан үүлдэр, омгийн малын генетик нөөцийн биологийн ашигт шинж чанарыг бататгах, үржлийн ажлын ололтыг хянан баталгаажуулах, цөм сүргийг сайжруулах арга хэмжээний зардал;
18.2.2.малын генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлох, үнэлэх;	18.3.2.малын бэлчээрийг сайжруулах, хадлан, тэжээл бэлтгэх, усан хангамжийг нэмэгдүүлэх арга хэмжээний зардал
18.2.3.төрийн өмчийн цөм сүрэг бүрдүүлэх, үржлийн малд үзлэг, ангилалт хийх, баталгаажуулах, гойд ашиг шимт сайжруулагч малыг шалгаруулах, улсын бүртгэл, үржлийн дэвтэр хөтлөх;	18.3.3.тоо нь цөөрсөн, мөхөхөд хүрсэн үүлдэр, омгийн малыг гардан маллаж, үүлдэрлэг байдлыг нь хамгаалж, сайжруулахад үзүүлэх энэ хуулийн 13.4-т заасан дэмжлэг, урамшуулал;
18.2.4.малд удам зүйн үнэлгээ хийх;	18.3.4.өсвөр хээлтүүлэгчийг сонгох, ялган суурилж, үржлийн нас хүртэл бойжуулах зардал;
18.2.5.энэ хуулийн 10.5-д заасан биотехнологийн ололтыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх	18.3.5.малын генетик нөөцийн сурталчилгааны зардал;
18.2.6.хязгаарлагдмал нөөц, тархац, ашиглалттай, үл давтагдах өвөрмөц үнэ цэнэ бүхий малыг хамгаалах;	18.3.6.Энэ хуулийн 16.9.6-д заасан арга хэмжээний зардал.
18.2.7.мал, үржүүлгийн бүтээгдэхүүн, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд чанарын үзлэг, шинжилгээ хийх.	
18.3.Малын генетик нөөцийн үйл ажиллагааны дараахь зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ:	

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН  
ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ШИНЖИЛГЭЭ**

Мөн Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд улс, орон нутгийн төсвөөс мал эмнэлгийн үйлчилгээний зардлуудыг дараах Хүснэгт 22-д харуулсан байдлаар санхүүжүүлэхээр заасан.

**Хүснэгт 22. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд Мал эмнэлгийн үйлчилгээний санхүүжилтийг заасан эх үүсвэр /улс, орон нутгийн төсөв/**

Улсын төсвөөс	Аймаг, нийслэлийн төсвөөс	Сум, дүүргийн төсвөөс
33.1.1.энэ хуулийн 7.14-т заасан хяналтын цэгийн үйл ажиллагааны зардал /7.14.Халдварт өвчингүй, тайван бүс, нутагт нэвтэрч байгаа улсын чанартай авто замыг түшиглэсэн байнгын ажиллагаатай мал эмнэлгийн хорио цээрийн хяналтын цэгийг Засгийн газрын шийдвэрээр байгуулна/	34.2.1.энэ хуулийн 13.4-т заасан дэд төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний зардал /13.4.Улсын бэлэн байдлын төлөвлөгөөнд тусгайлан заасан бол аймаг, нийслэлийн мал эмнэлгийн байгууллага, мал эмнэлгийн тасгийн саналыг үндэслэн тухайн шатны Засаг дарга харьяалах нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд хэрэгжүүлэх бэлэн байдлын дэд төлөвлөгөөг батална./	34.3.1.энэ хуулийн 13.4-т заасан дэд төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний зардал /13.4.Улсын бэлэн байдлын төлөвлөгөөнд тусгайлан заасан бол аймаг, нийслэлийн мал эмнэлгийн байгууллага, мал эмнэлгийн тасгийн саналыг үндэслэн тухайн шатны Засаг дарга харьяалах нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд хэрэгжүүлэх бэлэн байдлын дэд төлөвлөгөөг батална/
33.1.2.энэ хуулийн 11.1.1-д заасан жагсаалтад орсон халдварт өвчинтэй тэмцэх, устгах арга хэмжээний зардал /11.1.1.мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний олон улсын худалдаанд хориг саад үүсгэдэг гоц халдварт, халдварт өвчин, хүний амь нас хохирох эрсдэл үүсгэдэг зооноз өвчин/:	34.2.2.энэ хуулийн 11.1.2-т заасан жагсаалтад орсон халдварт өвчинтэй тэмцэх, устгах арга хэмжээний дараахь зардал /11.1.2.мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний дотоодын худалдаанд хориг саад үүсгэдэг гоц халдварт, халдварт өвчин, энэ хуулийн 11.1.1-д зааснаас бусад зооноз өвчин/:	34.3.2.дуудлагын дагуу анхны онош тогтоох үйл ажиллагааны тээвэр, шатахууны зардал, халдварт өвчин гарсан үед хэрэгжүүлэх арга хэмжээнд шаардагдах халдваргүйтгэлийн бэлдмэлийн үнэ;
33.1.2.1.вакцин, оношлуур, халдваргүйтгэлийн бэлдмэл, хамгаалах хувцас, хэрэгслийн үнэ; 33.1.2.2.тандалт, судалгаа, лабораторийн шинжилгээ, дархлаажуулалт хийх, мэдээллийн сан бүрдүүлж ажиллуулах үйл ажиллагааны зардал; 33.1.2.3.эмнэл зүйн үзлэг, тарилга, халдваргүйтгэл хийх, лабораторийн шинжилгээнд зориулан сорьц авах болон мал эмнэлгийн бусад үйлчилгээний хөлс;	34.2.2.1.энэ хуулийн 33.1.2.1-33.1.2.3-т заасан зардал;	34.3.3.харьяалах нутаг дэвсгэрийн мал, амьтныг эрүүлжүүлэх зорилгоор сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан хөтөлбөр, төсөл, төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний зардал.
33.1.2.4.зайлшгүй шаардлагаар төхөөрсөн малын тухайн орон нутаг дахь жишиг үнийн 40 хувь, гоц халдварт өвчний улмаас зайлшгүй шаардлагаар устгасан малын тухайн орон нутаг дахь жишиг үнийн 90 хувьтай тэнцэх нөхөн төлбөр.	34.2.2.2.зайлшгүй шаардлагаар төхөөрсөн малын тухайн орон нутаг дахь жишиг үнийн 40 хувьтай тэнцэх нөхөн төлбөр.	
33.1.3.халдварт болон шимэгчтэх өвчнийг тандах, эрт илрүүлэхэд шаардагдах үйл ажиллагааны зардал, эмнэл зүйн үзлэг хийх, лабораторийн шинжилгээнд зориулан сорьц авах үйлчилгээний хөлс, оношлуурын үнэ: 33.1.3.1.шинэ болон дахин сэргэж байгаа халдварт өвчин; 33.1.3.2.энэ хуулийн 21.4-т заасан шимэгчтэх өвчин. /улсын хэмжээнд аюул учруулах хэмжээнд хүрвэл/	34.2.3.хорио цээрийн дэглэм тогтоох өвчний жагсаалтад орсон гоц халдварт өвчнөөс бусад халдварт өвчин гарсан үед тухайн шатны Засаг даргын шийдвэрээр хэрэгжүүлж байгаа голомтыг устгах, хяналтад авах арга хэмжээний зардал;	

33.1.4.эмийн сорилт хийхэд ашиглагдах омог сэргээх, энэ хуулийн 4.1.13-т заасны дагуу ийлдсийн сан бүрдүүлэх, тэдгээрийг хадгалах, ашиглахад шаардагдах зардал;	34.2.4.харьяалах нутаг дэвсгэрийн мал, амьтныг эрүүлжүүлэх зорилгоор аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан хөтөлбөр, төсөл, төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний зардал.	
33.1.5.гоц халдварт өвчин гарсан үед энэ хуулийн 19.1, 19.3-т заасны дагуу байгуулагдсан мэргэжлийн баг, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнд дайчлагдан ажилласан малын эмч, мэргэжилтэн, албан хаагч, иргэдэд олгох дараахь зардал: 33.1.5.1.ердийн үеийнхээс гурав дахин нэмэгдүүлсэн томилолтын зардал; 33.1.5.2.албан үүргээ гүйцэтгэж байгаад амь насаа алдсан иргэний ар гэрт олгох 36 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмж.		

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай (ЗЗНДНТУТ) хууль 2020 оны 12-р сард шинэчлэгдэн батлагдсан бөгөөд 2022 оны 1 дүгээр сарын 1-нээс мөрдөхөөр хуульчилсан.

Одоо мөрдөж буй Төсвийн тухай хуулиар орон нутгийн чиг үүргийг тодорхойлж байгаа бол дээрх ЗЗНДНТУТ хуулиар орон нутгийн чиг үүргийг тогтоож, Төсвийн тухай хуулийн 58-р зүйлд заасан орон нутгийн чиг үүргийг хасаж зохицуулахаар болсон.

Хуулийн энэхүү өөрчлөлтийн ХХААХҮ-ийн салбартай холбоотой зохицуулалтыг дараах хүснэгтээр харуулав.

**Хүснэгт 23.** ЗЗНДНТУТ хууль болон Төсвийн тухай хуулинд заасан орон нутгийн чиг үүргийн талаарх заалтууд

ЗЗНДНТУТ хуульд заасан орон нутгийн чиг үүргүүд	Төсвийн тухай хуулийн 58-р зүйлд заасан орон нутгийн чиг үүргүүд /Энэ зүйл, заалтууд 2022 оны 1-р сарын 1-нээс хүчингүй болно/
<b>Аймгийн чиг үүрэг</b>	
21.1.7. аймгийн хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн хөтөлбөр, хэрэгжилтэд тавих хяналт; 21.1.8. аймгийн жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн менежмент; 21.1.9. худалдаа, үйлчилгээний нийтлэг зохицуулалт, хяналт;	58.2.9. малын тэжээлийн нөөц бүрдүүлэх; 58.2.6. жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх; 58.2.8.аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд бэлчээрийн менежмент хийх; 58.2.12. мал, амьтны халдварт, шимэгчлэх өвчинтэй тэмцэх, хортон шавжийн устгал, хяналт, гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн хор хохирлыг арилгах, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх; 58.2.20. хуульд заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.
<b>Сумын чиг үүрэг</b>	
22.1.7. аймгийн хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн хөтөлбөрийн хэрэгжилт; 22.1.8. сумын хүн амын ундны болон ахуйн хэрэгцээний уст цэгийн төлөвлөлт, байршил, ашиглалт, хамгаалалт; 22.1.9.худалдаа, үйлчилгээний зохион байгуулалт, хяналт	58.4.4. мал, амьтны халдварт, шимэгчлэх өвчинтэй тэмцэх, хортон шавжийн устгал, хяналт, гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн хор хохирлыг арилгах, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх; 58.4.5. сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд бэлчээрийн менежмент хийх; 58.4.11. хуульд заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.
<b>Нийслэлийн чиг үүрэг</b>	
24.1.6. нийслэлийн жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн менежмент;	58.1.6. жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх; 58.1.7.бэлчээрийн менежмент хийх;

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН  
ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ШИНЖИЛГЭЭ**

24.1.7. нийслэлийн хүн амын ундны болон ахуйн хэрэгцээний уст цэгийн төлөвлөлт, хяналт;	58.1.12. мал амьтны халдварт, шимэгчтэх өвчинтэй тэмцэх, хортон шавжийн устгал, хяналтыг хэрэгжүүлэх, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх;
24.1.9. худалдаа, үйлчилгээний нийтлэг зохицуулалт, хяналт;	58.1.21.хуульд заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.
<b>Дүүргийн чиг үүрэг</b>	
25.1.6. худалдаа, үйлчилгээний зөвшөөрөл, хяналт;	58.3.4.эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх, мал, амьтны халдварт, шимэгчтэх өвчинтэй тэмцэх, хортон шавжийн устгал, хяналт, гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн хор хохирлыг арилгах, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх;
25.1.7.нийслэлийн үйлдвэрлэлийн хөтөлбөрийн хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн хөтөлбөрийн хэрэгжилт;	58.3.8.хуульд заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

Дээрх хүснэгтэд харуулснаар Төсвийн тухай хуулийн одоогийн зохицуулалтаар буюу 2022 оны 1-р сарын 1 хүртэл ХХААХҮ-ийн салбарт орон нутгийн төсвийн хөрөнгөөр дараах чиг үүргийг хэрэгжүүлж байна. Үүнд:

- малын тэжээлийн нөөц бүрдүүлэх;
- аймаг, сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд бэлчээрийн менежмент хийх;
- мал, амьтны халдварт, шимэгчлэх өвчинтэй тэмцэх, хортон шавжийн устгал, хяналт, гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн хор хохирлыг арилгах, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх;
- жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх;
- хуульд заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх

Дээрх чиг үүргийн дагуу 2021 оны орон нутгийн төсөвт дараах зардлууд тусгагдсан байна.

**Хүснэгт 24.** Улсын болон орон нутгийн төсөв тусгагдсан ХХААХҮ-ийн салбарын төсвийн зардал (зориулалтаар, сая төгрөгөөр)

	Нэгдсэн төсөв	Улсын төсөв	Орон нутгийн төсөв
<b>Хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэрлэл, худалдаа</b>	<b>122,819.3</b>	<b>113,333.0</b>	<b>9,486.3</b>
Мал эмнэлгийн үйлчилгээ	15,867.9	9,084.3	6,783.6
Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх	6,055.0	3,352.3	2,702.7
Малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх	14,229.7	14,229.7	0.0
Малыг архаг халдварт өвчнөөс эрүүлжүүлэх	5,169.9	5,169.9	0.0
Малын өвчний лабораторийн оношилгоо, шинжилгээ	1,023.4	1,023.4	0.0
Малын өвчнөөс сэргийлэх сургалт, сурталчилгаа, судалгаа шинжилгээний ажил	319.5	319.5	0.0
Мал эмнэлгийн ариутгал, халдваргүйжүүлэлт	673.9	673.9	0.0
Өндөр ашиг шимтэй мал үржүүлэх	70.8	70.8	0.0
Үлийн цагаан оготной тэмцэх	1,752.7	1,752.7	0.0
Хөнөөлт царцаатай тэмцэх	247.0	247.0	0.0
Отрын бүс байгуулах, хамгаалах	27.9	27.9	0.0
Хамгаалагдсан хөрсний тариалан эрхлэхэд дэмжлэг үзүүлэх	375.0	375.0	0.0
Жимс, жимсгэний тариалан эрхлэхэд дэмжлэг үзүүлэх	439.8	439.8	0.0
Ургацын комисс, төв штаб, удирдлагын зардал	4.1	4.1	0.0
Хүнсний хангамж, аюулгүй байдал, хяналтын судалгаа	251.3	251.3	0.0
Сайн малчны шагнал	444.0	444.0	0.0



**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН  
ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ШИНЖИЛГЭЭ**

Хөнгөн үйлдвэрийн үндэсний хөтөлбөрүүд	273.8	273.8	0.0
“Монголд үйлдвэрлэв” үзэсгэлэн	120.0	120.0	0.0
Монгол мал хөтөлбөр	1,849.1	1,849.1	0.0
Мал, амьтан эрүүлжүүлэх	8,303.5	8,303.5	0.0
ХАА-н салбарын бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийг дэмжих урамшуулал	65,320.8	65,320.8	0.0
<b>Нөөц хөрөнгийн зориулалт</b>	<b>24,547.7</b>	<b>22,512.5</b>	<b>2,035.2</b>
Хүнс барааны нөөц	1,477.4	1,477.4	0.0
Өвс, тэжээлийн нөөц	6,955.2	4,920.0	2,035.2
Үрийн нөөц	5,401.7	5,401.7	0.0
Таваарын буудайн нөөц	6,500.0	6,500.0	0.0
Улсын нөөцийн барааны сэлгэлт, бүрдүүлэлт	1,082.7	1,082.7	0.0
Дархан арьс ширний цогцолборын бүтээн байгуулалтын зээлийн хүүгийн татаас	5,000.0	5,000.0	

Эх үүсвэр: СЯ

Дээрх зардлуудаас орон нутгийн төсвөөс санхүүжих зардлын зүйл болон нэгдсэн төсөвт эзлэх хувийг доорх хүснэгтээр үзүүлээ.

**Хүснэгт 25. ХХААХҮ-ийн салбарын урсгал зардлын орон нутгийн төсвөөрх санхүүжилт**

	Нэгдсэн төсөв	Улсын төсөв	Орон нутгийн төсөв	Нэгдсэн төсөв/ орон нутгийн төсөв
Мал эмнэлгийн үйлчилгээ	15,867.9	9,084.3	6,783.6	42.8%
Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх	6,055.0	3,352.3	2,702.7	44.6%
Өвс, тэжээлийн нөөц	6,955.2	4,920.0	2,035.2	29.3%

Дээрхээс харахад 2021 онд улсын хэмжээнд мал эмнэлгийн үйлчилгээний төсвийн зардлын 42.8 хувийг, малын халдварт өвчнөөс урьдчилсан сэргийлэх арга хэмжээний зардлын 44.6 хувийг, өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэх зардлын 29.3 хувийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр тусгасан байна.

Ирэх жилийн эхнээс хэрэгжих ЗЗНДНТУТ хуульд зааснаар ХХААХҮ-ийн салбарт орон нутгийн төсвийн хөрөнгөөр дараах чиг үүргийг хэрэгжүүлэх болж байна. Үүнд:

- аймгийн хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн хөтөлбөр, хэрэгжилт, хэрэгжилтэд тавих хяналт;
- аймгийн жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн менежмент;
- худалдаа, үйлчилгээний нийтлэг зохицуулалт, хяналт;

ЗЗНДНТУТ хуульд зааснаар мал эмнэлгийн үйлчилгээний чиг үүргийг орон нутгийн чиг үүргээс хассан байна. Өөрөөр хэлбэл мал эмнэлгийн үйлчилгээтэй холбоотой бүхий л зардлыг улсын төсвөөс буюу ХХААХҮЯ-наас санхүүжүүлэхээр харагдаж байна. Нөгөө талаас, Малын генетик нөөцийн тухай хууль, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд заасан мал эмнэлгийн үйлчилгээний тодорхой зардлуудыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх заасан тул эдгээр хуулиудын уялдуулж нийцүүлэх шаардлагатай.

ЗЗНДНТУТ хуульд орон нутгийн чиг үүрэгт аймаг, нийслэлийн хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн хөтөлбөр, хэрэгжилтэд тавих хяналт гэсэн чиг үүргийн оруулсан байх бөгөөд үүнд аймаг, нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, сумдын хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэрлэл хариуцсан чиг үүргийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэгдэхээр тусгагдсан гэж

## ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ШИНЖИЛГЭЭ

ойлгогдохоор байна. Тиймээс энэ талаар 2022 оны төсвийн төсөл боловсруулахаас өмнө ХХААХҮЯ болон Сангийн яам хамтран улс, орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх чиг үүргийг нарийвчлан тодорхой болгох нь зүйтэй.

### 3.2.5 Салбарын зээл, тусламжийн төслүүдийн хэрэгжилт

ХХААХҮ-ийн салбарт сүүлийн 5 жилд 260 орчим тэрбум төгрөгийн зээл, тусламжийг авч ашигласан байна.

Зээл, тусламжийн төслүүдийн нэр, үнийн дүнг 2016-2020 оноор дараах хүснэгтэд үзүүлэв.

**Хүснэгт 26. ХХААХҮ-ийн салбарт хэрэгжүүлсэн гадаадын зээл, тусламжийн дүн, тэрбум төгрөгөөр /2016-2020 он/**

	2016	2017	2018	2019	2020	Нийт
ХХААХҮ-ийн салбарын зээл, тусламжийн дүн	13.9	37.5	56.7	95.3	56.0	260.0
ЖДҮХБОХ 2 дахь шатны төсөл	0.5	1.3	0.4	0.3	0.2	2.7
Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл нэмэлт санхүүжилт	3.0	4.0	1.6	4.5	7.8	20.9
Зудын гамшгийн тусламж	3.1					3.1
ЗБД-ын системийг дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлэх, ажлын байрыг бий болгох төсөл		3.2	29.0	17.1	11.8	61.1
Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл					5.3	5.3
Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах төсөл				0.9	2.3	3.2
Хөдөө аж ахуй хөдөөгийн хөгжлийн төслийн нэмэлт санхүүжилт	6.0	28.0	23.4	31.8	23.6	112.8
Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил төсөл, MON-0115	0.2					0.2
Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих төсөл				39.0		39.0
Хүнсний ногооны тариалалт, усалгаатай газар тариаланг дэмжих төсөл						0.7
Хүртээмжтэй өсөлтийг хөгжүүлэх техник туслалцааны төсөл, ТА 8241	1.2					1.2
Экспортыг дэмжих төсөл	0.0	0.9	2.3	1.8	5.0	9.8

Эх үүсвэр: СЯ, ХХААХҮЯ

ХХААХҮ-ийн салбарт олон улсын байгууллага, хандивлагч орнуудын зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй томоохон төслүүдийн товч мэдээллийг төсөл тус бүрээр дор тусгав.

### 1. Зах зээл ба бэлчээрийн удирдлага төсөл

НҮБ-ын Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сангийн санхүүжилтээр ХХААХҮЯ-наас хэрэгжүүлж буй “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төслийн Нэмэлт санхүүжилт нь 2018 оны 5 сараас 2021 оны 09 сар хүртэл хугацаанд нийт 6 аймгийн 18 суманд “Монголын бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбоо” болон “Хөгжлийн оньсон түлхүүр төв” ТББ нь хамтран хэрэгжүүлж байна. Төсөл хэрэгжиж байгаа аймаг, сумдын малчид болон орлого багатай иргэдийн ядуурлыг бууруулж амьжиргааг дээшлүүлэхэд төслийн зорилго чиглэгдэж байна. Зах зээл бэлчээрийн удирдлага төсөл үндсэн гурван бүрэлдэхүүн хэсэгтэй. Үүнд:



**Бүрэлдэхүүн хэсэг 1. Бэлчээрийн менежмент, уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох**

Бэлчээрийн 144 малчны бүлэг байгуулж, бүлгийн 3 жилийн төлөвлөгөөг оролцооны аргаар боловсруулж, малчид, сумын удирдлагад зориулсан бэлчээр, мал аж ахуй, эрсдлийн менежментийн багц сургалтуудыг зохион байгуулах Малчдын бүлгийн хуримтлалын санг дэмжих, уур амьсгалын өөрчлөлтийг даван туулахад чиглэсэн хөрөнгө оруулалтуудыг сумын болон бүлгийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан хэрэгжүүлнэ. Үүнд: гүн өрмийн худаг шинээр гаргах, засварлах, бороо цасны ус цуглуулах хөв цөөрөм байгуулах, хадлангийн нөөц талбайг хамгаалтад авах, бага оврын трактор олгох, бог мал угаах цэг байгуулах, үлийн цагаан оготонотой тэмцэх, тэжээлийн аюулгүйн нөөцийн агуулах, саравч барих, эрсдэлийн сан байгуулах, мал үржлийн дэмжлэг үзүүлэх, малчдад зориулсан мэдээллийн төв байгуулах зэрэг ажлууд орж байна.

**Бүрэлдэхүүн хэсэг 2. Зах зээлийн хөгжил**

Эмэгтэйчүүд давамгайлсан бүлгүүд, хөдөөгийн бичил, жижиг аж ахуйн нэгжүүдийн бизнесийн үйл ажиллагааг дэмжиж, зах зээлд нэвтрэхэд нь туслах хөрөнгө оруулалт, чадавч бэхжүүлэх ажлуудыг хэрэгжүүлнэ. Бүлэг хоршоод, жижиг аж ахуйн нэгжүүдийг зээл, зээлийн батлан даалтын үйлчилгээнд хамруулж бүлгүүдийн хуримтлалын санг хадгаламж, зээлийн хоршоотой холбоход дэмжлэг үзүүлнэ.

**Бүрэлдэхүүн хэсэг 3. Бизнесийн орчин сайжруулах ба бренд бүтээгдэхүүн хөгжүүлэх**

Сүү, жимс, жимсгэнэ, хүнсний ногооны нэмүү өртгийн сүлжээний хөгжлийг дэмжих, төслийн орон нутгийн бренд бүтээгдэхүүнийг тодорхойлох, хөрөнгө оруулалт хийх, зах зээлд нэвтрэх, тэлэхэд нь дэмжлэг үзүүлэх, бренд бүтээгдэхүүний зах зээлийн орчинг сайжруулах, бичил жижиг бизнес эрхлэгчдийн батлан даалттай зээлд хамруулах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

**2. Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл**

Олон улсын хөгжлийн ассоциацийн 30 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлээр санхүүжигдэх энэхүү төсөл нь Дэлхийн банкны 11 сая ам.долларын санхүүжилтээр 2013-2017 онд хэрэгжүүлсэн “Хөдөө аж ахуйн маркетинг” төслийн 2-р үе шат юм. “Хөдөө аж ахуйн маркетинг” төслийн хүрээнд Хөвсгөл, Завхан, Архангай, Говь-Алтай, Баянхонгор гэсэн 5 аймгийн 15 суманд малчдыг зах зээл, хэрэглэгчидтэй шууд холбох, мал сүргийн үүлдэр угсааг сайжруулах, үр ашгийг нэмэгдүүлэх, мал аж ахуйн салбарын нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх арга хэмжээнд голлон анхаарсан. Уг төсөлд 13,684 малчид хамрагдсан ба төсөлд хамрагдсан нийт малчдын мах, сүү, ноос, ноолуураас олох орлого дунджаар 78 хувиар нэмэгдсэн дүн гарсан байна. “Хөдөө аж ахуйн маркетинг” төслийн үр дүнд суурилж, төслийн 2 дугаар үе шат буюу “Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх” төслийг мал сүргийн эрүүл мэнд, бүтээмж, нэмүү өртгийн сүлжээний эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх, онцгой нөхцөл байдал, гамшгийн үед шуурхай, үр дүнтэй авч болох хариу арга хэмжээг санхүүжүүлэх зорилготойгоор 2020-2025 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Төслийн бүрэлдэхүүн хэсэг болон дэд бүрэлдэхүүтэй хэсгүүд, тэдгээрийн санхүүжилтийн төлөвлөгөөг төсөл эхлэх үеийн байдлаар дараах хүснэгтээр үзүүлэв.

**Хүснэгт 27. МАА-н эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төслийн бүрэлдэхүүн хэсгүүд**

№	Бүрэлдэхүүн хэсэг болон дэд бүрэлдэхүүн хэсгүүд	Санхүүжилтийн дүн сая ам.доллар
1	Малын эрүүл мэндийн үйлчилгээг бэхжүүлэх	20.0
1.1	Байгууллагын болон хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх	5.0
1.2	Малын өвчний тандалт ба хяналт, хүнсний аюулгүй байдлыг сайжруулах	9.0
1.3	Салбарын цахим үйлчилгээг сайжруулах	4.0
1.4	Мал сүргийн эрүүл мэндийн эрсдлийг удирдах орон нутгийн иргэдийн оролцоонд суурилсан санаачлагуудыг дэмжих	2.0
2	Нэмүү өртгийн сүлжээний эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх	8.0
2.1	Мал сүргийн бүтээмжийг нэмэгдүүлэх	2.0
2.2	Бүтээмжит түншлэлийг хөгжүүлэх	6.0
3	Төслийн хэрэгжилтийг дэмжих	2.0
4	Байгалийн гамшиг, онцгой байдлын үед хариу арга хэмжээ авах	
	Нийт	30.0

Төслийн хэрэгжилтийн явцад төслийн бүрэлдэхүүн хэсгүүдийн санхүүжилтийн дүнд 2021 онд тодотгол хийж, тодорхой өөрчлөлтүүд орсон болно.

### **3. Экспортыг дэмжих төсөл**

Тус төсөл нь 2017 оноос хэрэгжиж эхэлсэн төслийн үргэлжлэл бөгөөд Дэлхийн банкны 20 сая ам.долларын санхүүжилтэйгээр 2020-2023 он хүртэл хэрэгжих ба уул уурхайн бус салбарын ААН-үүдийн экспортын чадавхыг бэхжүүлэх, экспортын зах зээлд нэвтрэх боломжийг өргөжүүлэх, Ковид-19 цар тахлын үр нөлөөг бууруулахад дэмжлэг үзүүлэх зорилготой төсөл юм. Төсөл нь 4 бүрэлдэхүүн хэсэгтэй бөгөөд бүрэлдэхүүн хэсэг тус бүрт дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

#### **Бүрэлдэхүүн хэсэг 1. Экспортын шинэ нэр төрлийн санхүүгийн бүтээгдэхүүн хөгжүүлэх**

Энэ бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд Экспортын зээлийн даатгалын бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлж, экспортлогч нарт санал болгох юм. Экспортын даатгалын шинэ бүтээгдэхүүн хөгжүүлж, зах зээлд нэвтрүүлэхтэй холбоотойгоор түүнийг хэрэгжүүлэгч байгууллага болох Үндэсний Давхар Даатгал ХК (ҮДД ХК), бусад холбогдох байгууллагын чадавхыг бэхжүүлэх ажлууд хийгдэнэ.

#### **Бүрэлдэхүүн хэсэг 2. Экспортын өрсөлдөх чадвар, зах зээлд нэвтрэх боломжийг нэмэгдүүлэх**

Уул уурхайн бус салбарын ААН-үүдийн экспортын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, Монгол улсын экспортын бодлого боловсруулах чадавхыг сайжруулах, гадаад зах зээлд нэвтрэх боломжийг өргөжүүлэх зорилго бүхий энэхүү бүрэлдэхүүн хэсэг нь дараах 4 дэд хэсэгтэй. Эдгээр нь 1) Худалдаа экспортын бодлого зохицуулалт, чадавх сайжруулах, 2) Олон улсын зах зээл дэх өрсөлдөх чадварыг сайжруулах, 3) Түншлэлийн хөтөлбөр, 4) ААН-үүдэд цар тахлын хүндрэлийг давах туулахад үзүүлэх санхүүгийн дэмжлэг зэрэг болно.

#### **Бүрэлдэхүүн хэсэг 3. Баталгаажуулалтын үйлчилгээ, чанарын удирдлагыг сайжруулах**

Энэ бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнд:

- Бүтээгдэхүүн экспортлогч болон экспортлохоор зорьж буй ААН-үүдийн чанарын удирдлагын тогтолцоог сайжруулахад дэмжлэг үзүүлэх
- Олон улсын чанарын шаардлага хангахад тусламж үзүүлж, сургалт, зөвлөгөө өгөх



- Тохирлын үнэлгээ, чанарын баталгаажилтын байгууллагуудын чадавхыг сайжруулах, арга аргачлалаар хангах
- Үндэсний итгэмжлэлийн байгууллагыг чадавхжуулахад хамтран ажиллах
- Нэн шаардлагатай олон улсын стандартуудыг дотоодод нэвтрүүлэх, хэрэгжилтийг сайжруулах
- Дотоодын холбогдох стандартуудыг олон улсын стандартад дүйцүүлэхэд дэмжлэг үзүүлэх зэрэг болно.

#### **Бүрэлдэхүүн хэсэг 4. Төслийн удирдлага**

Төсөл хэрэгжүүлэх нэгжийн зөвлөх үйлчилгээ, худалдан авалт, санхүү, сургалтын үйл ажиллагаа энэхүү бүрэлдэхүүн хэсэгт орно.

#### **4. Зээлийн батлан даалтын тогтолцоог сайжруулах замаар эдийн засгийг төрөлжүүлж ажлын байрыг нэмэгдүүлэх төсөл**

Төслийн үйл ажиллагааны зорилго нь жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн санхүүжилт авах боломж болон бизнесийн тогтвортой байдлыг сайжруулах замаар эдийн засгийн өсөлт, төрөлжүүлэлт болон ажлын байр бий болгоход дэмжлэг үзүүлэхэд оршино.

Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк хооронд 2016 оны 1 дүгээр сарын 8-ны өдөр байгуулсан зээлийн хэлэлцээрийн дагуу Азийн хөгжлийн банк нь Монгол Улсад дээрх зээлийн хэлэлцээрт тусгагдсан 60.0 сая ам долларын хөнгөлөлттэй зээлийг барьцаа хөрөнгө дутагдалтай жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч нарын зээлийн батлан даалтад зориулах бөгөөд Зээлийн батлан даалтын сан нь энэхүү төслийг хэрэгжүүлж байна.

Уг төсөл нь 2016-2021 онд хэрэгжихээр төлөвлөсөн ба 2023 он хүртэл сунгагдсан байна. АХБ-наас төслийн хүрээнд 2020 оны эцсийн байдлаар 60.1 тэрбум төгрөгийн төслийн санхүүжилт болох хөнгөлөлттэй зээлийг хүлээн аваад байна. Төслийн үндсэн үйл ажиллагааны хүрээнд Азийн хөгжлийн банкны шалгуурыг хангасан арилжааны банкуудад жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч нарын зээлийн батлан даалт гаргаснаас гэрээний дагуу 90 хувь нь Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээс, 10 хувь нь Зээлийн батлан даалтын сангийн эх үүсвэрээс тус тус санхүүжүүлж байна.

#### **5. Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй төсөл**

Төслийн зорилго нь услалтын системүүдийг шинээр барих, сэргээн засварлах замаар хүнсний ногооны үйлдвэрлэлийг дэмжих, усалгаатай тариалангийн талбайн хэмжээг нэмэгдүүлэх, усалгааны дэвшилтэт техник технологийг нэвтрүүлж, нутагшуулах, борлуулалт, агуулахын дэмжлэг үзүүлэх замаар хүнсний ногооны нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэн ногоочид, тариаланчдын чадавхи, орлогыг нэмэгдүүлэх, хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулах зорилготой юм.

Төслийн хүрээнд нийт 8,000 га газар бүхий сонгогдсон 12 хэсэгт усалгааны системийг дагалдах дэд бүтцийн хамт шинэчлэн сайжруулж, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй болгох юм. Төслөөс нийт 3,458 өрх ашиг шим хүртэх бөгөөд тэдгээрийн 1,041 нь орлого багатай өрх байх юм. Төслийг 2020-2027 он хүртэл хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Төслийн нийт төсөв нь 46.25 сая ам.доллар бөгөөд АХБ-аас үүний 25.3 сая ам.долларыг хөнгөлөлттэй нөхцөлтэй зээлээр, 14.7 сая ам.долларыг энгийн нөхцөлтэй зээлээр тус тус санхүүжүүлэх юм. Мөн Монгол улсын Засгийн газраас төслийн зардалд 4.25 сая ам.долларын санхүүжилт гаргах бөгөөд үлдсэн 2 сая ам.долларыг Ядуурлыг бууруулах Японы сан (ЯБЯС)-

ийн буцалтгүй тусламжаар санхүүжүүлнэ.

Төслийн хүрээнд дараах томоохон ажлуудыг хийж гүйцэтгэхээр төлөвлөж байна. Үүнд:

1. Төрийн болон орон нутгийн өмчийн 12 услалтын системийг шинээр барих (2) болон сэргээн засварлана (10). Усалгааны системийн усны эх үүсвэрийг Завхан, Ховд, Бодонч, Буянт, Идэр, Чигэстэй, Ивэн, Сөгнөгөр болон Хэрлэн голууд болон Сэлэнгэ мөрөнгөөс авах ба усалгааг дуслын болон бороожуулах технологийг ашиглан гүйцэтгэнэ. Шинэчлэн сайжруулсан усалгаатай талбайг тойруулан хамгаалалтын ойн зурвас байгуулахаас гадна сумын төвүүдэд хүнсний жижиг агуулах байгуулах болно. Энэхүү бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд Говь-Алтай аймгийн Цахир сум, Халиун сум, Ховд аймгийн Эрдэнэбүрэн сум, Алтай сум, Баян-Өлгийн аймгийн Баяннуур сум, Сагсай сум, Завхан аймгийн Тэлмэн сум, Улиастай сум, Сэлэнгэ аймгийн Сант сум, Зүүнбүрэн сум, Төв аймгийн Батсүмбэр сум, Хэнтий аймгийн Хэрлэн сум тус тус хамрагдах болно. Эдгээр сумдыг сонгохдоо хүнсний ногооны үйлдвэрлэл, төрийн болон орон нутгийн өмчийн усалгааны систем байх, мөн жижиг болон өрхийн үйлдвэрлэлийг дэмжих зэрэг шалгуурыг авч үзсэн байна.
2. Хөдөө аж ахуйн шинжлэх ухааны ололтыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх төвөөр дамжуулан бүс нутгийн 4 (баруун, төв, зүүн, өмнөд бүсийн) судалгааны хүрээлэнг (i) температурын хяналттай ургуулах, бойжуулах тасалгаанууд, хадгалах сэрүүн өрөө, нар, салхины хаалт, хашаа, механикжуулалтын багц, үр цэвэрлэх болон савлах тоног төхөөрөмж, тариалангийн болон сургалтын тоноглол, тоног төхөөрөмж, байгууламжаар хангах; (ii) бага оврын усалгааны системийг сайжруулах (iii) нүүрстөрөгч бага, ургалтын хугацаа урт, хүнсний ногоо болон сайн чанарын үр тариалах хүлэмжийг барих; (iv) эдгээр хүрээлэнгүүдийн чадавхийг бэхжүүлэх арга хэмжээ авна.

Усалалтын системийг сайжруулж, үр үрсэлгээний аж ахуйг дэмжсэнээр төслийн хүрээнд дараах үр дүнд хүрэх болно. Үүнд:

- 12 услалтын системийг шинээр барих болон шинэчлэн сайжруулснаар 8.0 мянга хүртэлх га талбайг усжуулах нөхцөл бүрдэж, хүнсний ногооны тариалангийн гарц, бүтээж сайжирна.
- Гол, хуваарилах болон түр суваг, далд хоолой болон илүүдэл ус зайлуулах байгууламжийг шинэчлэн сайжруулж, 240 га талбайг услах усны хэмнэлттэй, үр ашигтай төвийн эргэлттэй бороожуулагч, дуслын усалгааны технологийг нутагшуулах боломжийг бүрдүүлнэ.
- Усалалтын системийн дэд бүтцийн засвар үйлчилгээ хийх чадавхийг орон нутагт бэхжүүлсэн байна.
- Барилгын ажлын үед нийт 240 ажлын байр бий болгож, ажлын байрны 40 хувь нь эмэгтэйчүүд, 10 хувь нь өрх толгойлсон эмэгтэйчүүд байна.
- Төсөлд хүнсний ногооны тариалалт эрхлэгч 1,400 өрх хамрагдах ба эдгээрийн 20 хувь нь ядуу өрх байхаар тооцоолж байна.
- 4,000 хүртэл сорьцонд шинжилгээ хийх чадавхи бий болж, агрохимийн аюултай үлдэгдэл бүхий хүнсний хэрэглээ буурч, хэрэглэгчдийн дотоодод үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнд итгэх итгэл нэмэгдэж, хүнсний баталгаат байдал сайжирна.
- Хүнсний ногооны үр үйлдвэрлэлийн чадавхи 0.65 тонн, төмсний үр үйлдвэрлэл 10 тоннд хүрнэ.
- Мэргэжлийн институци, удирдлагын чадавхи бэхжүүлсэн байх зэрэг үр гаргахаар төлөвлөж байна.



## 6. “Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах” төсөл

Энэхүү төслийн зорилго нь Хүнсний ногооны үрийн аж ахуйг бэхжүүлэх, хоршоологчдыг дэмжиж тариалангийн ажлыг механикжуулах, зоорь, өвөл зуны хүлэмжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх замаар хүнсний ногооны импорт, ажилгүйдэл, ядуурлыг тус тус бууруулах, дотоодын хүнсний ногооны хэрэгцээг хангах, өрхийн амьжиргааг сайжруулах зорилготой юм.

Энэхүү төслийг Азийн хөгжлийн банкнаас 5 сая ам.доллараар санхүүжүүлэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас 2018-2022 онд Увс аймгийн Улаангом, Төв аймгийн Борнуур, Дархан-Уул аймгийн Орхон, Сэлэнгэ аймгийн Ерөө суманд хэрэгжүүлж байна.

Төслийн үр дүнд Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх загвар бий болгох, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй, тогтвортой ногоон аж ахуй эрхлэх технологи туршлага нэвтрүүлэх, хүнсний ногооны аж ахуй эрхлэгчдийн амьжиргааг сайжруулна гэж үзэж байна.

## 7. Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн Нэмэлт санхүүжилт төсөл

АХБ 2008 оны 9 дүгээр сарын 29-нд Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийг (төслийн эхний шат) санхүүжүүлэхээр Азийн Хөгжлийн Сангийн (АХС) эх үүсвэрээс 14.72 сая ам.долларын буцалтгүй тусламж олгохоор шийдвэрлэн баталсан. Шинэчилсэн хуваарийн дагуу төслийн эхний шат 2015 оны 12 дугаар сарын 31-нд дуусгавар болсон байна. Тус төслийн хүрээнд Хөдөө аж ахуйн маркетинг, брэнд хөгжүүлэхэд Японы Тусгай сан 2 сая ам.долларын Техник туслалцаа үзүүлсэн. Уг төсөл нь сонгон шалгаруулж авсан аж ахуйн нэгжүүдийг зорилтот зах зээлд дээд зэргийн үнэ цэнэ бүхий бүтээгдэхүүнийг найдвартай нийлүүлэхийг дэмжих замаар хөдөө аж ахуй, хөдөөгийн эдийн засгийн өсөлтийг дэмжихийг зорьсон. Төслийн эхний шатны хүрээнд дараах 2 гол үр дүнг гаргахаар ажилласан байна. Үүнд: (i) бусдаас ялгарах, дээд зэргийн үнэ цэнэ бүхий бүтээгдэхүүнийг зорилтот зах зээлд хүргэх чадамжтай нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх болон (ii) хамтын брэндийг хөгжүүлэх, удирдах процесс болон институцийн бүтэц зохион байгуулалт, журам, стандартыг бий болгох үйл ажиллагаа болно.

Төслийн эхний шатны хэрэгжилтийг тодорхой шалгуурт үндэслэн хүрэх ёстой үр дүнд хүрч амжилттай хэрэгжсэн гэж дүгнэсний үндсэн дээр нэмэлт санхүүжилт олгохоор болсон байна.

Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн нэмэлт санхүүжилт 50 сая ам.долларыг Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөнөөс гаргахаар шийдэн, 2016 оноос эхлэн 2021 он хүртэл хэрэгжүүлж байна.

**Хүснэгт 28. Төслийн бүрэлдэхүүн хэсгүүдийн төлөвлөсөн санхүүжилтийн хуваарь<sup>3</sup> (үр дүнгээр)**

#	Үр дүн	Дүн (сая ам.доллар)	Эзлэх хувь
1	Үр дүн 1: Нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх зээл	42.0	84.0%
2	Үр дүн 2: Малчдын үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх	2.2	4.4%
3	Үр дүн 3: Компаниудын маркетинг, техникийн чадавхийг сайжруулах	1.2	2.4%
4	Үр дүн 4: Монголын бүтээгдэхүүний брэндийн хөгжүүлэлт	0.6	1.2%
5	Төслийн удирдлага	1.2	2.4%
6	Зээлийн хүү, шимтгэл	2.8	5.6%
	Нийт	50.0	100%

3 - Төслийн вэб хуудас: <http://www.ardp.mn/ardp/page/tusliin-sankhuuzhilt-ur-dungeer>



## Төслийн хэрэгжилтийн явц, үр дүн

### Үр дүн 1. Нэмүү өртгийн сүлжээ (НӨС)-ний хөрөнгө оруулалт

Нэмэлт санхүүжилтийн төслийн хүрээнд арилжааны 6 банк (ХААН, ХАС, ХХБ, Голомт, Үндэсний хөрөнгө оруулалтын болон Улаанбаатар хотын)-тай Дамжуулан зээлдүүлэх гэрээг байгуулснаар НӨС-г хөгжүүлэх зээл олгох ажлыг эхлүүлсэн.

НӨС-г хөгжүүлэх зээл олгох хүрээнд арилжааны банкууд, ЗБДС-ын ажилтнууд, ААН-үүд болон бусад сонирхогч талуудын төлөөлөлд шат дараалсан 68 удаагийн сургалтад давхардсан тоогоор нийтдээ 1,269 ААН, байгууллагын 3,336 ажилтан хамрагдсан. Үүнээс 2020 онд төсөлд оролцогч ААН-ийг чадавхжуулах дижитал маркетинг, компанийн засаглалын 2 удаагийн семинар, сургалтад 40 ААН-ийн 75 төлөөлөл хамрагдсан байна.

Арилжааны банкуудаас 2020 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар нийтдээ 106.8 тэрбум төгрөгийн өртөгтэй 45 зээл батлаж, 44 төслийн 106.2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг Дамжуулан зээлдүүлэх гэрээний дагуу хийсэн байна.

Төслийн эхний шат (2009-2015 он)-д үед олгосон дэд төслүүдийн зээлийн эргэн төлөлт бүрэн дуусч, эргэн төлөлтийн 23.1 тэрбум төгрөгийг Төрийн санд төвлөрүүлсэн байна.

### Үр дүн 2. Малчид, фермерүүдийн үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх

ХХААХҮЯ-тай хамтран хэрэгжүүлэх үйл ажиллагаанд арьс шир, ноос ноолуур, оёдол, мах, сүү, зөгий болон чацарганын дэд салбар хамаарах бөгөөд дэд салбар тус бүрийн сургалт, техник туслалцааны хэрэгцээг тодорхойлсон судалгаа хийсэн байна.

Мах, сүү, арьс шир, зөгий, чацарганы салбарын төсөлд оролцогч аж ахуйн нэгжүүд, түүхий эд бэлтгэн нийлүүлдэг малчид, малчдын хоршоод, бэлтгэн нийлүүлэгчдэд зориулж 2020 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар (өссөн дүнгээр) 94,679.01 ам.долларын 35 удаагийн сургалт зохион байгуулж нийт 1,356 малчид, анхан шатны боловсруулагчдыг хамруулсан байна.

“Түүхий эдэд тордолт хийх, түүхий эд бэлтгэлийн тогтолцоог боловсронгуй болгоход шаардагдах технологийн сургалт явуулах” гэрээт ажил хэрэгжүүлж дуусгасан байна. Уг ажлын хүрээнд 6 (Хэнтий, Сүхбаатар, Завхан, Хөвсгөл, Архангай, Баянхонгор) аймгийн 19 сум, нийслэлийн 2 (Налайх, Сонгинохайрхан-Эмээлт) дүүргийн 850 малчид, хоршоологчид, түүхий эд бэлтгэгчид, орон нутгийн мал эмнэлэг, ХХААГ-ын ажилтнууд, малын эмч нарыг 2 шатны 6 модультай 336 цагийн сургалтад хамруулсан байна.

Мах, махан бүтээгдэхүүн, түүний үйлдвэрлэл, худалдааны аюулгүй байдлыг хангах, хүн, мал, амьтны эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, нийтийн ашиг сонирхолыг хамгаалах зорилготой 10 бүлэг, 45 зүйл, 623 заалт, 6 хавсралттай махны салбарын техникийн зохицуулалтын гарын авлагыг боловсруулж, хэвлүүлсэн.

“Зөгийн бэлчээрийн менежментийг сайжруулах”, “Зөгийн бүлийг ургамлын тоос хүртээлтэд ашиглах”, “Зөгийн аж ахуйн эдийн засгийн өгөөжийг нэмэгдүүлэх” судалгааны ажлуудыг хийлгэж гүйцэтгэсэн байна.

“Чацаргана болон бусад жимс жимсгэнийн ургамлын генефонд байгуулах” ажлыг гэрээлэн хийлгэж дуусгасан байна. Энэ ажлын дүнд монгол орны байгалийн чацаргана бүхий 6 аймгийн 10 гаруй сумын чацарганын нутгийн хэлбэрүүдээс шилж, цаашид селекцид ашиглах боломжтой 20 гаруй дээж хэлбэрүүдийг ногоон мөчрөөр үржүүлэн нийт 20 мянга гаруй суулгац бэлтгэжээ.

Бэлчээрт уст цэг тогтоох газар доорх усны геофизикийн хайгуулын ажлын гэрээг байгуулж, 102.1 сая төгрөгийн 4 аймгийн (Баянхонгор, Дорнод, Өмнөговь, Дорноговь) 82 бэлчээрт усны хайгуулын ажил хийгдсэн.

12 аймагт 61 худаг гаргах 1.6 тэрбум төгрөгийн 11 гэрээ байгуулан ажиллаж байна. 2020 оны 12-р сарын 31-ний байдлаар 1.1 тэрбум төгрөгийн гэрээт ажлыг санхүүжүүлсэн. Архангай, Баянхонгор, Завхан, Сүхбаатар, Ховд болон Хэнтий аймгуудад нийтдээ 45 худаг гаргах ажил бүрэн дууссан, бусад аймгуудад 16 худгийн ажил үргэлжилж байна.

2020 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар 906.3 сая төгрөгийн өртөгтэй арьс шир халимлах машин, сүүний чиглэлийн хоршоодод сүү боловсруулах иж бүрдэл, ноосны хоршоог чадавхижуулах багаж, хэрэгсэл болон зөгийн салбарын хоршоодод зөгийн гэр, сэмж нийлүүлээд байна.

Малчид, фермерийн аж ахуйг дэмжих зорилгоор нийтдээ 1.2 тэрбум төгрөгийн цахилгаан хөдөлгөөнт саалтуур, сүүний хөргөлтийн танк, лактоскан (сүү шинжлэгч багаж) болон барометр худалдан авах нээлттэй тендер шалгаруулалт зарлаж, 2020 оны 10-р сарын 14-ний өдөр нээж, тендерийн үнэлгээ хийгдэж байна.

### **Үр дүн 3. Аж ахуйн нэгжүүдийн маркетинг, техникийн хүчин чадал, чадамжийг сайжруулах**

Салбарын эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдийн лабораторийн хүчин чадал, чадамжийг сайжруулах хүрээнд нийлүүлэгдэх 63 нэр төрлийн тоног төхөөрөмж, лабораторийн багаж хэрэгсэл, эм урвалжийн техникийн тодорхойлолтыг боловсруулсан байна.

Төсөлд оролцогч ААН-ийн мэргэжлийн чадавхийг нэмэгдүүлэх, шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэх талаар 2020 оны 12-р сарын 31-ний байдлаар (өссөн дүнгээр) 70,459.16 ам.долларын 39 сургалт зохион байгуулагдаж 1,270 хүн оролцсон байна. Эдгээр сургалт ААН-ийн сүлжмэлийн зохион бүтээлт, сүлжих автомашинуудын техник, технологийн мэргэжлийн чадавхийг дээшлүүлэх, хүүхдийн гутлын масс үйлдвэрлэлийн ажлын байрны сургалт, мах махан бүтээгдэхүүний мал эмнэлэг ариун цэврийн нөхцөл, нэхмэлийн техникийн гарын авлага ба мэргэжилтний ур чаварыг дээшлүүлэх, мах махан бүтээгдэхүүний гадаад, дотоод худалдаан дахь эрүүл ахуй, ариун цэвэр, аюулгүй байдал, чанарын шаардлагууд зэрэг сэдвээр зохион байгуулагджээ.

“Сүү, сүүн бүтээгдэхүүний стандарт, техникийн баримт бичгийг боловсронгуй болгох”, “Олон улсын стандартуудын сургалт (чацаргана)”, “Чацарганы кластерийн хамтын ажиллагааны тогтолцоо бүрдүүлэх нэгдсэн өртгийн сүлжээ үүсгэх судалгаа”, “Бэлчээрийн монгол малын сүүний хими, биохимийн найрлагыг тогтоох, түүгээр зохицуулах үйлчилгээтэй хүнс үйлдвэрлэх туршилт, судалгаа”, “Зөгийн уурагт тэжээлийн технологи боловсруулах үйлдвэрлэлд нэвтрүүлэх”, “Зөгийн хачигтах өвчний үед хэрэглэх шинэ эмүүдийн технологи боловсруулах, үйлдвэрлэлд нэвтрүүлэх”, “Зөгийн гэр болон зөгийн аж ахуйн нэр томъёоны стандартуудыг шинээр боловсруулж батлуулах, үйлдвэрлэлд нэвтрүүлэх”, “Монгол зөгийн балны биологийн онцлог, антиоксидант чанарыг тогтоох” судалгааны ажлууд хийлгэсэн байна.

“Нэхмэлийн салбарын “Монголын сүлжмэлийн үйлдвэрүүдийн гүйцэтгэн боловсруулалт”, “Ноосон нэхмэлийн гүйцэтгэн боловсруулалтын технологи”, “Чанарын баталгаажилт ба хяналт”, “Ноос ноолуурыг будах техник, технологи” нийт 281 хуудас 4 гарын авлагыг англи хэлнээс монгол хэл рүү орчуулж, хөрвүүлэх ажил хэрэгжиж дууссан.

“Компанийн нийгмийн хариуцлага, ёс зүй” дадлагажуулах сургалтын гэрээт ажил, “Монгол зөгийн балыг сурталчилахад зориулсан цахим ном, видео контент бэлтгэх” ажил,



«Шувуу үргээх төхөөрөмжийн ажиллагаа техникийн туршилт хийж ашиглалтын үр ашгийг тооцоолох үйлдвэрлэлд нэвтрүүлэх», «Монголын хаан ширхэгтийн бүтээгдэхүүн хөгжүүлэх загвар туршилтын түүхий эдийн чанарыг шинжилж, үнэлэн анхдагч өгөгдлүүдийг бүрдүүлэх», «Бэлчээрийн монгол малын мах, махан бүтээгдэхүүн нь зохицуулах үйлчилгээтэй хүнс болохыг баталгаажуулах судалгаа», «Чацаргана, түүний гаралтай бүтээгдэхүүний тэжээллэг ба эмчилгээний шинж чанарыг тогтоох судалгаа» зэрэг томоохон туршилт, судалгааны ажлууд хэрэгжиж байна.

2020 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар 3.0 тэрбум төгрөгийн өртөгтэй арьс шир, ноос ноолуур, оёдол, зөгий, чацарганы салбарын лабораторийн тоног төхөөрөмж болон мах, сүүний чиглэлийн шилмэл үүлдэрийн гүн хөлдөөсөн үр, хөврөл нийлүүлээд байна.

#### **Үр дүн 4. Монголын бүтээгдэхүүний брэнд хөгжүүлэлт**

Монголын бүтээгдэхүүний брэнд хөгжүүлэх үйл ажиллагааны талаар 2020 оны 12-р сарын 31-ний байдлаар (өссөн дүнгээр) 17,372.43 ам.долларын өртөг бүхий 12 удаагийн сургалт зохион байгуулж нийт 351 хүн эдгээр сургалтанд хамрагдаад байна. Эдгээр сургалт нь дотор махны зохистой хэрэглээ, бүтээгдэхүүний суулт тохироо, экспортын чанарын шаардлага хангасан зөгийн бал үйлдвэрлэх, удирдлагын тогтолцооны дотоод аудитор (ISO19011) бэлтгэх, зөгийчдийн ур чадварыг дээшлүүлэх, «Монголын Хаан Ширхэгт» гэрчлэх тэмдэгт стандартын эхний төслийн танилцуулж, олон улсын хэрэглэгчийн шаардлагад нийцсэн бүтээгдэхүүний чанарын үзүүлэлтүүдийг тогтоох зэрэг сэдвээр зохион байгуулагдаад байна.

«Чацарганы бүтээгдэхүүний гадаад зах зээлийн судалгаа», «Ноосон даавуун хүрэм үйлдвэрлэх», «Монголын хаан ширхэгт гэрчлэх тэмдэгт бүтээгдэхүүний үйл явц болон үйлчилгээний баталгаажуулалтын байгууллагад тавигдах техникийн баримт бичиг боловсруулж, хүний нөөцийг чадавхжуулах», «Бэлчээрийн монгол малын сүүний хими, биохимийн найрлагыг тогтоох, түүгээр зохицуулах үйлчилгээтэй хүнс үйлдвэрлэх туршлага, судалгаа», «Монголын хаан ширхэгт тэмдэгт сүлжмэл, нэхмэл бүтээгдэхүүний чанарын стандартуудыг боловсруулж, батлуулах», «Монголын Хаан ширхэгт гэрчлэх тэмдэгт бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн дотоод хяналтын сорилтын лабораторийн итгэмжлэлийн үйл ажиллагаанд шаардагдах техникийн баримт бичиг боловсруулж, хүний нөөцийг чадавхжуулах», «Арьс ширний салбарын төсөлд оролцогч аж ахуйн нэгжүүдэд үйлдвэрлэлийн зөв тогтолцоо бүрдүүлэх, олон улсын стандартыг нэвтрүүлэх», «Арьс ширэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүдэд олон улсын чанарын менежментийн тогтолцооны ISO9001:2015 стандартын баталгаажуулалтын аудит хийлгэх», «Сурагчийн дүрэмт хувцас үндэсний стандартыг нийтэд танилцуулах контент бэлтгэх сурталчлах», «Махны техникийн зохицуулалтын лавлагаа баримт бичгүүдийг англи хэлнээс монгол хэл рүү орчуулах», «Зөгийн аж ахуйд хөдөө аж ахуйн зохистой дадал нэвтрүүлэх стандарт, үнэлгээний хуудас боловсруулах баталгаажуулах», «Зөгийн аж ахуйн технологий, менежмент сургалтын цуврал видео хичээл хийх», «Зөгийн аж ахуйн зөвлөх/сургагч багш нарт зориулсан удирдлагын тогтолцооны дотоод аудитор (ISO19011) бэлтгэх», «Брэнд болон экспортын чанарын шаардлага хангасан зөгийн бал үйлдвэрлэх загвар бий болгох хүрээнд бэлтгэн нийлүүлэгчдийг чадавхижуулах», «Зөгийн аж ахуйд мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм боловсруулах баталгаажуулах», «Зөгийг ургамлын тоос хүртээлтэд ашиглах эдийн засгийн өгөөжийг тооцох аргачлал, зөгийн болон балт ургамлын тариалангийн хосолсон болон дагнасан аж ахуй хөгжүүлэх боломж судалгаа» зэрэг гэрээт туршилт, судалгааны гэрээт ажлууд хийгдэж дууссан.

«Монгол зөгийн балыг Европын холбооны орнуудад экспортлох боломжид судалгаа хийж дэмжлэг үзүүлэх», «Үйлдвэрлэлийн дотоод хяналтын лабораторийн шинжээч бэлтгэх сургалт», «Монгол орны байгалийн чацарганы олон янз байдал тэдгээрийн генетикийн

онцлог шинжүүдийг уламжлалт болон орчин үеийн молекул генетикийн судалгааны аргаар харьцуулан судлах”, “Монголын хаанширхэгт тохиролын тэмдэг бүхий бүтээгдэхүүний чанарын хяналт, баталгаажилт-шаталсан сургалт”, “Оёмол бүтээгдэхүүн, хувцас үйлдвэрлэлийн салбарын үндэсний мэдээллийн сан бүрдүүлэх, үйлдвэрлэл төрөлжүүлэх судалгаа” зэрэг гэрээт ажил хийгдэж байна.

### ЖДҮ-ийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах 2 үе шаттай зээлийн төсөл

Энэхүү төслийг анх Монгол улсын Засгийн газар, Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Банк (ЯОУХАБ)-ны хооронд 2006 оны 6-р сарын 28-нд Зээлийн хэлэлцээр байгуулсанаар эхлүүлсэн. Төслийн зорилго нь ЖДҮ-ийг урт хугацааны, хүү багатай зээлээр дэмжих, байгаль орчныг хамгаалахад чиглэсэн зээлийн дэмжлэг үзүүлэх, энэ чиглэлээр зөвлөх үйлчилгээ үзүүлэхэд чиглэгдэж ирсэн байна. Төслийн хүрээнд ЖДҮ-ийг дэмжих зээлийг оролцогч Арилжааны банкуудаар дамжуулан зээлдүүлж, эх үүсвэрийг 2 үе шаттайгаар ЯОУХАБ-наас санхүүжүүлж ирсэн. Эхний үе шатанд 2006-2009 онд ойролцоогоор 27.4 сая ам.доллартай тэнцэх хөнгөлөлттэй зээлийн санхүүжилт олгосон бол 2-р үе шатанд 2011-2016 онд ойролцоогоор 65.9 сая ам.доллартай тэнцэх хэмжээний хөнгөлөлттэй зээлийн санхүүжилт хийсэн байна. Мөн дамжуулан зээлийн эргэн төлөлтөөс Эргэлтийн сан бүрдүүлж, үүнийг ЖДҮ-ийн зээлийн эх үүсвэр болгож дахин дамжуулан зээл олгож ирсэн байна.

Төслийн үйл ажиллагааг анх эхэлсэн цагаас нь Төсөл хэрэгжүүлэх нэгж байгуулан хариуцан хэрэгжүүлж ирсэн бөгөөд 2006-2017 он хүртэл Төслийн нэгжийг ЖАЙКА-аас санхүүжүүлж байсан бол 2017 оноос СЯ, 2019 оноос ХХААХҮЯ-ны дэргэд үйл ажиллагаагаа явуулж иржээ.

### 3.2.6 Зээл тусламжийн эх үүсвэр, төлөвлөсөн санхүүжилт

ХХААХҮ-ийн салбарт хэрэгжүүлж буй зээл, тусламжийн төслүүдийн эх үүсвэр, санхүүжилтийн төлөвлөсөн хэмжээг доорх хүснэгтээр үзүүлэв.

**Хүснэгт 29.** ХХААХҮ-ийн салбарт 2022 онд хэрэгжүүлэх гадаадын зээл, тусламжийн төсөл, хөтөлбөрүүдийн мэдээлэл /урьдчилсан мэдээлэл/

#	Төслийн нэр	Хандивлагч улс, ОУ-ын байгууллага	Хэрэгжих хугацаа	Валют	Нийт зээл, тусламжийн хэмжээ / мянгачилсан үндсэн валют /	2022 онд ашиглах Зээл, тусламжийн ашиглалт / мянгачилсан үндсэн валют /
1	Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон мал аж ахуйн хөгжил төсөл	АХБ	2021-2026	Ам.доллар	50,000.0	2,010.0
2	Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн 2 дугаар үе шат төсөл	АХБ	2022-2027	Ам.доллар	57,000.0	3,191.8
3	Хорио цээрийн байгууламж бүхий махны үйлдвэр байгуулах	БНХАУ	2021-2023	Ам.доллар	78,000.0	3,900.0
4	Хятад-Монголын хүнсний ногооны шинжлэх ухаан, технологийн үзэсгэлэн парк (Өвлийн хүлэмж байгуулах төсөл)	БНХАУ	2022-2022	Юан	100,000.0	5,000.0

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН  
ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ШИНЖИЛГЭЭ**


5	Мах, сүүний чиглэлийн үхэр, газар тариалангийн техник тоног төхөөрөмж авах	Беларус	2020-2022	Евро	30,000.0	4,500.0
---	--	---------	-----------	------	----------	---------

**3.3 Төсвийн зарлагын гүйцэтгэл**

Төсвийн зарлагын гүйцэтгэлийг хэмжихдээ тухайн жилд төлөвлөсөн буюу батлагдсан төсвийн зардал ба түүний бодит гүйцэтгэлийг харьцуулж авч үздэг. Төсвийн зарлагын гүйцэтгэл нь 10 хувиас хэтрэхгүй хэлбэлзэлтэй байвал олон улсын стандартаар<sup>4</sup> хэвийн гэж үздэг.

ХХААХҮ-ийн салбарын төсвийн зарлагын гүйцэтгэлийг сүүлийн 10 жилээр доорх зургаар үзүүлээ.

**Зураг 43. ХХААХҮ-ийн салбарын төсвийн нийт зарлагын гүйцэтгэл, хувиар**



Эх үүсвэр: ХХААХҮЯ

Зураг 43-аас харахад ХХААХҮ-ийн салбарын төсвийн нийт зарлагын гүйцэтгэл төлөвлөгөөтэй нь харьцуулахад сүүлийн 10 жилийн дунджаар 86 хувьтай буюу олон улсын стандартаар хэвийн хэмжээнээс 4 нэгжээр доогуур байна. Зарлагын бүтцээр нь авч үзвэл сүүлийн 10 жилийн дунджаар урсгал зардлын гүйцэтгэл 91 хувьтай, хөрөнгийн зарлагын гүйцэтгэл 80.0 хувьтай байна. Хөрөнгийн зардлын гүйцэтгэл доогуур хувьтай байгаа нь тухайн жилийн төсвийн орлого тасрах, худалдан авах ажиллагаа удаашрах зэрэгтэй холбоотой. Урсгал зардал дотроос бараа, үйлчилгээний зардал хамгийн өндөр гүйцэтгэлтэй

<sup>4</sup> -World Bank, Practitioners' Toolkit for Agriculture Public Expenditure Analysis



буюу дунджаар 97.0 хувийн гүйцэтгэлтэй байна.

ХХААХҮ-ийн салбарын хувьд эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлийн гүйцэтгэл нь төлөвлөснөөс ихээхэн хэлбэлзэлтэй явж ирсэн байна. Үүнийг доорх хүснэгтээр үзүүлэв.

**Хүснэгт 30. Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлийн төлөвлөгөө ба гүйцэтгэл**

Он	Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл /тэрбум төгрөгөөр/		
	төл.	гүй.	зөрүү
2010	40.7	43.5	2.9
2011	363.5	362.1	(1.4)
2012	(30.8)	25.0	55.8
2013	(27.4)	30.4	57.7
2014	(21.3)	(16.9)	4.4
2015	(20.4)	(37.3)	(17.0)
2016	(15.7)	5.7	21.4
2017	62.1	124.0	61.9
2018	(10.9)	42.3	53.2
2019	(71.8)	5.3	77.1
2020	2.8	18.9	16.1
дундаж	24.6	54.8	30.2

Эх үүсвэр: ХХААХҮЯ

ХХААХҮ-ийн салбарт улсын төсвөөс ЖДҮ-ийг дэмжих, газар тариалангийн бүтээгдэхүүн, хүнсний хангамжийг нэмэгдүүлэхэд зориулж хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийг жил бүр олгож байна.

Төсвийн зардлын эдийн засгийн ангилалаар эргэж төлөгдөх зээлийн эх үүсвэрийн зардлаас өмнө олгосон зээлийн эргэн төлөлтийг хасаж тооцсон зардлыг эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл гэсэн зүйлээр төсөвт тусгадаг.

Дээрх Хүснэгт 30-ээс харахад 2010 оноос хойш эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлийн гүйцэтгэл төлөвлөгөөтэй нь харьцуулахад ихээхэн зөрүүтэй явж ирсэн байна. Энэ нь тухайн салбарт олгосон төсвийн эх үүсвэрээрх зээлийн эргэж төлөгдөх төлбөр хугацаандаа төлөгдөхгүй он дамжих, хангалалтгүй төлөгдөж ирсэнтэй холбоотой. Эдгээрийн дийлэнхийг ЖДҮ-ийг хөгжүүлэх сан болон Хөдөө аж ахуйг дэмжих сангийн авлагууд эзэлж байна.

### 3.4 ХХААХҮ-ийн сайдын хэрэгжүүлэх хөтөлбөрүүдийн үр дүнгийн үзүүлэлтийн гүйцэтгэл

Төсвийн тухай хууль болон Сангийн сайдын батласан Төсвийн зарлагын хөтөлбөрийн ангилалын дагуу ХХААХҮ-ийн сайдын хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүд (Хүснэгт 31)-ийг жил бүрийн Төсвийн хуулиар батлан хэрэгжүүлж байна.

ХХААХҮ-ийн сайдын эрхлэх асуудал, яамны чиг үүрэг болон Төсвийн зарлагын хөтөлбөрийн ангиллаар нийт 6 хөтөлбөр хэрэгжүүлж байгаа бөгөөд 2020 оны байдлаар тэдгээрийн нийт 12 үр дүнгийн үзүүлэлтийг Төсвийн хуулийн 1-р хавсралтаар батласан байна. Эдгээр үр дүнгийн үзүүлэлтүүдийг харахад тухайн хөтөлбөрийн нийгэм, эдийн засаг, байгаль орчин, иргэд, зорилт бүлэгт нөлөөлөх жинхэнэ үр дүнгийн үзүүлэлт бус ихэвчлэн тухайн хөтөлбөр, арга хэмжээний гарц буюу бүтээгдэхүүн, үйлчилгээний тоо хэмжээг оруулсан харагдаж байна (Хүснэгт 31).

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН  
ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ШИНЖИЛГЭЭ**

Хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтийн биелэлтийг тус яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газарт нэгтгэж, дүгнэдэг бөгөөд цаашид үүнд бодлогын газрууд, хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан газар, хэлтсийн оролцоог хангах ажиллах нь зүйтэй.

**Хүснэгт 31. ХХААХҮ-ийн сайдын хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийн биелэлт**

Төсвийн эрх захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт	Зорилтот түвшин, түүний гүйцэтгэл							
	2017		2018		2019		2020	
	Төл.	Гүй.	Төл.	Гүй.	Төл.	Гүй.	Төл.	Гүй.
<b>Мал аж ахуйг хөгжүүлэх</b>								
1. Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээ /сая толгой, давхардсан тоогоор/	48.4	68.9	56	66.8	65.2	68.5	82.6	71.26
2. Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх /өссөн хувиар/	20	20	25	25	20	21.6	3	3.1
3. Бэлчээрийн ургамал хамгаалал /мянган га/	750	622.8	750	820	720	1300	1390	1600
4. Үндэсний үйлдвэрлэлд нийлүүлэх ноос /мянган тонн/	22.2	20.2	-		22	16.6	-	
5. Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх (Сүүний үхэр) /мян.толгой мал/					-		2318	2025
<b>Газар тариаланг хөгжүүлэх</b>								
1. Буудайн үйлдвэрлэлийг дэмжих /мянган тонн/	420	292.4	460	436.1	460	411.4	440	406.1
2. Төмс, хүнсний ногоо /мянган тонн/	270	197	269.5	269.6	280	291.8	270	365.5
3. Уриншилсан талбайн хэмжээ /мянган га/			390	360	-		-	
4. Стандартын шаардлага хангасан жимс, жимсгэнэ тариалсан талбай /га/			7000	3536.3	-		-	
<b>Хүнсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх</b>								
1. Хүн амын сүүний хэрэглээг үйлдвэрлэлийн аргаар боловсруулсан сүүний хангамжаар хангах /сая литр/	55	81.2	55	70.2	90	168.3	150	176.2
2. Үйлдвэрлэлийн аргаар боловсруулсан махны хэрэглээг нэмэгдүүлэх /мянган тонн/	10	25.5	15	45.6	14	31.9	20	25.8
<b>Хөдөө аж ахуй, газар тариалангийн бодлого, удирдлага</b>								
1. Улсын Их Хурал, Засгийн газраас баталсан шийдвэр, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх /тоогоор/	3	3	5	5	3	3	5	5
<b>Хөдөө аж ахуй, газар тариалан, аж үйлдвэрийн судалгаа шинжилгээ</b>								
1. Салбарын хэмжээнд хэрэгжүүлж дууссан нийгэм, эдийн засгийн чухал ач холбогдолтой, импортыг орлох, экспортыг дэмжих төслийн үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх	2	2	-		2	2	2	2
<b>Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих, хөгжүүлэх, ажлын байр олгох</b>								
1. Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төслийн тоо	150-170	154	100	211	150-200	451	200-250	249
2. Зээлийн батлан даалтын сангийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх /зээлдэгчийн тоо/	100-150	441	100-150	146	100-150	111	100-150	65

Эх үүсвэр: ХХААХҮЯ

ХХААХҮ-ийн сайдын хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийн биелэлтийн хувийг доорх хүснэгтээр харууллаа.

Хүснэгт 32-аас тооцож үзэхэд 2017-2020 онд хэрэгжүүлсэн хөтөлбөрүүдийн үр дүнгийн үзүүлэлтийн гүйцэтгэл дунджаар 115 хувийн биелэлттэй гарсан байх бөгөөд мал аж ахуйг хөгжүүлэх, газар тариаланг хөгжүүлэх хөтөлбөрийн зарим үзүүлэлтүүд 50.5-87.4 хувийн буюу харьцангуй доогуур биелэлттэй гарсан байна.

**Хүснэгт 32. Төсвийн эрх захирагчийн хэрэгжүүлсэн хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтийн биелэлт**

	Гүйцэтгэлийн хувь (Гүй./Төл.)					Стандарт хазайлт
	2017	2018	2019	2020	дундаж хувь	
<b>Мал аж ахуйг хөгжүүлэх</b>						
1. Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээ /сая толгой, давхардсан тоогоор/	142.4%	119%	105%	86%	113.2%	0.20
2. Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх /өссөн хувиар/	100.0%	100%	108%	103%	102.8%	0.03
3. Бэлчээрийн ургамал хамгаалал /мянган га/	83.0%	109%	181%	115%	122.0%	0.36
4. Үндэсний үйлдвэрлэлд нийлүүлэх ноос /мянган тонн/	91.0%		75%		83.2%	0.08
5. Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх (Сүүний үхэр) /мян.толгой мал/				87%	87.4%	0.00
<b>Газар тариаланг хөгжүүлэх</b>						
1. Буудайн үйлдвэрлэлийг дэмжих /мянган тонн/	69.6%	95%	89%	92%	86.5%	0.10
2. Төмс, хүнсний ногоо /мянган тонн/	73.0%	100%	104%	135%	103.1%	0.22
3. Уриншилсан талбайн хэмжээ /мянган га/		92%			92.3%	0.00
4. Стандартын шаардлага хангасан жимс, жимсгэнэ тариалсан талбай /га/		51%			50.5%	0.00
<b>Хүнсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх</b>						
1. Хүн амын сүүний хэрэглээг үйлдвэрлэлийн аргаар боловсруулсан сүүний хангамжаар хангах /сая литр/	147.6%	128%	187%	117%	144.9%	0.27
2. Үйлдвэрлэлийн аргаар боловсруулсан махны хэрэглээг нэмэгдүүлэх /мянган тонн/	255.0%	304%	228%	129%	229.0%	0.64
<b>Хөдөө аж ахуй, газар тариалангийн бодлого, удирдлага</b>						
1. Улсын Их Хурал, Засгийн газраас баталсан шийдвэр, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх /тоогоор/	100.0%	100%	100%	100%	100.0%	0.00
<b>Хөдөө аж ахуй, газар тариалан, аж үйлдвэрийн судалгаа шинжилгээ</b>						
1. Салбарын хэмжээнд хэрэгжүүлж дууссан нийгэм, эдийн засгийн чухал ач холбогдолтой, импортыг орлох, экспортыг дэмжих төслийн үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх	100.0%		100%	100%	100.0%	0.00
<b>Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих, хөгжүүлэх, ажлын байр олгох</b>						
1. Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төслийн тоо	96%	211%	258%	111%	168.9%	0.68
2. Зээлийн батлан даалтын сангийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх /зээлдэгчийн тоо/	353%	117%	89%	52%	152.6%	1.18

Эх үүсвэр: ХХААХҮЯ



### 3.5 Салбарын төсвийн үр ашгийн шинжилгээ

#### Хөдөө аж ахуйн салбарын төсвийн зарлага ба бүтээмжийн хамаарал

Бүтээмж нь улс оронд бий болсон үйлдвэрлэл, үйлчилгээний үр ашгийг илэрхийлэх нэг үзүүлэлт болно. Манай улсын хувьд ҮСХ-оос нэг ажилтанд ногдох ДНБ буюу хөдөлмөрийн бүтээмжийг жил бүр улсын хэмжээнд салбараар тооцон гаргаж байна. Хөдөлмөрийн бүтээмж нь нэгж хөдөлмөрийн орцод ногдох гарц буюу ДНБ-ий хэмжээг илэрхийлнэ. Бүтээмжийн тооцооны гарцыг улсын түвшинд ДНБ, салбарын түвшинд нэмэгдэл өртөгөөр тооцож байна. Нэг ажиллагчид ногдох нэмэгдэл өртгийг (ДНБ) тооцоходоо нэмэгдэл өртгийн хэмжээг тухайн салбарын ажиллагчдын жилийн дундаж тоонд хуваана.

Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын салбарын хөдөлмөрийн бүтээмжийг оны болон зэрэгцүүлэх үнээр, түүний бодит өсөлтийг доорх хүснэгтээр харууллаа. Мөн салбарын 1 ажиллагчид ногдох төсвийн зарлагын хэмжээг харьцуулж үзүүлээ.

**Хүснэгт 33.** ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын салбарын хөдөлмөрийн бүтээмж, 1 ажиллагчид ногдох төсвийн зарлага, мян.төгрөгөөр

	2015	2016	2017	2018	2019	2020
1 ажиллагчид ногдох төсвийн зарлага	302.5	301.6	557.0	374.5	534.4	579.0
Хөдөлмөрийн бүтээмж, оны үнээр	9840.6	8671.8	8752.6	11145.0	15073.1	17541.4
Хөдөлмөрийн бүтээмж, 2015 оны зэрэгцүүлэх үнээр	9840.6	9749.2	9504.3	10799.2	13087.4	14534.1
Хөдөлмөрийн бүтээмжийн бодит өсөлт		-0.9	-2.5	13.6	21.2	11.1

Эх үүсвэр: ҮСХ, ХХААХҮЯ

Дээрх хүснэгтээс харахад тус салбарын хөдөлмөрийн бүтээмж 2016, 2017 онуудад буурч байсан бол 2018 онд 13.6 хувь, 2019 онд 21.2 хувь, 2020 онд 11.1 хувиар тус тус өссөн байна.

ХАА-ын салбарын төсвийн зарлага болон хөдөлмөрийн бүтээмжийн хамаарлыг тооцохын тулд салбарын 1 ажиллагчид ногдох төсвийн зарлагын хэмжээ болон оны үнээрх хөдөлмөрийн бүтээмжийн хоорондох хамаарлын корреляцийн коэффициент, детерминацийн коэффициентийг тооцож үзэв /Зураг 44/.

**Зураг 44.** Салбарын 1 ажиллагчид ногдох төсвийн зарлага ба хөдөлмөрийн бүтээмжийн хамаарал



Эх үүсвэр: ҮСХ, ХХААХҮЯ




Корреляцийн коэффициент нь хувьсагчдын хоорондох шугаман хамаарлын хүчийг хэмждэг бөгөөд Корреляцийн коэффициент нь +1 рүү ойртох тусам (жишээлбэл 0.9) хүчтэй, эерэг, хоёр хүчин зүйлийн хооронд шууд шугаман хамааралтай буюу нэг хувьсагчийн утга өсөхөд нөгөө хувьсагч дунджаараа өсөхийг заана.

ХАА-н салбарын 1 ажиллагчид ногдох төсвийн зарлага ба хөдөлмөрийн бүтээмжийн хамаарлын корреляцийн коэффициент ( $R^2$ ) нь 0.629 байна. Энэ нь салбарын төсвийн зарлага болон хөдөлмөрийн бүтээмжийн хооронд тодорхой түвшний эерэг хамаарал байгааг харуулж байна. Мөн шугаман хамаарлыг детерминацийн коэффициентээр ( $r^2$ ) шинжилж үзье. Энэ коэффициент нь [0,1]-ийн хооронд утгыг авах бөгөөд регрессийн тэгшитгэлийн хамаарах хувьсагчийн хэдэн хувийг үл хамаарах хувьсагч тайлбарлаж байгааг илэрхийлнэ.  $r^2=1$  буюу 100% байвал х, у-ийн хооронд төгс шугаман хамаарлыг илтгэнэ.  $r^2=0$  буюу 0% бол шугаман хамааралгүй гэж үздэг. Дээрх Зургаас харахад детерминацийн коэффициент ( $r^2$ ) нь 0.396 байгаа нь шугаман хамаарал сул байгааг илтгэж байна.

### ХАА-н бүтээгдэхүүнд олгож буй урамшууллын үр нөлөө

ХХААХҮ-ийн салбарын төсвийн зарлагад томоохон хувийг эзэлдэг хөдөө аж ахуйн түүхий эдийн урамшуулал, татаасын эдийн засгийн үр нөлөөг хэмжих үүднээс урамшуулалд олгосон төсвийн зарлагын хэмжээ нь тухайн бүтээгдэхүүн болон түүгээр хийсэн боловсруулах салбарын бүтээгдэхүүний гарцад ямар нөлөө үзүүлж байгааг корреляци болон детерминацийн коэффициентээр тооцож гаргалаа.

**Зураг 45.** Улаан буудайн урамшууллын хэмжээ ба урамшуулал олгосон ургац, нийт хураасан ургац, урамшуулалд хамрагдсан иргэдийн тооны хамаарал



Эх үүсвэр: ХХААХҮЯ

Зураг 45-д үзүүлснээр улаан буудайн урамшууллын хэмжээ нь урамшуулалд хамрагдсан ААН, иргэдийн тоо болон урамшуулал олгосон ургацын хэмжээнд тодорхой эерэг хамааралтай байна. Харин нийт хураасан ургацын хэмжээтэй шугаман хамааралгүй болох нь корреляци болон детерминацийн коэффициентээр харагдаж байна.

Ноосны урамшуулал болон ноосоор хийсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хамаарлыг доорх хүснэгт, зургаар үзүүлэв.



Түүнчлэн 2011-2020 онд олгосон арьс, ширний урамшууллын хэмжээ болон бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хамаарлыг доор үзүүлэв.

Зураг 47. Арьс, ширний урамшууллын хэмжээ болон урамшууллаар бэлтгэсэн арьс, шир, урамшуулалд хамрагдсан малчдын тоо, үйлдвэрлэлийн хамаарал

	Детерминацийн коэффициент $r^2$	Корреляцийн коэффициент $R^2$
Урамшуулалд хамрагдсан малчдын тоо	0.320	0.566
Урамшууллаар бэлтгэсэн арьс шир	0.757	0.870
Үйлдвэрүүдийн боловсруулсан арьс ширний тоо	0.006	0.079
хагас боловсруулсан арьсны тоо	0.119	-0.344
гүн боловсруулсан арьсны тоо	0.106	0.326

Эх үүсвэр: ХХААХҮЯ, ҮСХ

Дээрх зургаас харахад арьс, ширний урамшууллын хэмжээ болон урамшуулалд хамрагдсан малчдын тоо, урамшууллаар бэлтгэсэн арьс, ширний хэмжээнд хүчтэй хамаарал ажиглагдаж байна. Харин арьс, ширний урамшууллын хэмжээ нь үйлдвэрт боловсруулсан арьс, ширний тоо хэмжээтэй төдийлөн хамааралгүй болох нь корреляци болон детерминацын коэффициентоос харагдаж байна. Өөрөөр хэлбэл арьс, ширний урамшуулал нь дотоодын арьс, ширэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээнд төдийлөн үр нөлөө үзүүлэхгүй байна гэж үзэж болно.

#### 4. Санал, дүгнэлт

1. Монгол улсын Засгийн газрын тухай хуулиар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр / ХХААХҮ/-ийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд дараах 14 чиг үүрэг хамаарч байна. Үүнд 1) хүн амын хүнсний хангамжийн бодлого; 2) хүнсний аюулгүй байдлын асуудал; 3) мал аж ахуйг эрчимжүүлэн хөгжүүлэх бодлого; 4) газар тариаланг эрчимжүүлэн хөгжүүлэх бодлого; 5) мал эмнэлэг, малын үржлийн талаар төрөөс явуулах бодлого; 6) мал, амьтан, ургамлын хорио, цээрийн асуудал; 7) бэлчээрийн болон таримал ургамлыг хамгаалах асуудал; 8) мал, таримал ургамлын гаралтай хүнсний зүйл, түүхий эд болон хөнгөн үйлдвэрийн бүтээгдэхүүний экспорт, импортын асуудал; 9) хөдөө аж ахуйн эдэлбэр газрын болон бэлчээр ашиглалтын бодлого; 10) малыг цаг агаарын гэнэтийн аюулаас хамгаалах бодлого; 11) хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх асуудал; 12) жижиг, дунд үйлдвэрийн хөгжлийн асуудал; 13) дотоод худалдаа, үйлчилгээний бодлого, зохицуулалт; 14) агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх асуудал зэрэг болно.
2. ХХААХҮ-ийн салбар нь 2020 оны байдлаар Монгол улсын ДНБ-ий 32.5 хувийг, нийт экспортын 5.6 хувийг, нийт ажиллагсадын 50 гаруй хувийг тус тус бүрдүүлж байна. Сүүлийн 10 жилийн хандлагаас харахад ХХААХҮ-ийн салбарын үйлдвэрлэлийн нийт эдийн засагт болон экспортод эзлэх хувь төдийлөн өөрчлөгдөөгүй байна.
3. ХХААХҮ-ийн салбар нь 1995 онд нийт ДНБ-ий 59.6 хувь, 2000 онд 44.5 хувийг бүрдүүлж байсан бол 2000 оноос аажмаар буурч сүүлийн 15 жилд ДНБ-ий 31-33 хувь буюу нийт эдийн засгийн гуравны нэгийг бүрдүүлж байна. Уул уурхай, олборлох үйлдвэрлэлийн салбарт 2000 оноос хойш гадаад, дотоодын хөрөнгө оруулалт мэдэгдэхүйц нэмэгдэж, Монгол улсын эдийн засагт чухал хувь нэмэр оруулах болсноор ДНБ-ий бүтэц өөрчлөгдөж ХХААХҮ-ийн салбарын эзлэх хувь буурсан байна.

4. ХХААХХ-ийн салбарт ажиллагсад нь Монгол улсын нийт ажиллагсадын талаас илүү хувийг бүрдүүлж байна. Салбарын нийт ажиллагсадын тоо 2019 оны эцэст 577.2 мянга байгаа ба энэ нь нийт ажиллагсадын 50.4 хувийг эзэлж байгаа бөгөөд сүүлийн 8 жилийн дунжийг авч үзвэл 54.2 хувьтай байна.
5. ХХААХҮ-ийн салбарын ДНБ-ий нийт дүнд Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын салбар хамгийн их хувьтай байгаа бөгөөд 2020 оны байдлаар 37.2 хувийг бүрдүүлж байна. Салбарын ДНБ-ий нийт дүнд боловсруулах салбарын эзлэх хувь 2000 оноос хойш аажмаар нэмэгдэх хандлагатай байгаа бөгөөд 2020 онд 32.7 хувийг эзэлж байна. Салбарын ДНБ-ний 30 орчим хувийг үйлчилгээний салбар болох бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ болон зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ эзэлж байна.
6. Сүүлийн 10 жилд ХХААХҮ-ийн сайдын төсвийн нийт зарлага нь 2011 оныг эс тооцвол ДНБ-ий 0.2-1.6 хувь, нэгдсэн төсвийн нийт зарлагын 0.8-4.2 хувь, улсын төсвийн зарлагын 1.1-5.5 хувийг тус тус эзэлж байна. ХХААХҮ-ийн сайдын төсвийн нийт зарлага 2011 онд бусад жилүүдтэй харьцуулахад огцом өндөр буюу ДНБ-ий 4.7 хувь, нэгдсэн төсвийн зарлагын 10.3 хувь, улсын төсвийн зарлагын 14.2 хувь байсан бөгөөд энэ нь тухайн жилд ЖДҮ-ийг дэмжихэд зориулсан хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэр, ХАА-н бүтээгдэхүүний татаас, хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрт бусад жилүүдтэй харьцуулахад харьцангуй өндөр байсантай холбоотой.
7. Салбарын төсвийн нийт зарлагын бүтцийг сүүлийн 10 жилээр авч үзвэл салбарыг дэмжих чиглэлээр тухайн үеийн төр, засгийн бодлого, шийдвэрээс хамааран жилээс жилд ихээхэн өөрчлөгдөж ирсэн байна.
8. Салбарын төсвийн нийт хэмжээ болон бүтэц нь сүүлийн 10 жилд татаас, урсгал шилжүүлэг, эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлээс голчлон хамаарч өсөж, буурсан дүр зураг харагдаж байна. Урсгал шилжүүлэгт ХАА-н бүтээгдэхүүний дэмжлэг, урамшуулал гол дүнтэй байсан бол эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл бүхэлдээ ЖДҮ-т олгох хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэр, түүний эргэн төлөлтөөс бүрдэж байна.
9. ХХААХҮ-ийн салбарын төсвийн зарлагын бүтцийг эдийн засгийн ангилалаар авч үзвэл 2020 оны байдлаар нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 347.9 тэрбум төгрөг байгаа бөгөөд үүний 307.8 тэрбум төгрөг буюу 88.5 хувийг урсгал зардал, 20.5 тэрбум төгрөг буюу 5.9 хувийг хөрөнгийн зардал эзэлж байна. Эдгээр зардлуудын салбарын төсвийн нийт зарлагад эзлэх хувь 2010 оноос хойш ихээхэн өөрчлөгдөж ирсэн байна. Тухайлбал урсгал зардлын эзлэх хувь 2010 онд 62.9 хувийг эзэлж байсан бол 2011 онд 17.9 хувь болж буурсан ба 2020 оны байдлаар 94.1 хувийг эзэлж байна.
10. Төсвийн зарлагын эдийн засгийн ангилалаар урсгал зардалд бараа, үйлчилгээний зардал, татаас, урсгал шилжүүлэг орж байгаа бөгөөд сүүлийн 10 жилд ХХААХҮ-ийн салбарын нийт төсвийн зарлагын 17.9-94.1 хувийг урсгал зардал эзэлж байна. Тухайлбал 2011 онд урсгал зардал салбарын нийт төсвийн зардлын 17.9 хувийг эзэлж байсан бол 2020 онд 88.5 хувийг эзэлж, ихээхэн хэлбэлзэлтэй явж ирсэн нь харагдаж байна. 2020 онд урсгал шилжүүлгийн хэмжээ ихээхэн нэмэгдсэн нь УИХ, Засгийн газрын тогтоолоор малчдын орлого болон үндэсний үйлдвэрүүдийг дэмжих зорилгоор ноолуурын зах зээлийн суурь үнэ дээр 1 кг тутамд 20 000 /хорин мянган/ төгрөгийг буюу нийт 174.7 тэрбум төгрөгийн урамшууллыг малчин, мал бүхий иргэдэд мөнгөн шилжүүлэг хэлбэрээр олгосонтой холбоотой.



11. ХХААХҮ-ийн салбарын бараа, үйлчилгээний зардал сүүлийн 10 жилд дунджаар 49.6 тэрбум төгрөг байгаа бөгөөд 2012 онд хамгийн бага буюу 34.0 тэрбум төгрөг, 2020 онд хамгийн их буюу 73.4 тэрбум төгрөг байв. Татаасын хувьд сүүлийн 10 жилийн дундаж хэмжээ 46.6 тэрбум төгрөг байсан бол 2010 онд хамгийн бага буюу 12.6 тэрбум төгрөг, 2020 онд хамгийн их буюу 62.6 тэрбум төгрөгт хүрчээ.
12. Бараа, үйлчилгээний зардлын бүтцийг авч үзвэл 2020 оны байдлаар энэхүү зардлын 53.3 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, 18.4 хувийг норматив зардлууд, 15.6 хувийг цалин, хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал эзэлж байна. Эдгээр 3 төрлийн зардал нийт бараа, үйлчилгээний зардлын 87.3 хувийг эзэлж байна.
13. Төсвийн зарлагын эдийн засгийн ангилалаар татаас нь дотроо төрийн өмчит байгууллагад олгох татаас, хувийн хэвшлийн байгууллагад олгох татаасаас бүрдэх ба ХХААХҮ-ийн салбарын хувьд хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас дийлэнхийг бүрдүүлж байна. Энэхүү татаас нь арьс, шир, ноос, улаанбуудай, сүүний урамшуулал, мах бэлтгэлийн, ноолуурын, газар тариалан эрхлэгчдийн зээлийн хүүгийн татаасууд ордог.
14. Урамшууллын хэмжээ нь өнгөрсөн хугацаанд тогтвортой бус, өөрчлөгдөж ирсэн бөгөөд энэ нь байгаль, цаг уур болон бусад хүчин зүйлсээс шалтгаалан тухайн жилийн ХАА-н бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нийлүүлэлтийн хэмжээ хэлбэлзлэлтэй байснаас голчлон хамаарсан байна. ХАА-н урамшууллууд нь хөдөө аж ахуй эрхлэгчдийн орлогыг нэмэгдүүлэх, ХАА-н бүтээгдэхүүний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, дотоодын боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зэрэг олон зорилтуудыг хангахад чиглэгдэж байгаа ба энэ урамшууллын үр нөлөө, үр ашгийг тооцоход бэрхшээлтэй болгож байна.
15. ХХААХҮ-ийн салбарын төсвийн зардалд хөрөнгийн зардлын эзлэх хувь өнгөрсөн 10 жилд 5.9-42.6 хүртэл хувийг эзэлж байв. Тухайлбал 2012 онд хөрөнгийн зардал салбарын нийт төсвийн зардлын 42.6 хувь буюу 77.0 тэрбум төгрөг байсан бол 2020 онд салбарын нийт төсвийн зардлын 5.9 хувь буюу 20.5 тэрбум төгрөгийн дүнтэй байна. сүүлийн 10 жилд хөрөнгийн зардлын хэмжээ болон нийт салбарын төсвийн зардалд эзлэх хувь жилээс жилд харилцан адилгүй хуваарилагдаж ирсэн байна. ХХААХҮ-ийн салбарын төсвийн хөрөнгийн зардын дийлэнх хэсгийг барилга байгууламж болон стратегийн нөөц хөрөнгө эзэлж байна. Барилга байгууламжид малын уст цэг худаг гаргах зардал, газар тариалангийн бүтээгдэхүүний агуулах, харъяа байгууллагуудын барилга барих зэрэг нь гол хувийн жин эзэлж байна.
16. Сүүлийн 5 жилийн дунджаар авч үзэхэд ХХААХҮ-ийн салбарын төсвийн урсгал зардлын 19.5 хувийг Мал аж ахуйг хөгжүүлэх, 10.6 хувийг Газар тариалан хөгжүүлэх, 2.8 хувийг Хүнсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, 15.7 хувийг Хөнгөн үйлдвэрийг хөгжүүлэх, 11.1 хувийг Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээ, 24.0 хувийг ЖДҮ, үйлчилгээ хоршоог дэмжих, 16.1 хувийг Хөдөө аж ахуй, газар тариалан, аж үйлдвэрийн бодлого удирдлага, 0.1 хувийг Хөдөө аж ахуй, газар тариалан, аж үйлдвэрийн судалгаа шинжилгээний хөтөлбөрт тус тус зарцуулсан байна.
17. Төсвийн зориулалтаас харахад ХАА-н салбарын бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийг дэмжих урамшуулал болон мал эмнэлгийн үйлчилгээний зардал салбарын төсвийн 70 гаруй хувийг эзэлж байна. Тухайлбал 2021 оны батлагдсан төсвийг зориулалтын ангилалаар харахад нийт төсвийн 41.4 хувийг ХАА-н салбарын бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийг дэмжих урамшуулал, 32.7 хувийг мал эмнэлгийн бүх төрлийн үйлчилгээ, оношлогоо, судалгаа эзэлж байна. Бусад зориулалтын зардлууд тус бүр нийт зарлагын дүнд 5-аас



бага хувийг эзэлж байна.

18. ХХААХҮ-ийн салбарын улсын төсвийн зардлаар орон нутагт 21 аймаг, нийслэлийн хүнс, хөдөө аж ахуйн газар, мөн аймаг, нийслэлийн мал эмнэлгийн газар, түүний суман дахь тасгийн үйл ажиллагааны урсгал зардлыг санхүүжүүлж байна. Эдгээр зардлын ХХААХҮ-ийн салбарын улсын төсвийн нийт зардалд эзлэх дүн 2019 онд 12.5 хувь буюу 20.8 тэрбум төгрөг байсан бол 2020 онд 6.5 хувь буюу 22.6 тэрбум төгрөгт хүрсэн байна.
19. Орон нутгийн ХХААГ-ын урсгал зардлыг улсын төсвөөс санхүүжүүлж байгаа бол Мал эмнэлгийн газрын үйл ажиллагааны урсгал зардлыг улс болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж байна. Улсын төсөв болон орон нутгийн төсвөөс аль төрлийн зардлыг санхүүжүүлэхийг 2017 онд батлагдсан Малын генетик нөөцийн тухай хууль болон Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд тодорхойлон заасан байна.
20. Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай (ЗЗНДНТУТ) хууль 2020 оны 12-р сард шинэчлэгдэн батлагдсан бөгөөд 2022 оны 1 дүгээр сарын 1-нээс мөрдөхөөр хуульчилсан. Одоо мөрдөж буй Төсвийн тухай хуулиар орон нутгийн чиг үүргийг тодорхойлж байгаа бол дээрх ЗЗНДНТУТ хуулиар орон нутгийн чиг үүргийг тогтоож, Төсвийн тухай хуулиас орон нутгийн чиг үүргийг хасаж зохицуулахаар болсон байна.
21. ЗЗНДНТУТ хуульд зааснаар мал эмнэлгийн үйлчилгээний чиг үүргийг орон нутгийн чиг үүргээс хассан байна. Өөрөөр хэлбэл мал эмнэлгийн үйлчилгээтэй холбоотой бүхий л зардлыг улсын төсвөөс буюу ХХААХҮЯ-наас санхүүжүүлэхээр харагдаж байна. Нөгөө талаас Малын генетик нөөцийн тухай хууль, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд заасан мал эмнэлгийн үйлчилгээний тодорхой зардлуудыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх заасан тул эдгээр хуулиудыг уялдуулж, нийцүүлэх шаардлагатай. ЗЗНДНТУТ хуульд орон нутгийн чиг үүрэгт аймаг, нийслэлийн хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн хөтөлбөр, хэрэгжилтэд тавих хяналт гэсэн чиг үүргийн оруулсан байх бөгөөд үүнд аймаг, нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, сумдын хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэрлэл хариуцсан чиг үүргийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэгдэхээр тусгагдсан гэж ойлгогдохоор байна. Тиймээс энэ талаар 2022 оны төсвийн төсөл боловсруулахаас өмнө ХХААХҮЯ болон Сангийн яам хамтран улс, орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх чиг үүргийг нарийвчлан тодорхой болгох зүйтэй.
22. ХХААХҮ-ийн салбарт сүүлийн 5 жилд 260 орчим тэрбум төгрөгийн зээл, тусламжийг авч ашигласан байна. Салбарын зээл тусламжийн дийлэнх хэсгийг Хөдөө аж ахуйн дэд салбарт буюу мал аж ахуй, газар тариаланд авч ашигласан байна. Салбарын зээл, тусламжийн нэгдсэн мэдээлэл байхгүй байгаа ба цаашид мэдээллийн баазыг бий болгож тооцоо, судалгаанд бодит мэдээллийг ашиглах нь зүйтэй байна.
23. ХХААХҮЯ-наас ХХААХҮ-ийн салбарын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөг боловсруулж тус яамны сайдын 2021 оны А-28 тоот тушаалаар батлан хэрэгжүүлж байна. ХХААХҮ-ийн салбарын 2021-2024 оны стратеги төлөвлөгөө нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтууд, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээг салбарын түвшинд нарийвчилж тусган хэрэгжүүлэхэд чиглэгдсэн байна.
24. Салбарын стратеги төлөвлөгөөнд тус яамны хариуцах нийт 7 чиг үүргийн хүрээнд 23 зорилт дэвшүүлж, түүнийг хэрэгжүүлэх 73 арга хэмжээг заасан байх бөгөөд үр дүнгийн 95 шалгуур үзүүлэлтийг тусгажээ. Салбарын дунд хугацаанд хэрэгжүүлэх тэргүүлэх чиглэлийн дээр дурдсан 23 зорилтыг бүхэлдээ Засгийн газрын үйл ажиллагааны



хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан тус салбарт хамаарах зорилтууд байна. Өөрөөр хэлбэл Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр буюу дунд хугацааны хөтөлбөрийг салбарын түвшинд хэрэгжүүлэхээр бүрэн уялдуулж боловсруулсан стратеги төлөвлөгөө гэж үзэж болно.

25. Стратеги төлөвлөгөөнд үр дүнгийн нийт 83 шалгуур үзүүлэлт байгаа бол ТЕЗ-ийн 2021 онд хэрэгжүүлэх хөтөлбөрт 10 шалгуур үзүүлэлт байгаа бөгөөд эдгээрийн зөвхөн 2 нь ижил буюу харилцан уялдаатай гэж үзэж болохоор байна. ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн үр дүнгийн үзүүлэлтүүд сүүлийн 4 жилд төдийлөн өөрчлөгдөөгүй бөгөөд 15 байсан үзүүлэлтийн тоог сүүлийн 2 жилд бууруулж 10 болгон төсвийн хуулийн 1-р хавсралтаар батлуулсан байна.
26. Салбарын төсвийн төлөвлөлт хийхдээ урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгийн зорилго, зорилт, хууль заасан арга хэмжээ, эдгээрийн шалгуур үзүүлэлтүүдийг гарган, тооцоо судалгааны тайлбарыг хийсэн байна. Гэхдээ эдгээр шалгуур үзүүлэлтүүдийг дээр дурдсанчлан Төсвийн хуулийн 1-р хавсралтад тусгасан болон дунд хугацааны стратеги төлөвлөгөөний шалгуур үзүүлэлтүүд, ТХЗ-уудтай илүү уялдуулах шаардлагатай. Мөн шалгуур үзүүлэлтүүдийг сонгохдоо илүү үр дүнд чиглэсэн, аль болох хэмжиж болохуйц тооны болон чанарын шалгуур үзүүлэлтийг эрэмбэлж авч үзэх нь зүйтэй.
27. ТХЗ-ууд, түүний шалгуур үзүүлэлтүүдээс ХХААХҮЯ-ны бодлогын түвшинд хариуцах нийт 10 зорилт, 17 шалгуур үзүүлэлт байна. Тогтвортой хөгжлийн эдгээр 10 зорилтоос 7 нь салбарын стратеги төлөвлөгөөнд бүрэн уялдаж туссан, 3 нь бүрэн бус боловч тодорхой хэмжээнд туссан гэж үзэж болохоор байна. Огт тусгаагүй зорилт байхгүй болно.

Харин тус яамны бодлогын түвшинд хариуцах ТХЗ-ын нийт 17 шалгуур байгаа ба эдгээрээс салбарын стратеги төлөвлөгөө болон ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтүүдтэй ижил буюу уялдаатай шалгуур үзүүлэлт байхгүй байна. Иймд цаашид салбарын дунд хугацааны стратеги төлөвлөгөөг тодотгож ТХЗ-ууд болон Монгол улсын “Алсын хараа -2050”-ын зорилтуудын шалгуур үзүүлэлтүүдтэй аль болох уялдуулж, улмаар Төсвийн хуулийн 1-р хавсралтанд тусгагдах шалгуур үзүүлэлтүүдтэй нийцүүлэх нь зүйтэй.

28. Салбарын улсын төсвийн зарлагын зориулалтаас авч үзэхэд ХАА-н салбарын бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийг дэмжих урамшууллын зардал, Мал эмнэлгийн үйлчилгээ, оношлогоо, халдварт өвчнөөс урьдчилэн сэргийлэх арга хэмжээ, судалгааны зардал болон ЖДҮ-ийг дэмжих зээлийн санхүүжилтийн эх үүсвэрийн зардал нь хамгийн их дүнтэй 3 зардал болж байна. Эдгээр зардлуудын үр дүн, үр нөлөөг тооцоход дараах бэрхшээлүүд гарч байна. Үүнд тухайлбал ХАА-н урамшууллыг олгож буй зорилго, зорилт нь олон талтай байх бөгөөд энэ нь үр дүнг тооцох, аль нэгэн зорилго, зорилтыг салгаж тооцох боломжгүй байна. Иймд урамшууллын тогтолцоонд иж бүрэн үнэлгээ хийж, түүний зорилго, зорилтыг илүү тодорхой чиглэсэн үр дүнд хүргэх, хөдөө аж ахуйн салбарын бодлого, зохицуулалтанд зах зээлийн механизмийг үр дүнтэй ашиглах зүйтэй. Жишээ нь урамшууллын бодлогыг ХАА-н бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах эсвэл нийлүүлэлтийг нэмэгдүүлэх аль нэг чиглэлд тодорхой болгох нь зүйтэй гэж үзэж байна. Мөн салбарын хэрэгжүүлж буй хөтөлбөрүүдийн статистик, тоо мэдээллийн нэгдсэн баазыг системтэй сайжруулах шаардлагатай байна. Үүнд яамны бүтцийн нэгжүүд, сан, агентлагуудын бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт, боловсон хүчний шилжилт хөдөлгөөн тодорхой нөлөө үзүүлж байна.



29. УИХ-аас 2017 онд батласан Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулинд улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх мал эмнэлгийн үйлчилгээний зардлын норматив, улсын төсөвт байгууллагатай шууд гэрээ байгуулах хэлбэрээр эм, худалдан авах үнэ тарифыг төсөв, санхүүгийн болон мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батлахаар заасан. Мал эмнэлгийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, түүнд зарцуулж буй төсвийн зарлагын үр дүнг дээшлүүлэхийн тулд дээрх зардлын норматив, үнэ тарифыг судалгаанд үндэслэн бодитой тогтоож байх нь чухал ач холбогдолтой. Мал эмнэлгийн үйлчилгээ сайжирсанаар ХХААХҮ-ийн салбарт дэвшүүлсэн хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийн боловсруулалтын түвшинг ахиулах, дотоодын үйлдвэрлэл, экспортыг дэмжих, хүнсний аюулгүй байдал, хангамжийн түвшинг дээшлүүлэх зэрэг олон зорилтуудыг хангахад чухал ач холбогдолтой арга хэмжээ болно.
30. Мөн Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулинд Улсын төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн арга хэмжээний эдийн засгийн үр ашгийг тооцох судалгааг мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хийхээр заасан. Энэхүү судалгааг тогтмол хийж, гарсан үр дүн, дүгнэлтийг хэрэгжүүлэх нь нотолгоонд суурилсан төсвийн төлөвлөлтөнд чухал ач холбогдолтой.
31. Өнгөрсөн хугацаанд ЖДҮ-ийг хөгжүүлэх сангийн эх үүсвэрт зориулан гаргасан Засгийн газрын бондын эргэн төлөлтийг ААН, иргэдэд олгосон зээлийн эргэн төлөлтөөс бүрдүүлэн хийж ирсэн бөгөөд зээлийн эргэн төлөлт тасалдсан үед салбарын төсвийн өөрийн орлого бүрдэлт тасарч, энэ хэмжээгээр зарлага, санхүүжилтийн гүйцэтгэл доголдох тохиолдлууд гарч байна. ЖДҮ-ийг хөгжүүлэх, эдийн засгийг төрөлжүүлэх нь Засгийн газрын болон салбарын тэргүүлэх зорилт хэвээр байна. Хэдийгээр улсын хөгжилд чухал хувь нэмэртэй ч аль ч улс оронд ЖДҮ нь зах зээлийн үнэ ханш, эдийн засгийн мөчлөг, бүс нутгийн эдийн засаг, нийгмийн өөрчлөлтөнд өртөмтгий, эрсдэл өндөртэй, барьцаа хөрөнгө дутмаг, үйл ажиллагааны цар хүрээ бага тул санхүүгийн зах зээлээс хэрэгцээт санхүүжилтээ авахад бэрхшээлтэй байдаг. Иймд ЖДҮ-ийн санхүүжилтийн тогтолцоог урт хугацаанд тогтвортой үргэлжлүүлэх, зах зээлийн зарчимд нийцүүлэх, улс төрийн нөлөөнөөс ангид байлгах, хямд өртөгтэй санхүүгийн эх үүсвэр, ялангуяа урт хугацааны төслийн санхүүжилтийн эх үүсвэр, хүртээмжийг нэмэгдүүлэх шаардлага тулгарч байна.



## 5. Хавсралт

ХХААХҮ-ийн салбарт хэрэгжүүлж буй бодлого, хөтөлбөрүүдийн гол зорилтууд

Бодлого, хөтөлбөрийн нэр	Батлагдсан огноо	Хэрэгжих хугацаа	Гол агуулга, зорилтууд
“Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого	УИХ, 2020	2020-2050	<ul style="list-style-type: none"> <li>- Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшнийг нэмэгдүүлж, малын гаралтай бүтээгдэхүүний экспорт нэмэгдсэн байна.</li> <li>- Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, малын чанар, ашиг шимийг сайжруулах ажлыг эрчимжүүлэх замаар хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангаж, хүнсний бүтээгдэхүүний экспортын хэмжээг нэмэгдүүлнэ</li> <li>- Уламжлалт өв соёлыг хадгалсан бэлчээрийн аж ахуйг зонхилон, дэвшилтэт технологи, техник бүхий эрчимжсэн аж ахуйг хот суурин орчимд бүсчлэн хөгжүүлж, нөөцийг тогтвортой, зохистой ашиглан, ногоон эдийн засгийн чиг баримжаатай мал аж ахуйг хөгжүүлнэ.</li> </ul>
Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал -2030	УИХ, 2016	2016-2030	<ul style="list-style-type: none"> <li>- Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллагын хорио, цээрийн шаардлагад нийцсэн газар нутгийн эзлэх хэмжээг 2030 онд 60 хувьд хүргэх</li> <li>- Мал сүргийн тоо, төрлийн зохистой харьцааг бүрдүүлэх</li> <li>- Эрчимжсэн мал аж ахуйг түлхүү хөгжүүлж, мах, сүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн, түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлт, хадгалалт, тээвэрлэлтийн сүлжээг хөгжүүлнэ.</li> </ul>
Монгол улсын 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл	УИХ, 2020	2021-2025	<ul style="list-style-type: none"> <li>- гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр бүрэн хангана</li> <li>- Монгол малын махны ач тусыг олон улсад сурталчлан таниулж, махны экспортын хэмжээг нэмэгдүүлнэ.</li> <li>- бэлчээрийг усжуулах, худагжуулах ажлыг үргэлжлүүлэн малын бэлчээрийн нөөцийг нэмэгдүүлж, тогтвортой байдлыг хангана</li> <li>- малын чанар, ашиг шимийг сайжруулж, малын тоог чанарт шилжүүлж малын генийн санг хамгаалах, биотехнологийн ололтыг нэвтрүүлэх, эрчимжсэн мал аж ахуйн салбарын хөгжлийг дэмжинэ.</li> <li>- мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангах, нийтийн эрүүл мэндийг хамгаалах, худалдааны чөлөөт байдлыг дэмжинэ.</li> <li>- мал, малын гаралтай түүхий эдийг боловсруулах цогцолбор байгуулж, хөдөө аж ахуйн гаралтай бараа, бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлнэ.</li> </ul>
Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого	УИХ, 2015	2014-2025	<ul style="list-style-type: none"> <li>- ХАА-н ДНБ-ий 5 жилийн дундаж өсөлтийг 2020 онд 15, 2025 онд 20 хувьд хүргэх</li> <li>- Нийт төсөвт ХАА-н салбарын эзлэх хувийг 2020 онд 3, 2025 онд 4 хувьд хүргэх</li> <li>- Үйлдвэрийн аргаар бэлтгэсэн махны хэмжээг 2025 онд 200 мян.тн-д хүргэх</li> <li>- уламжлалт өв соёлыг хадгалсан, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон бэлчээрийн мал аж ахуйг зонхилон эрхэлж, хүн ам олноор суурьшсан хот, суурин газрын орчмын болон тариалангийн бүс нутагт ашиг шимийн чиглэлээр төрөлжсөн эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэх</li> </ul>

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН  
ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ШИНЖИЛГЭЭ**

				<ul style="list-style-type: none"> <li>- мал аж ахуйн үйлдвэрлэлийн бүтээмж, үр ашгийг нэмэгдүүлэх, эдийн засгийн эргэлтийг сайжруулах, үхэр, хонины аж ахуйг махны чиглэлээр эрчимтэй хөгжүүлж, махны экспортын нөөцийг нэмэгдүүлэх</li> <li>- мал эмнэлгийн үйлчилгээнд зах зээлийн эрэлт, шаардлагад нийцсэн дэвшилтэт хэлбэрийг нэвтрүүлэх</li> <li>- малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтэд төрөөс үзүүлэх дэмжлэгийг түүний чанар, аюулгүй байдалтай уялдуулах</li> </ul>
“Монгол малчин” үндэсний хөтөлбөр	ЗГ, 2020	2020-2024	<ul style="list-style-type: none"> <li>- Малчдыг мэдээллээр хангах, хөгжүүлэх, орон нутагтаа ая тухтай ажиллах, амьдрах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулах, бүтээмж, орлого, ашгийг нь өсгөх, тэдгээрийг чадавхжуулахад энэ хөтөлбөрийн зорилго оршино.</li> <li>- малчдыг мэдлэгжүүлэх, мэдээллээр хангах аян өрнүүлж, тэдгээрийн мэдлэг, туршлага, чадавхыг сайжруулах, хөгжүүлэх, малчдын залуу халааг бэлтгэх</li> <li>- мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоонд чанарын үнэлэмж бий болгох, нэмүү өртгийн сүлжээнд малчдын оролцоог идэвхжүүлэх</li> <li>- малчид, малчин өрхийн үйлдвэрлэлийн бүтээмж, нөөц ашиглалтыг нэмэгдүүлэх, орлого, ашгийг өсгөх, эдийн засгийн чадамжийг сайжруулах</li> <li>- малчдын хамтын хоршил, эко санаачилга, хөрөнгө оруулалтыг идэвхжүүлж, байгальд ээлтэй, хариуцлагатай мал аж ахуйг тогтвортой эрхлэхэд чиглэгдсэн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх</li> <li>- малчдын орон нутагтаа ая тухтай ажиллах, амьдрах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулахад бодлогын дэмжлэг үзүүлэх</li> </ul>	
“Малын эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр	ЗГ, 2018	2018-2021	<ul style="list-style-type: none"> <li>- Хөтөлбөрийн зорилго нь мал, амьтны гоц халдварт болон халдварт өвчин гарах, тархах шалтгаан нөхцөлийг хязгаарлан эрүүлжүүлэх арга хэмжээг цогцоор нь хэрэгжүүлж, халдварт өвчингүй тайван байдлаа дотооддоо болон гадаад оронд баталгаажуулан хадгалж, хүн амыг эрүүл, аюулгүй хүнсээр, боловсруулах үйлдвэрийг чанартай түүхий эдээр хангаж, мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг экспортлох боломжийг нэмэгдүүлэхэд оршино.</li> <li>- мал эмнэлгийн салбарын хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох</li> <li>- мал, амьтны гоц халдварт болон халдварт, шинэ болон дахин сэргэж байгаа өвчнийг эрт илрүүлэх тандалтыг өргөжүүлэх замаар өвчнийг хяналтад авч, халдварт өвчингүй тайван байдлыг лабораторийн шинжилгээний үр дүнг харгалзан бүс нутгаар баталгаажуулах;</li> <li>- мал, амьтны гоц халдварт, зооноз, шинэ болон дахин сэргэж байгаа халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг шинжлэх ухааны нотолгоо, тархвар зүйн судалгааг үндэслэн төлөвлөх замаар бүс нутгаар нь хяналтад авах;</li> <li>- мал, амьтны шилжилт хөдөлгөөний хяналтыг сайжруулах замаар гоц халдварт өвчин гарах, тархах шалтгаан, нөхцөлийг таслан зогсоох;</li> </ul>	



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН  
ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ШИНЖИЛГЭЭ

				<ul style="list-style-type: none"> <li>- мал эмнэлгийн байгууллагын мэргэжилтэн, малын эмч нарын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, малын эрүүл мэндийг хамгаалах үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх;</li> <li>- малчин, үйлдвэрлэгч, хэрэглэгчдийг мал, амьтны эрүүл мэнд, түүнтэй шууд холбогдох нийтийн эрүүл мэндийн талаарх мэдлэг, мэдээллээр хангаж, үр дүнг сурталчлан таниулах.</li> </ul>
Эрчимжсэн МАА-н хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр	ЗГ, 2018			<ul style="list-style-type: none"> <li>- Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих төрийн бодлогын хүрээнд мал аж ахуйн үйлдвэрлэлийг бүсчилж хөгжүүлэх, төрөлжүүлэн эрчимжүүлэх, төвлөрсөн хүн амын хүнсний хангамж, хүртээмжийг тогтворжуулах, малын гаралтай зарим нэр төрлийн бүтээгдэхүүний импортыг бууруулах, экспортыг дэмжих, эрчимжсэн аж ахуй эрхлэгчдийн ажлын байрыг хадгалах, нэмэгдүүлэх, тэдгээрийн хөрөнгө оруулалт, эдийн засгийн үр өгөөжийг сайжруулахад энэ хөтөлбөрийн зорилго оршино.</li> <li>- эрчимжсэн аж ахуйн үйл ажиллагааг бүсчилж, төрөлжүүлэн кластер, ложистикийн сүлжээний үйлчилгээг хөгжүүлэх;</li> <li>- мал, амьтны гаралтай зарим нэр төрлийн бүтээгдэхүүний импортыг бууруулах, экспортыг дэмжих, дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах;</li> <li>- гойд ашиг шимт үржлийн мал, амьтны тоог нэмэгдүүлж, хот суурингийн хүн амын хүнсний хэрэгцээний сүү, мах, өндөг, зөгийн бал болон бусад түүхий эд, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хангамжийг сайжруулах;</li> <li>- эрчимжсэн аж ахуйн техник, технологийн шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлж, бүтээмж, үр ашгийг нь нэмэгдүүлэх;</li> <li>- боловсруулах үйлдвэрт нийлүүлэх мах, сүүний улирлын хамаарлыг бууруулах, аюулгүй байдлыг бүртгэлээр баталгаажуулах;</li> <li>- эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн санаачилга, хөрөнгө оруулалтыг урт хугацааны хөнгөлттэй зээл, татварын бодлогоор дэмжих</li> <li>- эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн технологи, эдийн засгийн мэдлэгийг сайжруулах, чадавхжуулах.</li> </ul>
“Монгол экспорт” хөтөлбөр	ЗГ, 2018	2018-2022		<ul style="list-style-type: none"> <li>- Хөтөлбөрийн зорилго нь үйлдвэрлэл, экспортын таатай, тогтвортой орчинг бүрдүүлэх замаар уул уурхайн бус бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний экспортыг дэмжих, экспортын бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, худалдааг хөнгөвчлөх, экспортын зах зээлийн хүрээг тэлэх арга хэмжээг шат дараатай авч хэрэгжүүлж Монгол Улсын эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахад оршино.</li> <li>- ноос ноолуур, арьс шир, мах болон сүүн бүтээгдэхүүн, чацаргана, зөгийн бал, уламжлалт эм, эмийн түүхий эд зэрэг бүтээгдэхүүний стандартыг европын болон олон улсын стандартад нийцүүлэх</li> <li>- ноос, ноолуур, арьс шир, мах болон сүүн бүтээгдэхүүн, чацаргана, зөгийн бал, уламжлалт эм, эмийн бүтээгдэхүүн зэрэг экспортын чиг баримжаатай бүтээгдэхүүний шинжилгээ, сорилтын лабораторийн чадавхыг олон улсын жишигт хүргэх, энэ чиглэлийн лаборатори байгуулах, тохирлын гэрчилгээ олгох үйл ажиллагааг бүх түвшинд дэмжих</li> </ul>

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН  
ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ШИНЖИЛГЭЭ**

“Ноолуур” хөтөлбөр	ЗГ, 2018	2018-2021	<ul style="list-style-type: none"> <li>- Ноолуурын бүрэн боловсруулалтын түвшинг 60 хувьд хүргэж, байгаль орчинд ээлтэй эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлж, ноолууран бүтээгдэхүүний олон улсад өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.</li> <li>- ямааны үүлдэр угсаа болон түүхий эдийн бэлтгэл, ноолуурын чанарыг сайжруулах</li> </ul>
Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр-III	ЗГ, 2019	2019-2024	<ul style="list-style-type: none"> <li>- хоршоогоор дамжуулан түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлт, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээний оновчтой тогтолцоог бий болгох замаар орон нутгийн хөгжлийг дэмжих</li> <li>- хөдөө аж ахуйн биржээр дамжуулан худалдан борлуулсан түүхий эдэд татварын хөнгөлөлт үзүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх</li> <li>- малчид, мал бүхий иргэдийн үндэсний үйлдвэрт нийлүүлсэн болон биржээр борлуулсан бүтээгдэхүүний урамшууллыг хоршоогоор дамжуулж олгох талаар холбогдох эрх зүйн баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах</li> </ul>
ХХААХҮ-ийн салбарын стратеги төлөвлөгөө	ХХААХҮ-ийн сайд, 2021	2021-2024	<ul style="list-style-type: none"> <li>- Стратеги төлөвлөгөөний зорилго нь Хүнс, хөдөө аж ахуй, хүнс, хөнгөн үйлдвэрийн салбаруудын хөгжлийн хэтийн хандлага, 2021-2024 он хүртэлх хугацаанд баримтлах стратегийн бодлогын зорилт, үйл ажиллагааны хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний үндсэн чиглэлийг тогтооход оршино.</li> <li>- Бэлчээрийг усжуулах, худагжуулах ажлыг үргэлжлүүлэн малын бэлчээрийн нөөцийг нэмэгдүүлэх, тогтвортой байдлыг хангах, малын чанар, ашиг шимийг сайжруулж, малын тоог чанарт шилжүүлж малын генийн санг хамгаалах, биотехнологийн ололтыг нэвтрүүлэх, эрчимжсэн мал аж ахуйн салбарын хөгжлийг дэмжих</li> <li>- Мал аж ахуйг байгаль цаг уурын эрсдлээс хамгаалах, бэлэн байдлыг хангах, сумдад өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх, малчдыг өвс тэжээл нөөцлөх сүлжээг бий болгоно.</li> <li>- Мал эмнэлгийн тогтолцооны шинэчлэлийг төгөлдөржүүлж, халдварт, гоц халдварт өвчинтэй тэмцэх, гоц халдварт өвчингүй, тайван бүсийг баталгаажуулж, мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний экспортын боломжийг нээнэ.</li> <li>- Хөдөө аж ахуйн тээвэр, борлуулалтын логистикийн сүлжээг байгуулж, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн чанарын хяналт, баталгаажуулалтын оновчтой тогтолцоог бүрдүүлнэ.</li> <li>- Махны нөөц бүрдүүлэх</li> <li>- Мах, махан бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх</li> <li>- Түүхий сүүний нийлүүлэлтийг сэрүүний улиралд нэмэгдүүлэх</li> <li>- Эрчимжсэн мал аж ахуйг дэмжих, үйлдвэрлэл эрхлэгчдийн санаачлага, хөрөнгө оруулалтыг урт хугацааны хөнгөлөлттэй зээл, татварын бодлогоор дэмжих</li> <li>- Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд төрөөс олгох татаас, мөнгөн урамшууллын тогтолцоог бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн үр дүнтэй холбож боловсронгуй болгох</li> </ul>



## 6. НОМ ЗҮЙ

- “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ (2020)
- Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль (2019)
- Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль (2017)
- Малын генетик нөөцийн тухай хууль
- Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, УИХ (2020)
- Монгол Улсын дунд хугацааны (2020-2025) Тогтвортой хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэл (Тайлан III), ҮХГ, UNDP (2018)
- Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, УИХ (2020)
- Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Засгийн газар (2020)
- Монгол Улсын Статистикийн Эмхэтгэл-2019, 2020, ҮСХ, (2020, 2021)
- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль (2020)
- Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор батласан ХХААХҮ-ийн салбартай холбоотой журмууд
- Монгол улсын 2015-2021 оны төсвийн хуулиуд, УИХ, [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn)
- Монгол улсын Төсвийн тухай хууль (2011)
- Тариалангийн тухай хууль
- ҮАГ, “Монгол улсын эдийн засаг, нийгмийн 2020 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн биелэлт” Гүйцэтгэлийн аудитын тайлан, (2021)
- ҮСХ, Ажиллах хүчний судалгааны тайлан 2019, (2020)
- Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль, (2011)
- ХХААХҮ-ийн сайдын багцын төсвийн төлөвлөгөө ба гүйцэтгэл 2010-2020, ХХААХҮЯ
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын стратеги төлөвлөгөө: 2021-2024 он, ХХААХҮЯ (2021)
- Anwar Shah, Public Expenditure Analysis (2005)
- Caroline Vandierendonck, Public Spending Reviews: design, conduct, implementation, EU (2014)
- FAO of the UN, Rethinking public policy in agriculture-Lessons from distant and recent history (2009)
- JICA, Data Collection Survey for Agriculture and Livestock in Mongolia, Final report (2017)
- UNDP, Budgeting for the Sustainable Development Goals, Guidebook (2020)
- WB, Mongolia: Public Financial Management Performance Report (2015)
- WB, Practitioners’ Toolkit for Agriculture Public Expenditure Analysis (2011)
- WB, Mongolia Public Financial Management Performance Report (2015)
- WB, Review, Estimation and Analysis of Agricultural Subsidies in Mongolia (2014)



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН  
ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ШИНЖИЛГЭЭ





ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН  
ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ШИНЖИЛГЭЭ



